

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ДАХИН ЭРГЭЦҮҮЛЭН БОДОХ НЬ

Боловсрол бүх нийтийн баялаг уу?





МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ДАХИН ЭРГЭЦҮҮЛЭН БОДОХ НЬ

Боловсрол бүх нийтийн баялаг уу?

Энэхүү ном нь Creative Commons-ийн Зохиогчийн нэрийг дурьдах - Ижил нөхцөлөөр цааш дамжуулах (CC-BY-SA 3.0 IGO) лицензийн дагуу хэрэглэхэд нээлттэй байна. (<http://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/>).

Номын агуулгыг ашигласанаар, хэрэглэгч нь ЮНЕСКО-ийн Нээлттэй мэдээллийн сангийн ашиглалтын нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрөх ёстой (<http://www.unesco.org/open-access/terms-use-ccbysa-en>).



Энд ашигласан нэр, материалууд нь аль нэг улс орон, газар нутаг, хот дүүргийн болон хил хязгаарын тухай эрх зүйн байдлын талаар ЮНЕСКО-ийн үзэл бодлын илэрхийлэл биш болно.

Шинжээчдийн бүлгийн гишүүд энэ номонд орсон баримт, үзэл бодлыг илэрхийлсэн хэлбэр, түүний сонголтод хариуцлага хүлээнэ. Шинжээчдийн үзэл бодол ЮНЕСКО-ийн байр суурьтай адил байх шаардлагагүй бөгөөд байгууллагын хувьд ямар нэг үүрэг хүлээхгүй болно.

Номны англи нэр: *Rethinking Education: Towards a global common good?*

2015 онд, Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага (ЮНЕСКО) хэвлэн гаргав.

ISBN 978-92-3-100088-1, CC-BY-SA 3.0 IGO лицензийн дагуу хэрэглэхэд нээлттэй байна.

График зураг: ЮНЕСКО

Хавтасны зураг: @Shutterstock/Arhimedes

Орчуулсан: Б.Мөнххүж, Я.Гантөмөр

Орчуулгын редактор: Д.Бадарч, Н.Бэгз

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Ч.Болорчимэг

© ШУТИС Хэвлэлийн газар

2017

ISBN: 978999785716-3

Энэхүү ном нь ЮНЕСКО-гийн албан ёсны хэвлэл биш болно.

Мэндчилгээ

Сүүлийн хориод жилийн хугацаанд манай орны бүх шатны боловсролын салбарт өөрчлөлт шинэчлэл эрчимтэй явагдаж байна. Тухайлбал, боловсролын системд дэлхийн шилдэг тэргүүний арга, хэлбэрүүд, олон янзын туршилтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх талаар төрөөс ихээхэн анхаарал хандуулан боловсролын тогтолцоог дэлхийн нийтлэг системд ойртуулахад чиглэсэн үндэс суурийг тавьж, хөгжүүлэх талаар тодорхой ажлууд хийгдэж ирсэн билээ.

Бага дунд боловсролын хүрээнд Кембрижийн хөтөлбөр, техник мэргэжлийн түвшинд шинэ хөтөлбөрөөр мэргэжилтэй ажилчин бэлтгэх сургалт, дээд боловсролын түвшинд сургалтын зохион байгуулалтыг кредит системд шилжүүлэх хөтөлбөрийг шинэчлэх зэрэг олон жишээ дурьдаж болно.

Түүнчлэн боловсролын салбарт хийх хөрөнгө оруулалт харьцангуй нэмэгдэж, Мянганы сорилийн сан, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын тусламжийн байгууллагуудаас тодорхой хөтөлбөр хэрэгжүүлж, сургалтын орчин, техник хэрэгслийн хангамжийг сайжруулж ирлээ.

Нөгөө талаас, боловсролын салбарын бүх шатанд хувийн сектор хүчтэй түрж орж ирлээ. Гэвч эдгээр өөрчлөлт шинэчлэлийн хөтөлбөрийн ихэнх нь тэр бүр амжилтанд хүрч, манай орны хөрсөнд сууж чадахгүй байна. Мөн сургалтын чанарын түвшин буурч, боловсрол, хөдөлмөрийн зах зээлийн хоорондын харилцан шүтэлцээ алдагдаж, сургуулиар олгож байгаа мэдлэг чадвар амьдралын бодит хэрэгцээг хангахгүйд хүрэх зэрэг нөхцөл байдал байсаар байна.

Мэдээллийн технологийн эрчимтэй хөгжлийн үр дүнд мэдлэг, мэдээллийн хүртээмж эрс дээшилж, сургалтын нээлттэй нөөц материал, нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээлүүд бий болж, сургалтын арга барилыг өөрчлөн шинэчлэхэд шинэ боломж нээж байна. Сургалтын үйл ажиллагаанд багшийн гүйцэтгэх үүргийг шинээр тодорхойлж, шинэ нийгмийн иргэн төлөвшүүлэхэд тэдний үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай болсон.

Миний бие 2016 онд ЮНЕСКО-ийн Ерөнхий бага чуулганы хуралд оролцох Монголын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтаж, улмаар Боловсролын салбараас эрхлэн гаргасан

“Боловсролын тухай дахин эргэцүүлэн бодох нь” номын нээлтэд оролцох завшаан надад олдсон билээ. Тэр үеэс энэ ном бол манай боловсролын салбарт цаг үеэ олсон чухал ач холбогдолтой бүтээл болохыг ойлгож, олны хүртээл болгож, боловсролын талаар дахин эргэж эргэцүүлэн бодох хэлэлцүүлгийг өөрийн орны түвшинд явуулахаар төлөвлөсөн юм.

Үүний зэрэгцээгээр манай улсын боловсролын салбарт шийдэх асуудал олон байсаар байгаа өнөө үед санаа авах, шийдэл гаргахад чухал нөлөөлөл болно гэдгээр энэ номын үнэ цэнэ тодорхойлогдоно гэж бодож байна. Энэхүү бүтээл нь монголын боловсролын салбарыг цаашид хөгжүүлэх, дэлхийн хэмжээний чиг хандлагатай мөр зэрэгцүүлэх төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, улмаар өөрийн орны боловсролын системийг дэлхийн хэмжээнд хүргэхүйцээр өөрчлөн зохион байгуулахад чухал ач холбогдолтой.

Энэхүү номыг орчуулсан Б.Мөнххүж, Я.Гантөмөр болон түүнийг шүүн хянаж ариутгасан профессор Д.Бадарч, академич Н.Бэгз нарт талархлаа илэрхийлье.

“Боловсролын тухай дахин эргэцүүлэн бодох нь” бүтээл боловсролын төлөө санаа зовж явдаг хүн бүрийн ширээний ном болж ирээдүйн боловсролын талаар оюун ухаанаа уралдуулахад түлхэц өгөх гарын авлага болно гэдэгт итгэлтэй байна.



Б.Очирбат
ШУТИС-ийн Ректор

Өмнөх үг

21-р зуунд бидэнд ямар боловсрол хэрэгтэй вэ? Өөрчлөгдөж байгаа өнөөгийн нийгмийн шинэ нөхцөлд боловсролын зорилго юу байх вэ? Суралцах үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах вэ? Эдгээр асуултуудаас энэ номын санаа төрсөн юм.

ЮНЕСКО-оос хэвлэн гаргасан Эдгар Форийн “Хүн болохын тулд суралцах нь: Өнөөдөр ба маргаашийн боловсрол” (Faure Report, 1972), Жак Делорийн “Боловсрол: түүнд нуугдсан эрдэнэс” (Delors Report, 1996) гэсэн хоёр түүхэн ач холбогдол бүхий бүтээлийн үзэл санаанд тулгуурлан боловсролын талаар өнөөдөр нухацтай, өргөн хүрээнд дахин ярилцах хэрэгтэй гэсэн итгэл үнэмшил надад төрсөн юм.

Бид тайван бус цаг үед амьдрах боллоо. Дэлхийн хүн ам залуужиж, хүний эрх, хүний нэр төрийг эрхэмлэх хүсэл эрмэлзлэл өсөж байна. Нийгэм урьд өмнө байгаагүйгээр харилцан хамааралтай болж байна. Гэвч үл тэвчих үзэл, зөрчил мөргөлдөөн газар авсаар байна. Хүчний шинэ төвүүд бий болж, тэгш бус байдал улам гүнзгийрч, манай гараг ихээхэн дарамттай болжээ. Бүх нийтийг оролцуулсан, хүртээмжтэй, тогтвортой хөгжих өргөн боломжууд нээгдэж байгаа боловч шийдэгдээгүй ээдрээтэй асуудлууд ч гарч ирсээр байна.

Дэлхий ертөнцийн энэхүү өөрчлөлтийг дагаад боловсрол бас өөрчлөгдөх ёстой. Нийгмийн бүхий л салбарт гүн гүнзгий өөрчлөлт гарч байгаа учраас нийгэм, эдийн засагт өнөөдөр, тэр тусмаа маргааш хэрэгтэй байгаа ур чадвар, чадамжийг хөхүүлэн дэмждэг боловсролын шинэ хэлбэр шаардагдаж байна. Энэ нь унших, бичих, тоо бодох чадвартай болгохоос цаашлаад шударга ёс, нийгмийн тэгш байдал, эв нэгдлийн үзэл санаанд сургахад анхаарлаа хандуулах шаардлагатай гэсэн үг бөгөөд сурах орчин, суралцах шинэ хандлагад санаа тавих хэрэгтэй. Асар их ачаалал, дарамттай байгаа эх Дэлхий дээр хамтдаа амьдарч сурах нь боловсролын зорилго байх ёстой. Тогтвортой хөгжлийг нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн 3 талаас нь иж бүрэн авч үзэхэд дөхөм үзүүлэх, хүнийг дээдлэн хүндлэх, нэр төрийг нь эрхэмлэхэд тулгуурласан соёлын цагаан толгойд сургахад боловсрол чиглэх ёстой.

Энэ бол боловсролыг бүх нийтийн эрхэм баялаг гэж үздэг хүмүүнлэг үзэл, чиг хандлагын илрэл юм. Боловсролыг ингэж харах нь 70 жилийн өмнө баталсан ЮНЕСКО-гийн дүрмийн үзэл санаанд бүрэн нийцэж байгаа бөгөөд шинэ эрин үеийн шинэ эрэлт хэрэгцээг тусгаж байгаа гэдэгт би бүрэн итгэж байна.

Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх нийтлэг хандлагыг олж тогтооход

боловсрол гол түлхүүр болох юм. Боловсрол бол бидний амьдарч байгаа Дэлхий ертөнцийг өөрчлөх, түүнд гарч буй өөрчлөлт, шинэчлэлд дасан зохицох талаарх бидний хүч чармайлтын гол үндэс юм. Эрч хурдтай өөрчлөгдөж байгаа өнөөгийн ээдрээтэй нийгэмд чанартай суурь боловсрол насан туршдаа суралцах зайлшгүй шаардлагын үндэс суурь нь юм.

Дэлхий даяар бүх нийтийн сурах боломжийг өргөжүүлэх тал дээр асар их дэвшил гарч байгааг бид харж байна. Харин цаашдын шинэ чиг хандлагыг тодорхойлохдоо урд өмнө хийсэн зүйлээсээ зөв сургамж авах ёстой. Боловсрол хүртээмжтэй байх явдал өнөөдөр хангалттай биш болж байна. Харин боловсролын чанар, сурч буй зүйл амьдралын хэрэгцээтэй хир нийцэж байгаа байдал болон хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид чухамдаа юу сурч байна гэдэгт анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй байна. Сургуулиар боловсрол олж авах, албан боловсролд хамрагдах нь зайлшгүй чухал боловч насан туршийн боловсролыг хөхүүлэн дэмжих талаар анхаарлаа хандуулах ёстой болж байна. Охидыг бага сургуульд элсүүлэх нь амин чухал асуудал, гэхдээ дунд сургууль болон түүнээс цааш суралцахад нь тэднийг дэмжиж туслах ёстой. Өөрчлөлтийн хөдөлгөгч хүч байх багш, сурган хүмүүжүүлэгч нарт урьд урьдаас илүү их анхаарал хандуулах хэрэгтэй.

Хүн төрөлхтний түгээмэл шинж чанар болох тэгш эрх, нийгмийн шударга ёс, соёлын олон төрлийг хүндэтгэх, олон улсын эв санааны нэгдэл ба хамтын хариуцлага дээр үндэслэсэн илүү сайхан ирээдүйг бий болгох, хүний эрх, нэр төрийг эрхэмлэх, ядуурлыг бууруулж тогтвортой байдлыг гүнзгийрүүлэх хүчтэй хөдөлгөх хүч боловсролоос өөр байхгүй.

Тийм ч учраас бид өнөөгийн өөрчлөгдөж буй нөхцөл байдалд боловсролын талаар өргөн хүрээнд эргэцүүлэн тунгааж, шинэ үзэл баримтлалыг дэвшүүлэх ёстой. Үүний тулд бүх хүрээнд оюун ухаанаа уралдуулж, мэтгэлцэх, харилцан ярилцлагыг өрнүүлэх хэрэгтэй. Энэхүү номын зорилго ч ирээдүйн боловсролын тухай яриа хөөрөөг хөхүүлэн дэмжих, урамшуулан зоригжуулахад оршиж байгаа юм.



Ирина Бокова
ЮНЕСКО-гийн ерөнхий захирал

Талархал

Олон улсын боловсрол ба хөгжлийн асуудлыг сонирхдог хэн бүхэн тогтвортой хөгжлийн зорилтын зүг рүү анхаарлаа төвлөрүүлж эхэлж буй түүхэн цаг үед энэ ном хэвлэгдэн гарсанд би их баяртай байна. Би дээхэн үеэс ЮНЕСКО-гийн ерөнхий захирал хатагтай Ирина Боковатай, тодруулбал, түүний бүрэн эрхийн эхний хугацааны үед санал солилцож байсны үр дүн нь энэ ном юм. Дэлхийн боловсролын ирээдүйн чиг хандлагыг тодорхойлохын тулд “Делорийн илтгэл”-ийг дахин эргэж авч үзэх санааг тэрээр ихэд дэмжсэн бөгөөд “Бүх нийтийн боловсрол” хөдөлгөөнийг дэлхийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл хэргийг зохион байгуулахад ЮНЕСКО тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байгаагийн дээр олон улсын боловсролд оюуны чухал манлайлагч гэдгийг харуулахыг зорьсон юм.

Энэхүү үзэл санааны үндсэн дээр өөрчлөгдөж буй дэлхий ертөнцийн өнөөгийн нөхцөл байдалд боловсролын үзэл баримтлалыг эргэн харах зорилго бүхий олон улсын нэр хүндтэй шинжээчдийн багийг ЮНЕСКО-гийн ерөнхий захирлын шийдвэрээр байгуулсан юм. Олон улсын шинжээчдийн энэ баг нь ирээдүйн боловсролын хэтийн зорилгын талаар өргөн хүрээтэй хэлэлцүүлгийг өрнүүлэх болон сурах үйл ажиллагааны зохион байгуулалтад нөлөө үзүүлэх асуудлуудыг тодорхойлсон товч баримт бичиг бэлтгэх үүрэгтэй ажилласан юм. Энэ багийг НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын 2015 оноос хойших хөгжлийн төлөвлөлт хариуцсан тусгай зөвлөх, ерөнхий нарийн бичгийн даргын орлогч хатагтай Амина Ж.Мохаммед, Их Британий Нэгдсэн Вант Улсын Ноттингамын их сургуулийн дэргэдэх ЮНЕСКО-гийн тэнхимийн профессор У. Жон Морган нар хамтран удирдсан юм.

Түүнээс гадна Энэтхэгийн Нью Дели дэх Хөгжиж байгаа нийгмийн судалгааны төвийн профессор, ноён Петер Роналд ДеСуза, Францын Парис дахь Сорбоны их сургуулийн профессор, ноён Жорж Хаддад; Ливан улсын Бейрут дахь Гэгээн Иосефын их сургуулийн дэргэдэх Улс төрийн шинжлэх ухааны хүрээлэнгийн хүндэт захирал, хатагтай Фадиа Киван; Эдюкэшн Интернэшнл (Education International) олон улсын байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга, ноён Фред ван Леувен; Японы Эрүүл мэнд, нийгмийн халамжийн олон улсын их сургуулийн профессор, ноён Тейчи Сато; Мексик улсын Боловсролын үнэлгээний үндэсний хүрээлэнгийн ерөнхийлөгч хатагтай Сильвия Шмелкес нар шинжээчдийн багт ажилласан юм.

Энэ төслийг хэрэгжүүлэхэд Ерөнхий захирал бүх талын дэмжлэгийг Боловсролын секторт үзүүлж байсан билээ. Боловсрол судлал, хэтийн төлөвлөлтийн багийн дэмжлэгээр шинжээчдийн баг Парист 2013 оны 2-р сар, 2014 оны 2-р сар, 2014 оны 12-р сард

тус тус уулзалт хийж, санал бодлоо солилцож, улмаар энэ номын анхны хувилбарыг ноороглогсон юм. Энэ завшааныг ашиглан олон улсын шинжээчдийн багийн бүх гишүүдэд энэ чухал хамтын бүтээлд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсанд талархал илэрхийлье. Тэдний хүчин чармайлт, хөдөлмөр зүтгэлд ЮНЕСКО-гийн Боловсролын секторын хамт олны нэрийн өмнөөс талархал илэрхийлж байна.

Гадны олон шинжээчид, ЮНЕСКО-д хамт ажилладаг олон нөхдүүдийн оролцоогүйгээр энэ ном бүтэхгүй байсан. Тухайлбал: Абдельжалил Аккари (Женевийн их сургууль), Массимо Амадио (ЮНЕСКО-гийн Боловсролын олон улсын товчоо), Дэвид Атчоарена (ЮНЕСКО-гийн Боловсролын бодлого ба насан туршийн боловсролын газар), Сильван Обри (Эдийн засаг, нийгэм, соёлын талаар хүний эрхийг хангах дэлхийн санаачилга байгууллага), Нежиб Айед (Боловсрол, соёл, шинжлэх ухааны Арабын орнуудын холбоо), Аарон Бенавот (Бүх нийтийн боловсролын мониторингийн илтгэл бэлтгэх баг), Марк Брэй (Хонгконгийн их сургууль), Арне Карлсен (ЮНЕСКО-гийн Насан туршийн боловсролын хүрээлэн), Мишел Картон (Боловсрол, сургалтын олон улсын бодлого, хамтын ажиллагааны сүлжээ), Борхене Чакрун (ЮНЕСКО-гийн Залуучууд, бичиг үсэг, ур чадварын хөгжлийн тасаг); Кай-минг Чэнг (Хонгконгийн их сургууль), Марен Элферт (Бритиш Колумбын их сургууль), Полен Ж.Унтонджи (Бенин улсын Боловсролын үндэсний зөвлөл), Клаус Хюфнер (Берлиний Чөлөөт их сургууль), Рут Кагиа (Хөгжилд хүргэх үр дүн олон улсын байгууллага), Тэуонг Канг (Өмнөд Солонгосын POSCO компаний судалгааны хүрээлэн), Мария Хан (Суурь болон насанд хүрэгчдийн боловсролын Ази, Номхон далайн орнуудын холбоо), Валери Лишти (Швейцарийн хөгжил хамтын ажиллагааны агентлаг), Кенди Лугас (ЮНЕСКО-гийн Боловсролын төлөвлөлтийн олон улсын хүрээлэн), Ян Макферсон (Нээлттэй нийгэм сан), Ролла Моумне Беулке (ЮНЕСКО-гийн Боловсролын бодлогын тасаг), Ренато Оперти (ЮНЕСКО-гийн Боловсролын олон улсын товчоо), Свейн Оствейт (ЮНЕСКО-гийн Боловсролын секторын захиргааны алба), Дэвид Пост (Бүх нийтийн боловсролын мониторингийн илтгэл бэлтгэх баг), Шелдон Шеффер (Сургуулийн өмнөх насны боловсрол, засаглалын мэргэжилтэн), Денис Синиоло (Эдьюкэшн Интернэшнл), Роза-Мария Торрес (Instituto Fronesis, Quito) нарт талархлаа илэрхийлж байна.

Эцэст нь, энэ төслийг амжилттай хэрэгжүүлсэн ЮНЕСКО-гийн Боловсрол судлал, хэтийн төлөвлөлтийн багийн хамт олонд талархаж байна. Энэ багийн дарга асан Жорж Хаддадийн удирдлага дор эхлүүлсэн энэ төслийг ахлах мэргэжилтэн Собхи Тавил үргэлжлүүлэн, номын эх бэлтгэх ажлыг удирдан явуулсан. Түүнд Италийн Бергамогийн их сургуулийн дэргэдэх Хүний эрх ба олон улсын хамтын ажиллагааны ёс зүйн чиглэлээр ажилладаг ЮНЕСКО-гийн тэнхимийн ажилтан Рита Локателли, Лука Солесен нар болон ЮНЕСКО-гийн мэргэжилтэн Хыонг Ле Тху тусалсныг дурдах хэрэгтэй. Мөн эрдэм шинжилгээний туслах ажилтан Мари Кугуре, Цзявэнь Ли, Джорджиана Мачука, Гильермо Нино Вальдеита, Виктор Нуис, Марион Путрель, Элен Веррю и Шань Ин нар оролцсон юм.



Кян Танг, доктор (PhD)
Боловсрол хариуцсан орлогч захирал

Гарчиг

МЭНДЧИЛГЭЭ	3
ӨМНӨХ ҮГ	5
ТАЛАРХАЛ	7
ЖИШЭЭ БАРИМТЫН ЖАГСААЛТ	10
ТОВЧ ХУРААНГУЙ	11
ОРШИЛ	12
1. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: ГОЛ АСУУДАЛ	22
Бэрхшээл ба зөрчил	22
Шинэ мэдлэгийн хүрээ	28
Альтернатив арга замыг эрэлхийлэх нь	30
2. БОЛОВСРОЛЫН ХҮМҮҮНЛЭГ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	36
Боловсролд хүмүүнлэгийн үүднээс хандах нь	37
Хүртээмжтэй боловсрол олгох нь	42
Боловсролын дүр төрхийн өөрчлөлт	47
Мэдлэгт суурилсан нийгэмд багшийн үүрэг	54
3. НАРИЙН ТӨВӨГТЭЙ БОЛЖ БҮЙ ӨНӨӨГИЙН НИЙГЭМД БОЛОВСРОЛЫН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ НЬ	58
Боловсрол, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний хоорондын өсөн нэмэгдэж буй зөрүү	58
Өнөөгийн хөдөлгөөнт орчинд сургалтыг хүлээн зөвшөөрөх, батламжлах нь	61
Олон өнгө төрхтэй, харилцан холбоотой дэлхийд иргэний боловсрол, хүмүүжлийн үзэл баримтлалыг эргэн харах нь	65
Дэлхийн түвшин дэх боловсролын засаглал ба үндэсний бодлого боловсруулах	67
4. БОЛОВСРОЛ ДЭЛХИЙ НИЙТИЙН БАЯЛАГ УУ?	72
Боловсролыг олон нийтийн баялаг гэж үзэх зарчим эргэлзээтэй байдалд орж байна	72
Боловсрол, мэдлэг бол дэлхий нийтийн баялаг мөн	77
Цаашдын алхмын талаарх эргэцүүлэл	82

Жишээ баримтын жагсаалт

1. Латин Америкийн орнуудад эдийн засаг тогтвортой өсч байгаа хэдий ч орлогын тэгш бус хуваарилалтын түвшин өндөр байна	25
2. Мэдлэгийн төрөл бүрийн системийн зөрчилдөөн	31
3. Sumac Kawsay: Хөгжлийн нэгэн альтернатив үзэл	33
4. Боловсролоор дамжуулан тогтвортой хөгжлийг дэмжих нь	33
5. Суурь, хөрвөх, техникийн болон мэргэжлийн чадвар	40
6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд анхаарал дутагдаж байдаг	43
7. Боловсролоос тусгаарлагдсан охины дуу хоолойг сонсох нь	44
8. Сенегал: “Бага насны хүүхдийн гэр” хөтөлбөрийн туршлага	45
9. Мексикийн соёл хоорондын харилцааны их сургуулиуд	46
10. ‘Ханан дахь цонх’ туршилт	49
11. Пакистаны охидод бичиг үсгийн боловсрол олгох хөдөлгөөнт сургалт	51
12. Дээд боловсролын уламжлалт хэлбэрийн дараах үе рүү шилжих зам	52
13. Финляндад багш нарыг өндөр түвшинд бэлтгэж, багшийн мэргэжил өндөр нэр хүндтэй байдаг	54
14. Залуучуудын хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэх нь	60
15. Бангалор, Хайдараб хот руу чиглэсэн эргэсэн нүүдэл	62
16. Египетэд ядуу гэр бүлийн боловсрол олж авах боломжид хувийн багшийн сургалт сөрөг нөлөө үзүүлж байна	75
17. Боловсрол эзэмших эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх, дагаж мөрдөх нь	76
18. Мэдлэгийг бүтээх, хянах, эзэмших, баталгаажуулах, хэрэглэх нь	80

Товч хураангуй

Өнөөдөр дэлхий дээр гарч байгаа өөрчлөлтүүд ээдрээтэй байдал, сөргөлдөөний цоо шинэ түвшингээрээ онцлог юм. Эдгээр өөрчлөлтүүд нийгэмд зөрчилтэй байдлыг үүсгэж байгаагийн дээр шинэ нөхцөл байдалд дасан зохицох, хариу арга хэмжээ авах чадварыг хувь хүмүүс болон нийгмийн тодорхой бүлэглэлд олгохыг боловсролоос хүлээж байна. Энэ ном нь боловсрол болон сурах үйл ажиллагааны талаар эргэцүүлэн бодож, дахин нэг эргэн харахад хувь нэмэр оруулах болно. ЮНЕСКО бол төрийн бодлогын асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх зорилго бүхий нийгмийн өөрчлөлтийг тандан ажиглах дэлхийн төв юм. Тиймээс уг номыг ЮНЕСКО-ийн энэхүү үндсэн зорилгод тулгуурлан бэлтгэсэн юм.

Энэ ном бол сонирхогч бүх талуудыг яриа хэлэлцээнд уриалсан дуудлага юм. Тогтвортой ирээдүйг бий болгохын тулд хүний амь нас, нэр төр, тэгш эрх, нийгмийн шударга ёс, соёлын олон төрөл, олон улсын эв санааны нэгдэл, хамтын хариуцлага зэргийг хүндэтгэхэд тулгуурласан хүмүүнлэг үзэл санааны дор энэ ном бэлтгэгдсэн. Эдгээр нь нийт хүн төрөлхтний хувьд нийтлэг зарчим юм. ЮНЕСКО-оос хэвлэн гаргасан Эдгар Форийн *“Хүн болохын тулд суралцах нь: Өнөөдөр ба маргаашийн боловсрол”* (Faure Report, 1972), Жак Делорийн *“Боловсрол: түүнд нуугдсан эрдэнэс”* (Delors Report, 1996) гэсэн хоёр түүхэн ач холбогдол бүхий бүтээлийн үзэл санааг энэ номонд цааш гүнзгийрүүлсэн болно.

Тогтвортой хөгжил: гол асуудал

Тогтвортой хөгжлийн төлөө бидний тэмүүлэл өнөөгийн нийтлэг асуудлууд болон зөрчлүүдийг шийдэх, ирээдүйг харж чадах чадвартай байхыг шаардаж байна. Эдийн засгийн өсөлт, баялгийн үйлдвэрлэл нь дэлхийн хэмжээнд ядуурлын түвшинг бууруулсан боловч эмзэг, тэгш бус байдал, гадуурхалт, хүчирхийлэл нийгмийн дотор ч, дэлхий дахинаа ч өсөн нэмэгдэж байна. Үйлдвэрлэл, хэрэглээний тогтворгүй, ухаалаг бус хөгжил нь дэлхийн дулаарал, байгаль орчны доройтолд хүргэж, улмаар байгалийн гамшиг нэмэгдэхэд ихээхэн нөлөөлж байна. Түүнчлэн, өнгөрсөн хэдэн арван жилд хүний эрхийн талаарх олон улсын тогтолцоо бэхжсэн ч эдгээр тогтсон хэм хэмжээг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх дээр бэрхшээлтэй тулгарсаар байна. Жишээлбэл, эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийг боловсрол олж авах хүртээмжийг нэмэгдүүлэх замаар өргөжүүлж байгаа ч нийгмийн амьдралд оролцох, ажил эрхлэхэд

тэднийг ялгаварлах байдал үргэлжилсээр байна. Эмэгтэйчүүд, хүүхэд ялангуяа охидын эсрэг хүчирхийлэл тэдний эрхийг ноцтой зөрчихөд хүргэсээр байна. Технологийн хөгжил нь бидний харилцан холбоотой байдлыг улам нэмэгдүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулан, харилцан солилцоо, хамтын ажиллагаа, эв санааны нэгдэлд цоо шинэ боломжийг нээж өгч байгаа боловч, соёлын ба шашны үл тэвчих үзэл, яс үндэс, үндсэрхэг үзлээс үүдэлтэй улс төрийн хөдөлгөөн, мөргөлдөөн өсөж байгааг бид харж байна.

Ертөнцийг үзэх олон ургальч үзэл, мэдлэгийн янз бүрийн систем, мөн нейро шинжлэх ухааны ололт дэвшил, тоон технологийн хөгжил зэрэг шинжлэх ухаан технологийн шинэ боломжийг харгалзан дээрх бэрхшээлүүдээс гарах хариу арга замыг олох ёстой. Боловсролын зорилго, суралцах үйл ажиллагааны зохион байгуулалтыг нухацтай, өргөн хүрээнд дахин ярилцах шаардлага урьд өмнө хэзээ ч ингэж тулгамдаж байгаагүй.

Боловсрол ба хүмүүнлэг хандлага

Хөгжлийн бүх асуудлыг боловсрол дангаараа шийдвэрлэж чадахгүй нь мэдээж. Харин боловсролд хүмүүнлэгийн үүднээс өвчөөр хандах нь хөгжлийн шинэ загварт хүрэхэд хувь нэмрээ оруулж чадах бөгөөд тэгэх ч ёстой юм. Ийм загварт, эдийн засгийн өсөлт нь энх тайван, хүртээмж, нийгмийн шударга ёсыг дээдлэх, байгаль орчныг хамгаалах асуудлыг юуны өмнө удирдлага болгох ёстой. Хөгжилд хүмүүнлэгийн үүднээс хандах ёс зүйн ба ёс суртахууны зарчмууд хүчирхийлэл, үл тэвчих, ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг зогсож байдаг. Боловсрол, суралцах үйл ажиллагаа хүний оршин байхын олон талыг нэгтгэн авч үзэхийн тулд явцуу утилитаризм, экономизмээс ангид байна гэсэн үг. Энэ арга зам бол эмэгтэйчүүд, охид, нутгийн уугуул иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, шилжин суурьшигчид, настангууд, мөргөлдөөнд нэрвэгдсэн улс орнуудад амьдарч байгаа хүмүүс зэрэг ялгаварлан гадуурхалтанд ихэвчлэн өртдөг хүмүүсийг нийгмийн харилцаанд татан оролцуулах асуудалд анхаарлаа хандуулахыг онцгой шаарддаг. Энэ бол насан туршийн болон амьдралын бүх хүрээг хамарсан суралцах үйл ажиллагаанд хүрэх нээлттэй бөгөөд уян хатан арга замыг шаардаж байна. Ийм хандлага хүн бүрд саруул ирээдүй, нэр төртэй амьдралын төлөө бүхий л чадавхи бололцоогоо дайчлах боломжийг өгдөг. Энэхүү хүмүүнлэг хандлага сургалтын агуулга, заах арга зүй болон багш, сурган хүмүүжүүлэгчдийн үүргийг дахин шинээр тодорхойлоход хүргэнэ. Энэ нь шинэ технологи, ялангуяа тоон технологийн хурдтай хөгжлийн эрин үед бүр ч илүү цаг үеэ олсон зүйл юм.

Өнөөгийн ээдрээтэй нөхцөлд үндэсний болон дэлхийн хэмжээний бодлого боловсруулах нь

Нийгэм, эдийн засгийн байдал улам бүр нарийн төвөгтэй, ээдрээтэй болж байгаа явдал өнөөгийн даяаршсан нийгэмд боловсролын бодлогыг тодорхойлоход олон тооны бэрхшээл учруулж байна. Эдийн засгийн даяаршил эрчимжсэнээс ажлын байрны тоо буурч, залуу насны хүмүүсийн ажилгүйдэл нэмэгдэж, ажил эрхлэлтийн баталгааг эмзэг байдалд хүргэж байна. Өнөөгийн эдгээр хандлага боловсрол болон байнга өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээл хоёрын хоорондын харилцан шүтэлцээ алдагдаж байгааг онцлон харуулахын зэрэгцээ боловсрол, нийгмийн хөгжлийн хоорондох уялдаа холбоог эргэж харах боломж гэж үзэж болохоор байна. Түүнчлэн суралцагчид ба ажил эрхлэгчдийн өсөн нэмэгдэж байгаа хил дамнасан шилжилт хөдөлгөөн, мэдлэг, чадварыг дамжуулах шинэ хэлбэрүүд сургалтыг хүлээн зөвшөөрөх,

батламжлах, үнэлгээ өгөх шинэ арга замыг шаардаж байна. Нийгэмд идэвхитэй иргэн бэлтгэх тал дээр үндэсний боловсролын системүүдийн өмнө тулгарч байгаа зорилт бол үндэсний мөн чанарыг төлөвшүүлэх, өөр хоорондоо илүү харилцан холбоотой, харилцан хамааралтай болж байгаа энэ дэлхийд бусдын төлөөх хариуцлагын тухай мэдрэмжээ нэмэгдүүлж, ухамсарлахыг дэмжих явдал юм.

Өнгөрсөн хэдэн арван жилийн турш дэлхий дахинаа боловсролын хүртээмж өргөжсөнөөр төрийн санхүүжилтэд илүү их дарамт үзүүлэх болж байна. Үүний зэрэгцээ, үндэсний ба дэлхийн хэмжээнд төрийн хэрэгт олон түмний дуу хоолойг сонсох, боловсролын салбарт төрийн бус сонирхогч талуудыг оролцуулах хэрэгцээ сүүлийн жилүүдэд өссөн. Хамтын ажиллагааны энэ олон хэлбэр улсын ба хувийн салбарын хоорондох хил хязгаарыг бүдгэрүүлж, боловсролын ардчилсан засаглалд шинэ асуудлуудыг үүсгэж байгаа юм. Товчоор хэлбэл, төр, нийгэм, зах зээл гэсэн нийгмийн төлөв байдлын гурван зохицуулагчийн хувь нэмэр, хэрэгцээг зохистой нийцүүлэх шаардлага нэмэгдэж байна.

Дэлхий нийтийн баялаг гэдэг утгаар боловсрол, мэдлэгийг авч үзэх нь

Хурдацтай өөрчлөгдөж буй өнөөгийн бодит байдлыг харгалзан боловсролын засаглалын удирдамж болохуйц тухайлбал, боловсрол эзэмших эрх, боловсрол бол нийгмийн баялаг болох зэрэг норматив зарчмуудын талаар бид эргэн харах хэрэгтэй болж байна. Үнэндээ, олон улсын хэмжээнд боловсролын тухай яриа хэлэлцүүлэг дээр боловсрол бол хүний эрх, нийгмийн баялаг болох тухай байнга ярьдаг. Суурь боловсролын түвшинд эдгээр зарчмуудын талаар маргаан бараг гардаггүй бол суурь боловсролын дараах түвшинд нэгдсэн тохиролцоонд хүрээгүй байгааг яриа хэлэлцүүлгээс харж болно. Боловсрол эзэмших эрхийн тухай болон боловсрол бол нийгмийн баялаг болох тухай зарчмыг албан бус болон насан туршийн боловсролд ямар хэмжээнд хэрэглэх тухай асуулт аяндаа гарч ирнэ. Учир нь албан бус болон насан туршийн боловсрол нь тогтсон зохион байгуулалт бараг байдаггүй.

Үүнтэй холбоотойгоор боловсролын зорилгын тухай аливаа яриа хэлэлцүүлгийн гол сэдэв нь мэдлэгийн тухай асуудал болж байдаг. Мэдлэгийг бид суралцах үйл ажиллагаагаар дамжуулан олж авсан мэдээлэл, ойлголт, чадвар, үнэт зүйлс, зан үйл гэж ойлгодог билээ.

Мэдлэг, боловсрол хоёрын аль алийг *нийтийн баялаг* гэж авч үзэхийг зохиогчид санал болгож байна. Өөрөөр хэлбэл, *нийгмийн хамтын хүчин чармайлтын* үр дүн гэсэн утгаараа мэдлэгийг бүтээх, түүнийг эзэмших, баталгаажуулах, хэрэглэх нь нийтийн баялаг байх ёстой гэсэн үг. Нийтийн баялаг гэсэн ойлголт нь “бүх нийтийн баялаг” гэсэн нийгэм, эдийн засгийн онолын тогтсон ойлголтын нөлөөнөөс гарч гүнзгий авч үзэх боломж олгож байна. Мэдлэгийн экосистем, сайн сайхан аж амьдралын тухай үзэл баримтлалууд болон түүнийг хэрэглэх хүрээний олон талт байдлыг харгалзан нийтийн баялаг гэж юу болохыг тодорхойлоход хамтын оролцоог онцолж байна. Мэдлэг бол хүн төрөлхтний нийтийн өвийн салшгүй нэг хэсэг юм. Харилцан хамаарал нь өсөн нэмэгдэж буй дэлхий дээр тогтвортой хөгжлийг хангах хэрэгцээг харгалзаж үзвэл, боловсрол, мэдлэгийг *дэлхий нийтийн баялаг* гэж үзэх ёстой. Хүн төрөлхтний язгуур үндэс болсон эв нэгдлийн тухай үзэл санаанд тулгуурлаж мэдлэг, боловсролыг дэлхий нийтийн баялаг гэж үзэх зарчим нь боловсролд оролцогч төрөл бүрийн сонирхогч талуудын үүрэг, хариуцлагад нөлөөлөх болно. Энэ нь боловсролын салбарт төрийн

бодлого боловсруулах талаарх дэлхийн хэмжээний яриа хэлэлцүүлгийг чиглүүлэх, дэмжих үүрэгтэй бөгөөд дэлхийн хэмжээнд эрх зүйн норм тогтоох, хэрэгжилтийг нь ажиглах үүрэгтэй ЮНЕСКО зэрэг олон улсын байгууллагад шууд хамааралтай.

Ирээдүйн талаарх эргэцүүлэл

Сурах үйл ажиллагааны зорилго ба зохион байгуулалтыг хамтын хүчин чармайлтаар эргэн харах гэж бид оролдлого хийж байна. Ийм яриа хэлэлцүүлэг өрнүүлэхэд хүргэх эхний алхам нь дараах асуултууд байж болох юм. Мэдэхийн тулд суралцах, хийхийн тулд суралцах, хүн болохын тулд суралцах, хамт амьдрахын тулд суралцах — гэсэн суралцахуйн дөрвөн тулгуур багана өнөөдөр ч гэсэн ач холбогдол өндөр хэвээр байгаа боловч даяаршил болон үндэс угсааны зарчим дээр суурилсан улс төрийн үйл ажиллагаа газар авснаар түүнийг аюулд оруулж байна. Суралцахуйн энэхүү дөрвөн тулгуур баганыг хэрхэн бэхжүүлж, шинэчилж болох вэ? Эдийн засаг, нийгэм, экологийн тогтвортой байдлыг хангахад гарах бэрхшээлүүдэд боловсрол хэрхэн үр дүнтэй хариу арга хэмжээ авч чадах вэ? Ертөнцийг үзэх олон ургальч үзэл нь боловсролд хандах хүмүүнлэг хандлагийн үндсэн дээр хэрхэн зохицуулагдах вэ? Ийм хүмүүнлэг хандлага нь боловсролын бодлого, практик арга хэмжээгээр хэрхэн хэрэгжих вэ? Боловсролын талаарх үндэсний бодлого боловсруулах, шийдвэр гаргахад даяаршил ямар үр дагаваруудтай байх вэ? Боловсролыг хэрхэн санхүүжүүлэх ёстой вэ? Багшийн боловсрол, давтан сургалт, хөгжил, тэдгээрийг дэмжихэд ямар тодорхой үр дагавартай вэ? Хувийн баялаг, нийгмийн баялаг, нийтийн баялаг гэсэн үзэл баримтлал хоорондын ялгаа боловсролд яаж тусах вэ?

Олон талын байр суурьтай төрөл бүрийн сонирхогч талуудыг судалгааны үр дүнгээ солилцох, бодлого боловсруулах удирдамжийн норматив зарчмуудыг тодорхой илэрхийлэхийн тулд тэдний хүчийг нэгтгэх хэрэгтэй. ЮНЕСКО бол оюун ухааны олон улсын төв бөгөөд ийм ярилцлага, хэлэлцүүлэг, маргаан явуулах талбар болж чадна. Ийм яриа хэлэлцүүлэг нь хүн төрөлхтөн, түүний сайн сайхан амьдралыг хангах зорилгоор боловсролын бодлого боловсруулах, боловсрол олгох шинэ арга замуудын тухай бидний ойлголтыг өргөжүүлэх юм.

Оршил



Оршил

“Боловсрол бол өөртөө итгэх итгэлтэй болгодог. Өөртөө итгэлтэй байх нь хүсэл, найдварыг төрүүлдэг. Хүсэл мөрөөдөлтэй байх нь энх тайвныг дэлгэрүүлнэ”

Күнз. Хятадын философич (МЭӨ 551 -479)

Яриа хэлэлцээнд уриалах нь

Нийгмийн өөрчлөлтийг ажиглах дэлхийн төв — ЮНЕСКО-ийн эрхэм зорилгод үндэслэн өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд боловсролын үзэл баримтлалыг шинээр тодорхойлоход энэ ном хувь нэмэр оруулах юм. Энэ номын зорилго нь өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөл байдалд боловсролын талаарх төрийн бодлогын тухай яриа хэлэлцүүлгийг өдөөж өрнүүлэхэд оршиж байна. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтний үндсэн утга учир болох хүний амь нас, нэр төрийг хүндэтгэн үзэх, тэгш эрх ба нийгмийн шударга ёс, соёлын олон төрлийг хүндэтгэх, олон улсын эв санааны нэгдэл, хамтын хариуцлагын тухай зарчмуудад үндэслэсэн, боловсрол болон хөгжлийн хүмүүнлэг үзэл санаагаар амьсгалсан яриа хэлэлцээнд уриалсан дуудлага юм. Энэхүү дуудлага боловсролын үйл ажиллагаанд оролцогч хэн бүхэнтэй шинэ цаг үеийн тухай ярилцах урам хайрлахын дээр гэгээрүүлж зоригжуулах зорилготой юм. ЮНЕСКО-оос хэвлэн гаргасан Эдгар Форийн “Хүн болохын тулд суралцах нь: Өнөөдөр ба маргаашийн боловсрол” (Faure Report, 1972), Жак Делорийн “Боловсрол: түүнд нуугдсан эрдэнэс” (Delors Report, 1996) гэсэн хоёр түүхэн ач холбогдол бүхий бүтээлийн үзэл санаанд тулгуурлан энэ номыг бүтээсэн.

Ирээдүйгээ төсөөлөхийн тулд өнгөрснөө эргэн харах нь¹

Бид өнгөрсөн үедээ хийсэн задлан шинжилгээний үр дүнд үндэслэн ирээдүйн боловсрол ба сурах үйл ажиллагааг төсөөлж, шинээр тодорхойлох ёстой. Жишээ нь уламжлалт боловсролын систем бэрхшээлтэй тулгарсан цаг үед суралцаж буй нийгэм, насан

1 Morgan, W. J. and White, I. 2013. Looking backward to see ahead: The Faure and Delors reports and the post-2015 development agenda. (Ирээдүйг харахын тулд эргэж нэг харах: Фор, Делорын илтгэл ба 2015 оноос хойших хөгжлийн хөтөлбөр) Zeitschrift Weiterbildung, No.4, pp.40-43-аас авав.

туршийн боловсрол гэсэн хоёр харилцан холбоотой ойлголтыг 1972 оны Форийн илтгэл гаргаж тавьсан. Технологийн дэвшил, нийгмийн өөрчлөлт хурдассанаар хүний олж авсан анхны боловсрол түүний амьдралынх нь туршид хангалттай гэж хүлээн зөвшөөрч болохгүй гэж энэ илтгэлд дурдсан байдаг. Сургууль бол зохион байгуулалттай мэдлэг олгох чухал хэрэглүүр хэвээр байхын зэрэгцээ нийгмийн амьдралын бусад хэсэг болох нийгмийн бүтцүүд, ажлын орчин, чөлөөт цаг, мэдээллийн хэрэгсэл зэргээр хүрээгээ тэлэх ёстой. Энэхүү илтгэлд хүн бүр хувийн, нийгмийн, эдийн засгийн, улс төрийн, соёлын талаар өөрийгөө хөгжүүлэхийн тулд сурч, боловсрох эрх болон хэрэгцээний талаар зөвлөсөн байдаг. Энэ илтгэлд насан туршийн боловсролыг хөгжиж байгаа болон хөгжингүй орнуудын боловсролын бодлогын тулгын чулуу гэж тодорхойлсон².

1996 оны Делорийн илтгэл “насан туршийн боловсрол” болон суралцах үйл ажиллагааны дөрвөн тулгуур багана “мэдэхийн тулд, хийхийн тулд, хүн болохын тулд, хамт амьдрахын тулд” гэсэн гол үзэл баримтлалд тулгуурласан боловсролын нэгдсэн үзэл санааг дэвшүүлсэн. Энэ илтгэл боловсролын салбарт шинэчлэл хийх төсөл хөтөлбөр биш байсан бөгөөд харин боловсролын бодлогыг боловсруулахад ямар сонголтууд хийх хэрэгтэй тухай эрэгцүүлэн тунгааж, санал бодлоо илэрхийлэх, маргалдан хэлэлцэх үндэс болох зорилготой байсан. Бид ямар нийгэмд амьдрахыг хүсэж байгаагаас хамаарч боловсролын тухай сонголтууд тодорхойлогддог гэж илтгэлд үзсэн байна. Мөн боловсролын үндсэн үйл ажиллагаанаас гадна хүн төлөвшүүлэх асуудал бол боловсролын зорилгын чухал хэсэг болохыг онцгойлон авч үзсэн байна³. ЮНЕСКО-ийн үндэс болсон ёс суртахуун, оюун санааны зарчмуудтай нийцүүлэн Делорийн илтгэлийг бэлтгэсэн бөгөөд түүнд дурдсан дүн шинжилгээ, зөвлөмжүүд нь тухайн үед боловсролын шинэчлэлийн талаар хийгдсэн бусад судалгаануудтай харьцуулахад зах зээлд хөтлөгдсөн, арга зүйн гэхээсээ илүү хүмүүнлэг шинжтэй бүтээл болсон юм⁴.

Дэлхий дахины боловсролын салбарын бодлогод Форийн болон Делорийн илтгэлүүд үзэл санааны нөлөө үзүүлсэн нь эргэлзээгүй бөгөөд дэлхийн хэмжээнд оюун санааны болон материаллаг талбарт 1970 оноос, дараа нь 1990-ээд оноос хойш зарчмын томоохон өөрчлөлтүүд гарсныг бид хүлээн зөвшөөрөх ёстой⁵. Хорин нэгдүгээр зууны хоёр дахь арван жил боловсрол, хөгжлийн хувьд шинэ сорилт, цоо шинэ боломжуудыг бий болгосон түүхэн үе болохыг харуулж байна. Нийгэм хоорондын харилцан холбоо, харилцан хамааралтай байдал болон ээдрээтэй төвөгтэй, тодорхойгүй, зөрчил тэмцэлтэй түүхэн шинэ үе шатанд бид орж байна.

Суралцах үйл ажиллагаанд тулгарч байгаа шинэ нөхцөл байдал

Өнөөгийн дэлхий ертөнц олон тооны санаанд оромгүй хачирхалтай үзэгдэл юмсаар

2 Medel-Aconuevo, C., Oshako, T. and Mauch, W. 2001. *Revisiting lifelong learning for the 21st Century*. (XX1 зуунд насан туршийн боловсролын үзэл баримтлалыг эргэж харах нь) Hamburg, UNESCO Institute for Education.

3 Power, C. N. 1997. Learning: a means or an end? A look at the Delors Report and its implications for educational renewal. (Боловсрол бол зорилго уу эсвэл хэрэгсэл үү? Дэлорын илтгэлийг дахин үзэх ба түүний Боловсролын шинэчлэлд үзүүлэх нөлөө) Prospects, Vol. XXVII, No.2, p.118.

4 Өмнөхийг үз

5 Tawil, S. And Cougoureux, M. 2013. *Revisiting Learning: The treasure within—Assessing the influence of the 1996 Delors report*. Суралцах үзэл баримтлалыг эргэцүүлэх нь: Боловсрол доторх эрдэнэс- Делорын илтгэлийн ая холбогдлыг үнэлэх Paris, UNESCO Education Research and Foresight, ERF Occasional Papers, No.4; Elfert, M. 2015. UNESCO, the Faure report, the Delors report, and the political utopia of lifelong learning. (Фоп ба Делорын илтгэл, насан турш сурах үзэл баримтлалын улс төрийн мөрөөдөл) *European Journal of Education*, 50.1, pp.88-100.

дүүрэн байна. Эдийн засгийн даяаршил эрчимжиж ядуурал дэлхийн хэмжээнд буурсан хэдий ч хөдөлмөр эрхлэлт буурч, залуучуудын ажилгүйдэл газар авч, тогтвортой биш ажлын байрны хэлбэрүүд бий болж байна. Эдийн засгийн даяаршил улс орны дотоодод болон улс орнуудын хооронд тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна. Боловсролын системүүд эмзэг бүлгийн болон ядуу орнуудад амьдарч буй суралцагчдын боловсролын хэрэгцээг үл хайхрахын зэрэгцээ хүн амын чинээлэг давхаргынхны боловсрол олох боломжид анхаарлаа хандуулж, дээд зэргийн чанартай боловсролын хүртээмжийг хэт явцуу хүрээнд олгох болсноос тэгш бус байдлыг улам тэлж байна.

Хүн ам зүйн өсөлт, хотжилттой хосолсон эдийн засгийн өсөлт нь байгалийн үл сэргээгдэх баялгийг хорогдуулж, байгаль орчныг бохирдуулж, экологийн эргэлт буцалтгүй хохирол, уур амьсгалын өөрчлөлтөд хүргэж байна.

Түүнчлэн, соёлын олон төрөл (улс орны түүх уламжлал болон шилжин суурьших хөдөлгөөний үр дүнд бий болсон)-ийг хүлээн зөвшөөрөх хандлага нэмэгдэхийн зэрэгцээ соёлын болон шашнаар түрэмгийлсэн дээрэнгүй үзэл, үндэс угсаанаас үүдэлтэй улс төрийн хөдөлгөөн, хүчирхийлэл эрс ихсэж байгааг бид харж байна. Терроризм, мансууруулах бодистой холбоотой хүчирхийлэл ба дайн, улс орны дотоодын мөргөлдөөн, тэр ч бүү хэл гэр бүлийн дотоод зөрчил болон сургууль тойрсон зөрчил хүчирхийлэл өсөж байна. Хүчирхийллийн энэ олон хэлбэр нь хамтдаа амьдрах соёлыг төлөвшүүлж, түүний үнэ цэнийг ухуулан ойлгуулах талаар боловсролд асуулт тавьж байна. Эдгээр зөрчил, мөргөлдөөн, хямралаас болж бараг 30 сая хүүхэд суурь боловсрол эзэмших эрхээсээ хагацаж, хөгжлийн бодлогын гадна хоцорсон боловсролгүй насанд хүрэгчдийн бүхэл бүтэн ирээдүй үеийг бий болгож байна. Эдгээр асуудал нь хүмүүс бие биеэ харилцан ойлголцох, нийгмийг нэгдэх нягтрахад гол бэрхшээл болж байна.

Үүний зэрэгцээ, засаглалын өөрчлөгдөж буй нөхцөл байдалд үндэсний болон дэлхийн хэмжээний төрийн үйл хэрэгт оролцох гэсэн хүмүүсийн дуу хоолой улам нэмэгдэж байна. Интернэтийн холбоо, хөдөлгөөнт технологи, бусад тоон мэдээллийн хэрэгслийн гайхамшигт дэвшил, төрөөс олгох боловсролын хүртээмжийг ардчилж, хувийн хэвшлийн янз бүрийн хэлбэрийн сургалтыг бий болгосноор нийгмийн, иргэний болон улс төрийн үйл хэрэгт оролцох цар хүрээг өөрчилж байна. Үүнээс гадна ажилчид, суралцагчдын хил дамнасан, ажлын байр дамжсан болон сурах орчины хүрээнд шилжих хөдөлгөөн өссөн нь боловсролын бичиг баримт, цогц чадамжийг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, үнэлэх тухай дахин авч үзэх хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлж байгаа билээ.

Эдгээр өөрчлөлтүүд нь боловсролын салбарт тодорхой үр нөлөө үзүүлж байгаа бөгөөд суралцах үйл ажиллагааны хувьд шинэ нөхцөл байдал бий болж байгааг анхааруулж байна. Тэдгээрийн зарим нь боловсролын салбарын бодлогын талаар тодорхой арга хэмжээ авахыг шаардаж байгаа бус, харин шинэ нөхцөл байдал бий болсныг анхааруулж байна. Эдгээр өөрчлөлтүүд нь шинэ практик аргууд төдийгүй суралцах үйл ажиллагааны мөн чанар, хэтийн төлөв, хүний хөгжилд мэдлэг боловсролын

6 European Science Foundation. 2011. Responses to Environmental and Societal Challenges for our Unstable Earth (Манай тогтворгүй дэлхийн экологи, нийгмийн асуудалд анхаарах нь) (RESCUE). ESF Forward Look—ESF-COST 'Frontier of Science' joint initiative. Strasbourg/Brussels, European Science Foundation/European Cooperation in Science and Technology.

үүргийг ойлгох шинэ хандлагыг бас шаардаж байна. Нийгмийн өөрчлөлтийн энэхүү шинэ нөхцөл байдал боловсролын зорилго, суралцах үйл ажиллагааг эргэж харахыг биднээс шаардаж байна.

Мэдлэг, суралцах үйл ажиллагаа, боловсрол гэдгийг юу гэж ойлгох вэ?

Суралцах үйл ажиллагааны тухай аливаа яриа хэлэлцүүлгийн төвд мэдлэг байдаг. Мэдлэг гэдгийг нийгэм ба хувь хүмүүс түүний утга агуулгыг практик дээр хэрэглэх арга зам гэж ойлгож болно. Тиймээс мэдлэгийг суралцах үйл ажиллагаагаар дамжуулан олж авсан мэдээлэл, ойлголт, ур чадвар, үнэт зүйлсийн баримжаа, зан үйл гэж өргөн утгаар ойлгож болно. Мэдлэг бол түүнийг бүтээсэн, өлгийдсөн соёл, нийгэм, хүрээлэн буй орчин, байгууллагын нөхцөл байдалтай салшгүй холбоотой байдаг⁶.

Мэдлэг олж авах үйл ажиллагааг суралцах үйл ажиллагаа гэж ойлгоно. Нөгөө талаас, суралцах үйл ажиллагаа бол мэдлэг эзэмших үйл ажиллагааны үйл явц ба үр дүн болохын зэрэгцээ арга хэрэгсэл бас эцсийн зорилго, хувь хүний туршлага ба хамтын хүчин чармайлт юм. Суралцах үйл ажиллагаа бол тухайн нөхцөл байдлаар тодорхойлогдох олон талт бодит байдал юм. Ямар мэдлэг эзэмших, түүнийг юуны төлөө, хаана, хэзээ, хэрхэн хэрэглэх вэ? гэдэг бол хувь хүний болон нийгмийн хөгжлийн тулгуур асуудлууд юм.

Боловсрол гэдгийг урдаас бодож төлөвлөсөн, чиг зорилготой, зохион байгуулалттай суралцах үйл ажиллагаа гэж ойлгож болно. Албан ба албан бус боловсролын төрлүүд нь тодорхой хэмжээний албан ёсны зохион байгуулалтыг шаарддаг. Харин суралцах үйл ажиллагаа тэр тусмаа урдаас төлөвлөж, тодорхой хүсэл эрмэлзэлд хөтлөгдсөн байсан ч албан ёсны зохион байгуулалт бараг шаарддаггүй. Ийм чөлөөтэй суралцах үйл ажиллагаа нь албан ба албан бус боловсролыг бодвол дэг журам, зохион байгуулалт бараг байхгүйн дээр сурах үйл ажиллагаа ажлын байр (тухайлбал, дадлагажигчаар ажиллах явцад), хамт олны дунд, өдөр тутмын амьдрал дээр гэр бүлийн болон хамт олны зөвлөмж, өөрийн хүсэл эрмэлзэлд хөтлөгдөх замаар явагддаг⁷.

Ямар мэдлэг эзэмших, түүнийг юуны төлөө, хаана, хэзээ, хэрхэн хэрэглэх вэ? гэдэг бол хувь хүний болон нийгмийн хөгжлийн тулгуур асуудлууд юм.

Эцэст нь бид амьдралаас олон зүйлийг өөрийн ухамсраар бус, санамсаргүй сурдаг гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Энэхүү чөлөөтэй суралцах үйл ажиллагаа бол хүний нийгэмшлийн үйл явцтай салшгүй холбоотой юм. Гэсэн хэдий ч зөвхөн ухамсартай, зохион байгуулалттай суралцах үйл ажиллагааны талаар цаашдын бидний яриа хязгаарлагдана.

Номын бүтэц, агуулга

Хүний болон нийгмийн тогтвортой хөгжлийн гол асуудлыг үндэс болгон, номны

7 Өмнөхийг үз

эхний хэсэгт дэлхий дахины нийгмийн өөрчлөлтийн өнөөгийн үйл явц дахь зарим чиг хандлага, зөрчил ба сөргөлдөөн, түүний үр дүнд гарч ирж байгаа шинэ мэдлэгийн цар хүрээг танилцуулсан. Түүний зэрэгцээ энэ хэсэгт ертөнцийг үзэх үзэл ба мэдлэгийн системийн олон талт байдлыг хүлээн зөвшөөрөхийн дээр тэдгээрийг тогтвортой байлгах шаардлага, хүний сайн сайхан аж амьдралыг сайжруулах талаар шинэ хувилбар арга замыг эрэлхийлэх шаардлагыг онцолсон.

Хоёрдугаар хэсэгт ёс зүйн ба ёс суртахууны зарчим дээр үндэслэн боловсролд хүмүүнлэгийн үүднээс нэгдмэл байдлаар хандах шаардлагыг давтан бататгажээ. Мөн бүх нийтэд хүртээмжтэй байхын зэрэгцээ тэгш бус байдлыг нэмэгдүүлэхгүй байхад чиглэсэн боловсролын үйл ажиллагаа явуулахыг уриалсан байна. Боловсролыг бүхэлд нь хамарсан өөрчлөлтийн өнөөгийн нөхцөлд багш, сурган хүмүүжүүлэгчдийн гүйцэтгэх үүрэг нь идэвхигүй хүлээн зөвшөөрдөг сэтгэлгээнээс шүүмжлэлт сэтгэлгээ, бие даан эргэцүүлэн бодож дүгнэлт хийх чадварыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Дараагийн хэсэгт өнөөгийн ээдрээтэй нийгэмд боловсролын бодлого боловсруулах асуудлыг авч үзсэн. Үүнд, албан боловсрол ба ажил эрхлэлт хоорондын зөрүүтэй ялгааг хүлээн зөвшөөрч, зохих арга хэмжээг авах; улс орны хил хязгаар, мэргэжил хоорондын болон сурах орон зай дамнасан өсөн нэмэгдэж буй шилжилт хөдөлгөөний өнөөгийн нөхцөлд сургалтыг хүлээн зөвшөөрөх ба баталгаажуулах; нийт хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлс ба тэдний санааг зовоосон асуудлын олон ургальч байдлыг тэнцвэртэйгээр хүндэтгэн өнөөгийн даяаршсан нийгэмд иргэний боловсролын асуудлыг дахин авч үзэх зэрэг асуудлыг хамарсан болно. Эцэст нь, бид дэлхийн хэмжээний засаглалын боломжит хувилбаруудын нөхцөлд улс үндэсний түвшинд боловсролын үндэсний бодлого боловсруулах нарийн төвөгтэй асуудлыг авч үзлээ.

Дөрөвдүгээр хэсэгт боловсролын засаглалын тулгуур зарчмууд, тухайлбал сурч, боловсрох эрх, боловсрол нь бүх нийтийн баялаг болох тухай зарчмыг шинэ нөхцөл байдалд тодорхойлох шаардлагыг тайлбарласан болно. Энд мэдлэг болон түүнийг бүтээх, үнэлэх, эзэмших, баталгаажуулах, хэрэглэх аргуудын талаарх боловсролын бодлогод илүү их анхаарлаа хандуулахыг зөвлөжээ. Мөн боловсролын зохион байгуулалтын тулгуур зарчим, ялангуяа боловсрол бол бүх *нийтийн баялаг* болох тухай зарчмыг дахин тодорхойлох шаардлага байгааг гаргаж тавьсан. Боловсрол ба мэдлэг бол *дэлхий нийтийн баялаг* гэж авч үзэх нь өөрчлөгдөж буй өнөөгийн дэлхий ертөнцөд нийгмийн хамтын хүчин чармайлт болох суралцах үйл ажиллагааны зорилго, зохион байгуулалтыг орчин үетэй нь хөг нийлүүлэх чухал арга байж болохыг зөвлөсөн байна. Төгсгөлийн хэсэгт гол санаануудыг нэгтгэн дүгнээд, тодорхой асуултуудыг хойшдын хэлэлцүүлэгт зориулан толилуулсан болно.



1. Тогтвортой хөгжил: гол асуудал

1. Тогтвортой хөгжил: гол асуудал

“Бид өөрсдийгөө нэгэн том модны навчис гэж бодох ёстой бөгөөд тэр мод нь нийт хүн төрөлхтөн юм. Бид бусадгүйгээр, тэр модгүйгээр амьдарч чадахгүй.”

Пабло Казальс (Pablo Casals), Испанийн морин хийлч, удирдаач

Боловсролын зорилгыг эргэж харахдаа өнөөгийн гол асуудал болсон хүний болон нийгмийн тогтвортой хөгжлийг үзэл бодлынхоо үндэс болгосон юм. Тогтвортой байдал гэдгийг сайн сайхан ирээдүйн төлөө нийгэм, хувь хүмүүсийн хариуцлагатай үйл ажиллагаа гэж ойлгож байна. Ийм ирээдүйд нийгмийн шударга ёс, хүрээлэн буй орчныг дээдлэн хамгаалах замаар нийгэм эдийн засгийн хөгжил явагдах ёстой. Өнөөгийн харилцан холбоотой, харилцан хамааралтай болж байгаа дэлхий дээр гарч буй өөрчлөлтүүд нь нарийн төвөгтэй байдлыг гүнзгийрүүлж, зөрчил, ер бус үзэгдэл, цоо шинэ мэдлэг бий болгож байгааг бид анхаарах ёстой. Өөрчлөлтийн ийм хэв маяг нь ахиц дэвшил, хүний сайн сайхан амьдралд хүргэх арга замуудын хувилбарыг эрж хайх хүчин чармайлтыг шаардаж байна.

■ Бэрхшээл ба зөрчил

Делорийн илтгэлд технологи, эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөөс болж үүссэн олон зөрчлийг тодорхойлсон. Эдгээрт дэлхий нийтийн болон орон нутгийн, нийтлэг болон тухайн нөхцлийн, уламжлал болон орчин үеийн, оюун санааны болон материаллаг байдлын хоорондын ба урт хугацааны болон богино хугацааны шийдвэрүүдийн хоорондын зөрчлийг хамруулсан байна. Түүнээс гадна нэг талаас, өрсөлдөөн бий болгох хэрэгцээ ба эрх тэгш боломж олгох, нөгөө талаас, шинэ мэдлэг өргөжиж байгаа нөхцөл байдал болон түүнийг шингээх бидний чадавхийн хоорондын зөрчлүүдийг багтаасан. Эдгээр долоон зөрчил нь нийгмийн өөрчлөлтийн өнөөгийн хэм, цар хүрээг дүрслэн харахад чухал үүрэгтэй. Тэдний зарим нь шинэ утга санаатай болж, шинэ зөрчил дагуулж байна. Тухайлбал, эдийн засгийн өсөлт нь тэгш бус байдлыг нэмэгдүүлж, эмзэг давхаргыг тэлж, экологийн дарамтыг нэмэгдүүлж, үл тэвчих байдал, хүчирхийллийг газар авахад хүргэж байна. Эцэст нь, хүний эрхийн тал дээр ахиц дэвшил байгаа ч, нийтлэг хэм хэмжээг ажил хэрэг болгох тал дээр бэрхшээл тулгарсаар байна.

Экологийн дарамт ба үйлдвэрлэл, хэрэглээний эдийн засгийн тогтворгүй хэв маяг

Эдийн засгийн өсөлт бол яваандаа бүх нийтийн сайн сайхан аж амьдралын баталгаа болж чадах эерэг үр нөлөөг бий болгодог гэсэн ойлголтод суурилсан хөгжлийн зорилго бол өсөлтийг хангах явдал гэж ойлгож ирсэн. Гэсэн хэдий ч үйлдвэрлэл ба хэрэглээний тогтвортой бус хэв маяг нь эдийн засгийн өсөлтөд тулгуурласан хөгжлийн түгээмэл загварт гүнзгий зөрчил байгааг харуулж байна. Чөлөөт өсөлт, байгалийн баялгийн хэт ашиглалт, уур амьсгалын өөрчлөлт зэргийн үр дагавар байгалийн гай гамшиг нэмэгдэхэд хүргэж, ялангуяа ядуу орнуудыг ихээхэн эрсдэлд оруулж байна. Чухамдаа, ус болон бусад байгалийн амин чухал нөөц хомсдож, уур амьсгал өөрчлөгдөж, биологийн олон төрөл зүйл устаж байгаатай хүн төрөлхтөн нүүр тулж байгаа нөхцөлд тогтвортой байдлыг хангах нь хөгжлийн гол асуудал болж байна.

Хорьдугаар зууны сүүлийн хагаст (1960-2000), усны ашиглалт хоёр дахин, хүнсний үйлдвэрлэл ба хэрэглээ 2.5 дахин, модны хэрэглээ гурав дахин нэмэгдсэн. Энэ огцом өсөлт нь хүн амын өсөлттэй холбоотой байсан. Дэлхийн хүн ам 1950 онд 2.5 тэрбум байсан бол 2013 онд 7 тэрбум гаруй болж өсөн, хорьдугаар зууны хоёр дахь хагаст бараг 3 дахин нэмэгдсэн бол 2025 онд 8 тэрбум гаруй болж өсөх төлөвтэй байна⁸. 2030 он гэхэд хүнсний хэрэгцээ хамгийн багаар бодоход 35 хувиар, усны хэрэгцээ 40 хувиар, эрчим хүчний хэрэгцээ 50 хувиар өсөх тооцоо гарч байна⁹.

Түүнчлэн, анх удаагаа дэлхийн хүн амын хагасаас илүү нь хот суурин газар амьдрах болж байна. 2050 он гэхэд дэлхийн хүн амын гуравны хоёр буюу 6 тэрбум гаруй хүн хотод амьдрах юм¹⁰. Тэр үед дэлхийн хот суурин газрын хүн амын 80 хувь бөмбөрцгийн өмнөд хэсгийн том жижиг хотуудад төвлөрнө гэсэн тооцоо байна¹¹. Дундаж давхаргын хүмүүсийн амьжиргааны түвшин, хэрэглээ ба үйлдвэрлэлийн хэв маяг өөрчлөгдөн өргөжин тэлэхийн хамт хотын хүн ам өссөн явдал хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлтөнд сөрөг нөлөө үзүүлж, дэлхий дахинаа байгалийн гамшигын эрсдлийг нэмэгдүүлж байна¹². Эдгээр эрс өөрчлөлтүүд хүмүүсийн амьдрал, амьжиргаа, нийгмийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байна. Огт төлөвлөөгүй эсвэл тааруухан төлөвлөсөн хотжилт нь байгалийн гамшиг, уур амьсгалын аюултай нөхцөлд өртөх эрсдэл ихтэй. Хот суурин газрын урьд өмнө байгаагүй өсөлтийн хурдац

Харилцан холбоотой, харилцан хамааралтай болж байгаа өнөөдрийн дэлхий дээр гарч буй өөрчлөлтүүд нь нарийн төвөгтэй байдлыг гүнзгийрүүлж, зөрчил, ер бус үзэгдэл, цоо шинэ мэдлэг бий болгож байгааг бид анхаарах ёстой.

8 UN DESA. 2013. *World Population Prospects: The 2012 Revision*. (Дэлхийн хүн амын хэтийн төлөв) New York, United Nations. Бөмбөрцгийн өмнөд хэсгийн улс орнуудад хүн амын өсөлт харагдаж байгаа ба үргэлжилнэ. Тухайлбал, 1950 онд дэлхийн хүн амын 66% байсан бол 2010 онд 82% болжээ. 2050 он гэхэд 86%, 2100 он гэхэд 88%-д хүрэх тооцоо байна.

9 National Intelligence Council. 2012. *Global Trends 2030: Alternative worlds*. (2030 он хүртэлх дэлхийн чиг хандлага: альтернатив арга хэмжээ) Washington, DC, National Intelligence Council.

10 UN DESA. 2012. *World Urbanization Prospects: The 2011 Revision*. (Дэлхийн хотжилтийн ирээдүй) New York, United Nations.

11 UN-HABITAT. 2013. UN-HABITAT Global Activities Report 2013. *Our presence and partnerships*. (2013 оны үйл ажиллагааны тайлан. Хамтын ажиллагаа, бидний оролцоо) Nairobi, UN-HABITAT.

12 SPREAD Sustainable Lifestyle 2050. 2011. *Sustainable Lifestyle: Today's facts and Tomorrow's trends*. (Амьдралын тогтвортой хэв маяг: Өнөөгийн бодит байдал, маргаашийн хандлага) Amsterdam, SPREAD Sustainable Lifestyle 2050.

нь нийгэм, улс төр, соёл ба хүрээлэн буй орчны дэлхийн чиг хандлагыг тодорхойлох болж байна. Үүний үр дүнд тогтвортой хотжих үйл явц нь хорин нэгдүгээр зуунд дэлхий нийтэд тулгарч буй хамгийн тулгамдсан асуудлын нэг болоод байна¹³.

Насан туршийн боловсролын байр сууринаас авч үзэхэд орчин үеийн шаардлагад нийцсэн, уян хатан боловсролын боломжийг хангахад шаардагдах зохион байгуулалтын болон түншлэлийн асуудалд хүн амын өсөлт, хотжилтын эдгээр хэв маяг чухал үр нөлөө үзүүлдэг. 2050 он гэхэд нийт хүн амын дунд ахмад настны эзлэх хувь хоёр дахин өсөх төлөвтэй байгаа¹⁴ бөгөөд үүний хамт насанд хүрэгчдэд зориулсан төрөлжсөн боловсрол, сургалтын эрэлт хэрэгцээ өсөх төлөвтэй байна. Хөдөлмөрийн насны хүн амын тооцоолж буй өсөлтийг хангаж чадвал Африк тивд “хүн ам зүйн ашигтай байдал”¹⁵ бий болно. Ингэснээр насан туршдаа зохих боловсрол олж авах, сургалтанд хамрагдах боломжийг өргөтгөх шаардлага гарна.

Баялаг нэмэгдэхийн сацуу эмзэг, тэгш бус байдал өсөх нь

1990 оноос 2010 оны хооронд ядуурлын түвшин дэлхийн хэмжээнд хоёр дахин буурсан. Хэдийгээр 2008 онд дэлхий нийтийг санхүү, эдийн засгийн хямрал нөмөрсөн ч ядуурал ийнхүү буурсан нь зах зээлийн эдийн засаг төлөвшиж байгаа болон Африкийн олон улс оронд гарсан эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлын үр дүн юм. Хөгжиж буй орнууд дахь дундаж давхарга дараагийн 15-20 жилд мэдэгдэхүйц өргөжин тэлэх төлөвтэй байгаагийн дээр, Хятад, Энэтхэг зэрэг улсад өсөлт хамгийн хурдацтай байна¹⁶. Гэсэн хэдий ч хөгжлийн их хэмжээний ялгаа дэлхий даяар хадгалагдсаар байхын зэрэгцээ ядуурлын түвшин дэлхийн бүс нутгуудад харилцан адилгүй өөр өөр байх болно¹⁷.

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий тогтвортой өсөлт нь хөдөлмөр эрхлэлтийн шаардлагатай түвшин, хэрэгцээтэй ажлын байрны аль алиныг тэр бүр бий болгохгүй байна. Ажиллах хүчин өсөхийн зэрэгцээ хөдөлмөр эрхлэх боломж хангалттай хэмжээгээр нэмэгдэж чадахгүй байна. 2013 онд дэлхий дээр 200 гаруй сая хүн ажилгүй байсан ба дэлхийн хэмжээний ажилгүйдэл цаашдаа нэмэгдэх төлөвтэй байна. Зүүн Ази, Өмнөд Ази, Сахар орчмын Африк зэрэг бүс нутгуудад ажилгүйдэл өсөж, ажлын чанар бас буурч байна. Хөдөлмөр эрхлэлтийн тогтворгүй байдал нь нийт ажил эрхлэгчдийн бараг тэн хагасыг хамарч байгаагийн зэрэгцээ ядуурлын шугамаас доогуур эсвэл түүний ойролцоо түвшинд амьдарч байгаа ажилчдын тоог нэмэгдүүлж байна. Тогтвортой биш ажлын байртай хүмүүс тогтмол цалинтай ажилчдыг бодвол нийгмийн даатгалд огт хамрагдаагүй эсвэл хязгаарлагдмал хамрагдсан байхын зэрэгцээ найдвартай орлогын эх үүсвэргүй байх магадлалтай¹⁸.

Нийгмийн наад захын хамгаалал ихэнх улс орнуудад огт байхгүй байгаа нь дээрх асуудлыг улам даамжруулж, дэлхийн бөмбөрцгийн хойд болон өмнөд хэсгийн улс

13 United Nations Human Settlement Programme, UN-Habitat, www.un-ngls.org/spip.php?page=article_fr_s&id_article=819 [2015 оны 2-р сард авав].

14 UNDESA. 2013. *World Population Prospects: The 2012 Revision*. (Дэлхийн хүн амын ирээдүй) New York, United Nations.

15 Drummond, P., Thakoor, V. and Yu, S. 2014. *Africa Rising: Harnessing the Demographic Dividend*. (Африкийн сэргэн босолт: Хүн ам зүйн давуу талыг ашиглах нь) IMF Working Paper 14/43. International Monetary Fund.

16 National Intelligence Council. 2012. *Global Trends 2030: Alternative worlds*. (2030 он хүртэлх дэлхийн чиг хандлага: альтернатив арга хэмжээ) Washington, DC, National Intelligence Council.

17 2010 онд Зүүн Ази, Номхон далайн орнуудад ядуурлын түвшин 12.5% байсан хэдий ч Өмнөд Азид 30% гаруй, Сахараас өмнөх Африкт 50% -д ойртсон байна. IMF and World Bank. 2013. *Global Monitoring Report 2013. Rural-Urban Dynamics and the Millennium Development Goals*. Washington, DC, International Bank for Reconstruction and Development and the World Bank.

орнуудын хооронд төдийгүй тэдний дотоодод тэгш бус байдал нэмэгдэхэд нөлөөлж байна¹⁹.

Өнгөрсөн 25 жилийн дотор дэлхийн эд баялаг хэдхэн хүмүүсийн гарт төвлөрлөө²⁰. Дэлхийн эд баялгийн бараг хагас хувь нь дэлхийн хүн амын хамгийн баян нэг хувьд, нөгөө хагас нь үлдэж байгаа 99 хувьд нь ноогдож байна гэсэн үг юм²¹. Ийм хурдтай өргөжин тэлж байгаа орлогын тэгш бус байдал нь нийгмийн гадуурхалд хүргэж, нийгмийн нэгдэл нягтралыг алдагдуулахад түлхэц болж байна. Аливаа нийгэмд тэгш бус байдал хэт ихсэх нь нийгмийн зөрчил, мөргөлдөөний эх үүсвэр болохын дээр улс төрийн тогтворгүй байдал, хэрцгий мөргөлдөөнд хүргэх ноцтой нөхцлийг бий болгодог.

1. Латин Америкийн орнуудад эдийн засаг тогтвортой өсч байгаа хэдий ч орлогын тэгш бус хуваарилалтын түвшин өндөр байна.

Сүүлийн арван жил Латин Америк, Карибийн тэнгисийн орнуудын эдийн засаг эрчимтэй хөгжиж, нийгмийн үзүүлэлтүүд нь сайжирсан боловч орлогын тэгш бус хуваарилалт хамгийн өндөр түвшинтэй бүс нутгийн нэг хэвээр байна. "Цалингийн эзлэх хувийн жин буурч байгаа нь хөдөлмөр хөнгөвчлөх технологийн өөрчлөлт шинэчлэл болон хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт, түүнийг хариуцсан байгууллагуудын нөлөө суларсантай холбоотой. Энэ бууралт нь орлогын хуваарилалтын дунд ба доод хэсэгт байдаг хувь хүмүүст харилцан ижил бус нөлөөлөх хандлагатай. Учир нь тэдгээр хүмүүс нь ихэнхдээ дан ганц хөдөлмөрийнхөө орлогод тулгуурлаж байдаг." гэж доорх тайланд дурдсан байна. Түүнчлэн "газрын тэгш бус хуваарилалт нь нийгэм, улс төрийн зөрчлүүдийг үүсгэхийн зэрэгцээ эдийн засгийн үр ашиггүй байдлын эх үүсвэр болдог. Учир нь жижиг газар эзэмшигчдэд бүтээмжээ нэмэгдүүлэхийн тулд зээл авах болон бусад нөөц боломж байнга хомс байдаг бол том газар эзэмшигчдэд энэ чиглэлээр ажиллах сонирхол хангалттай байдаггүй." гэж тайланд тэмдэглэжээ.

Эх сурвалж: UN Department of Economic and Social Affairs, 2013. *Inequality Matters. Report of the World Social Situation 2013*. New York, United Nations.

Харилцан холбоотой байдал нэмэгдсэн ч үл тэвчих үзэл, хүчирхийлэл өсч байна

Тоон шинэ технологийн хөгжлийн үр дүнд мэдээлэл, мэдлэгийн хэмжээг огцом өсөж, тэдгээрийг дэлхий дээрх олон тооны хүмүүст илүү хялбар хүртээмжтэй болгосон. Тухайлбал, мэдээлэл холбооны технологи бол тогтвортой хөгжлийг дэмжих, эв нэгдлийн үзэл санааг бэхжүүлэх үүднээс мэдлэг, туршлагаа харилцан хуваалцахад чухал үүрэг гүйцэтгэж чадна. Гэтэл олон ажиглагчдын үзэж байгаагаар ертөнцийг өрөөсгөлөөр үзэх үзлийг хөхүүлэн дэмжих зорилгоор мэдээлэл, холбооны технологиудыг үзэл суртлын болоод улс төрийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа учраас яс угсаа, соёл, шашнаас улбаатай үл тэвчих үзэл газар авч байна. Энэ нь цаашлаад гэмт хэргийн ба улс төрийн хүчирхийлэл, зэвсэгт мөргөлдөөнд хүргэж болно.

18 International Labour Office. 2014. *Global Employment Trends 2014*. (Ажил эрхлэлтийн дэлхийн хандлага) Geneva, International Labour Office.

19 UNDESA. 2013. *Inequality matters*. (Тэгш биш байдлын асуудалд) *Report on the World Social Situation 2013*. New York, United Nations.

20 World Economic Forum. 2014. *Outlook on the Global Agenda 2015*. (Дэлхийн хөтөлбөрийн үнэлгээ) Global Agenda Councils. pp.8-10.

21 Oxfam. 2014. Working for the Few: Political capture and economic inequality. (Цөөнхийн төлөө ажиллах нь: Улс төрийн хязгаарлалт, эдийн засгийн тэнцүү биш байдал) *Oxfam Briefing Paper No. 178*. Oxford, UK, Oxfam.

Зэвсэгт мөргөлдөөнөөс болж үүссэн үймээн самуун, дүрвэлт болон түүний дараах үеийн хямрал, тогтворгүй байдлын нөхцөлд эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэл ихсэх хандлагатай байдаг. Ийм нөхцөл байдалд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл газар авч, зэвсэгт бүлэглэлүүд хүчин, албадлагын биеэ үнэлэлт болон хүний наймааг байлдааны тактик болгон зохион байгуулалттай хэрэглэж байж болох юм²². Ийм нөхцөлд эмэгтэйчүүд улс орныхоо дотоодод нүүж шилжих сонирхолтой байдаг бөгөөд энэ нь тэдний эрүүл мэнд, боловсролд сөрөг үр дагавартай бөгөөд улмаар тэдний гэр бүл, үр хүүхдийн амьдралын нөхцөл байдалд шууд нөлөөлнө²³.

Хүчирхийлэл түүний дотор гэмт хэргийн хүчирхийлэл нь мансууруулах бодисын үйлдвэрлэл, наймаа (Төв Америк зэрэг дэлхийн тодорхой хэсэг дэх ноцтой асуудал болж байгаа), улс төрийн тогтворгүй байдал, зэвсэгт мөргөлдөөн зэрэгтэй холбоотойн дээр хүмүүсийн амьдралд аюул занал учруулж, нийгэм, эдийн засгийн хөгжилд саад болсоор байна²⁴. 500 сая хүн тогтворгүй байдал, мөргөлдөөний эрсдэлтэй улс орнуудад амьдарч байна гэсэн тооцоо байна²⁵. Дэлхий дээрх хүчирхийллийн үр дагаврыг арилгах, шийдвэрлэхэд ойролцоогоор 10 их наяд америк доллар болно гэж эдийн засгийн үүднээс тооцоолсон бөгөөд энэ нь дэлхийн ДНБ-ий 11 хувь буюу Африкийн орнуудын 2013 оны ДНБ-ийг нийлүүлснээс хоёр дахин их байна гэсэн үг юм²⁶. Цаашилбал, аюулгүй байдал, батлан хамгаалах зардалд зарцуулж буй улсын төсвийн хэсэг нь улс орны хөгжилд зарцуулах нөөцийг ихээр бууруулж байна. 2000 оноос хойш дэлхийн хэмжээнд цэргийн зардал байнга өссөөр байгаа бөгөөд 2012 онд 1742 тэрбум америк долларт хүрсэн ба²⁷ олон улс орон боловсролоос илүүтэйгээр цэргийн зардалд ДНБ-ийнхээ ихээхэн хувийг зориулж байна.

Энэ бүхэн нь боловсролын төрийн бодлогыг зөрчил, мөргөлдөөний асуудалд зохих мэдрэмжтэйгээр боловсруулах, хэрэгжүүлэхийг шаардана. Тэгш бус байдал, нийгмийн зөрчлийг дэвэрлэхгүй байхаар боловсролыг зохион байгуулахын тулд боловсролын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ бүхнийг оролцуулах шаардлагатай. Тэгш бус байдал, нийгмийн зөрчил нь хүчирхийлэл болон улс төрийн тогтворгүй байдалд хүргэж болно. Хүний эрхийн боловсрол бол зөрчил мөргөлдөөнд хүргэдэг шалтаг, шалтгаан болон тэдгээрийг шударгаар шийдвэрлэх аргуудын тухай ойлголтыг төлөвшүүлэхэд

22 UN Women. 2013. *A Transformative Stand-alone Goal on Achieving Gender Equality, Women's Rights and Women's Empowerment*. (Жендерийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрхийн баталгаажуулах, тэдгээрийн эрх, боломжийг өргөтгөх) New York, UN Women.

23 WorldBank. 2011. *World Development Report 2011: Conflict, Security and Development*. (2011 оны дэлхийн хөгжлийн тайлан: мөргөлдөөн, аюулгүй байдал, хөгжил) Washington, DC, The World Bank.

24 Мансууруулах бодисын гол зах зээл нь хөгжингүй орнууд боловч, тэдгээрийн үйлдвэрлэл, боловсруулалт, хууль бус худалдааг хөгжиж буй орнууд эрхэлдэг. Өссөөр байгаа энэ том зах зээлтэй хамт түүний үйлдвэрлэл бас өсөж байдаг. Өрсөлдөгч бүлэглэлүүд нутаг дэвсгэрт хяналтаа тогтоохын тулд дайтаж байдаг тул мансууруулах бодисын үйлдвэрлэл хүчирхийллийг дагуулж байдаг. Энэ үйлдвэрлэл нь их хүнд хөдөлмөр учраас түүнтэй холбоотой ажлыг мэргэжилгүй хүмүүс гүйцэтгэдэг байна. Олон улс оронд мансууруулах бодисын наймаанд голчлон өсвөр насны хүүхдүүд оролцдог. Тэд сургуулиа орхиж, илүү цалингийн хариуд өөрсдийн амь насгаа байнгын аюул дор байлгадаг. Мансууруулах бодисын үйлдвэрлэл ихээхэн хэмжээний газар нутгийг ихэвчлэн нутгийн хүн ам бүхий газрыг шаарддаг. Мансууруулах бодисын худалдаа нь бусад гэмт хэргийн тухайлбал, мөнгө салгах, хүний наймаа, бэлгийн боолчлол, барьцаалах гэх мэт ерөнхийдөө янз бүрийн газарт хувь хүний аюулгүй байдалд аюул занал учруулах үйл ажиллагаатай холбоотой байдаг. Төв Америкийн зарим орнууд, Мексик, Колумб, түүнчлэн Баруун Азийн зарим орнууд энэ гамшгийн хохирогчид юм. Энэ асуудлын шийдлийг одоо хүртэл олоогүй л байна.

25 Global Peace Index and Institute for Economics and Peace. 2014. *Global Peace Index 2014*. (Энх тайвны индекс) Institute for Economics and Peace.

26 Өмнөхөөс үз

27 Мэдээг АНУ-ын долларын ханшийг ашиглан тогтмол үнээр илэрхийллээ. SIPRI Database, www.sipri.org/research/armaments/milex [2015 оны 2-р сард авав].

28 Хүний эрхийн түгээмэл мөн чанар анх удаа 1948 онд Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал болон НҮБ-ын бусад конвенцуудад тусгалаа олж, гишүүн орнууд батламжилсан байна.

чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүчирхийлэл, хямралын нөхцөлд хүний амь нас, нэр төрийг хамгаалах, ялгаварлан гадуурхахгүй байх гол зарчмыг дэмжихэд ийм боловсрол чухал ач холбогдолтой юм. Энэ нь бүх нийтийг аюулгүй, хүчирхийлэлгүй, хүртээмжтэй ба үр дүнтэй суралцах орчноор хангах баталгааг шаарддаг.

Хүний эрх: Амжилт ба саад бэрхшээл

Хүний түгээмэл эрх гэдэг нь онцлог шинж, ялгаатай байдлаас үл хамааран хүний нэр төрийг хүндлэх, хүн өөрийгөө бүх талаар хөгжүүлэх бүхий л боломжоор хангагдах нийтлэг зорилго руу чиглэсэн хамтын хүсэл тэмүүлэл юм²⁹. Гэсэн хэдий ч, хүний эрхийн чиглэлээр батлагдсан олон улсын эрх зүйн хэм хэмжээ ба тэдгээрийг хэрэгжүүлж байгаа байдлын хооронд зөрүүтэй байдал ажиглагдаж байгаа нь эрх мэдэл, хууль болгон баталсан эрхийн хоорондох өсөн нэмэгдэж буй зөрчлөөр илэрдэг. Олон улсын болон үндэсний хэмжээнд хууль, шударга ёсыг дээдлэх журмыг тогтоох хүсэл эрмэлзэл эрх мэдэл бүхий сонирхолын бүлгүүдийн давамгайллын улмаас амжилтанд хүрээгүй жишээ нилээд бий. Хуулиа дээдлэх замаар болон нийгэм, соёл, ёс зүйн хэм хэмжээгээр дамжуулан хүний эрхийг хангах явдал бол өнөөгийн гол асуудал болж байна.

Жендерийн буюу хүйсийн асуудал нь ялгаварлан гадуурхалтын нэг чухал асуудал байсаар ирсэн. Өнгөрсөн хэдэн арван жилийн турш эмэгтэйчүүдийн эрх ялангуяа 1979 оны Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW)-ыг хэрэглэх болон Бээжингийн олон улсын бага хурлын (1995) үйл ажиллагааны хүрээний хэрэгжилтийг өргөжүүлэх хүчин чармайлтаар бэхжиж ирсэн. Хэдийгээр эрүүл мэнд, боловсролын хүртээмж дээр жендерийн эрх тэгш байдлыг хангахад ихээхэн ахиц гарсан боловч нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд эмэгтэйчүүдийн дуу хоолой, оролцоог нэмэгдүүлэхэд ахиц төдийлөн гараагүй байна²⁹. Туйлын ядуу нөхцөлд амьдарч байгаа хүмүүсийн дийлэнх нь эмэгтэйчүүд байна³⁰. Мөн тэд дэлхийн бичиг үсэгт тайлагдаагүй залуучууд, насанд хүрэгчдийн дийлэнхийг бүрдүүлж байна³¹. Түүнээс гадна, дэлхий даяар парламентад 20-иос бага хувийн суудлыг эмэгтэйчүүд эзэлж байна³². Ажил эрхлэлтийн боломжууд хумигдснаас ажлын байрны төлөөх ширүүн өрсөлдөөн газар авч байна. Мөн эдийн засаг, санхүүгийн шил дараалсан хямралын нөлөөнөөс болж хөдөлмөрийн зах зээл дэх, ялангуяа албан бус сектор дахь эмэгтэйчүүдийн нөхцөл байдал нь улам эгзэгтэй болж байна. Одоогоор хөдөлмөрлөж байгаа эмэгтэйчүүдийн тал хувь нь ажлын байрны аюулгүй байдал хангагдаагүй,

29 UN.2013.A New Global Partnership: Eradicate poverty and transform economies through sustainable development, (Шинэ түншлэл: Тогтвортой хөгжлийн замаар ядуурлыг бууруулж, эдийн засгийг өөрчлөх нь) Report of the High-level Panel of eminent persons on the post-2015 development agenda. New York, United Nations.

30 Өмнөхийг үз

31 UNESCO. 2014. *Teaching and Learning: Achieving quality for all. EFA Global Monitoring Report 2013-2014*. (Сурах ба сургах: бүх нийтээрээ чанарт хүрэх нь. Бүх нийтийн боловсролын хяналт үнэлгээний дэлхийн тайлан 2013-2014 он.) Paris, UNESCO.

32 UN Women. 2011. *Progress of the World's Women: In Pursuit of Justice*. (Эмэгтэйчүүдийн хувьд гарч буй дэвшил: шударга ёсны эрэлд) New York, UN Women.

33 ILO. 2012. *Global Employment Trends for Women*. (Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн хандлага) Geneva, ILO.

34 International Telecommunication Union. 2013. *Trends in Telecommunication Reform: Transnational aspects of regulation in a networked society*. (Цахилгаан холбооны шинэчлэлийн хандлага: Сүлжээний нийгэмд үндэстэн дамнасан удирдлагын асуудалд) Geneva, International Telecommunication Union.

35 ITU. 2013. *The world in 2014: Fact and Figures*. (Дэлхий 2014 онд: Тоо баримт) Geneva, ITU.

36 ITU. 2014. *Trends in Telecommunication Reform, Special Edition. Fourth-generation regulation*. (Цахилгаан холбооны шинэчлэлийн хандлага: Пөрөвдэх үеийн зохицуулалтын зарчмууд) Geneva, ITU.

37 Schmidt, E. and Cohen, J. 2013. *The New Digital Age: Reshaping the Future of People, Nations and Business*. (Тоон шинэ ертөнц: Хүний амьдрал, бизнесийн загвар, төрийн тухай ойлголтыг технологи хэрхэн өөрчилж байна вэ) New York, Knopf.

эдийн засгийн цочролын эсрэг хамгаалалт байхгүй эмзэг нөхцөлд хөдөлмөр эрхэлж байна³³. Энэ нь эмэгтэйчүүдийг цалин хөлс, мэргэжлийн талаар дэвшин ажиллах талаар ялгаварлан гадуурхах явдалд нэрмээс болж байна.

■ Шинэ мэдлэгийн хүрээ

Цахим ертөнц

Өнөөгийн хөгжлийг тодорхойлогч хүчин зүйлүүдийн нэг бол интернет холболтын өсөлт, хөдөлгөөнт холбооны тархалтаар тэтгэгдсэн цахим ертөнц юм³⁴. Өнөөдөр бид хоорондоо хэлхээ холбоо бүхий дэлхий дээр амьдарч байна. Барагцаагаар дэлхийн хүн амын 40 хувь нь интернет ашигладаг бөгөөд энэ тоо гайхамшигтай хурдтайгаар нэмэгдэж байна³⁵. Улс орнууд, бүс нутгуудын хооронд интернетийн холболт нэлээд ялгаатай байгаа боловч бөмбөрцгийн Өмнөд хэсэгт ийм холболттой өрхийн тоо бөмбөрцгийн Хойд хэсэгт амьдарч буй өрхийн тоог гүйцэж түрүүлсэн байна. Түүнээс гадна, дэлхий даяарх хөдөлгөөнт утас хэрэглэгчдийн 70 гаруй хувь нь бөмбөрцгийн Өмнөд хэсэгт байна³⁶. Дараагийн хорин жилийн дотор огт холбоогүй байсан таван тэрбум хүн бүрэн холболттой болох төлөвтэй байна³⁷. Гэсэн хэдий ч, улс орнууд болон бүс нутгуудын хооронд тухайлбал, хот, хөдөө орон нутгийн хоорондох зааг ялгаа их байна. Өргөн зурвасын холболт байхгүй, хязгаарлагдмал хурдтай зэрэг нь мэдлэг олж авахад, улмаар нийгэм, эдийн засгийн хөгжилд оролцоход саад болж байна.

Мэдээлэл, мэдлэг рүү нэвтрэх, хүмүүс хоорондоо харилцах, төрийн болон бизнесийн удирдлага зэрэг үйл ажиллагааг интернет эрс өөрчилж байна. Эрүүл мэнд, боловсрол, харилцаа холбоо, чөлөөт цаг, сайн сайхан амьдралд нааштай дэвшил авчрах найдлагыг өнөөгийн тоон холбоо төрүүлж байна³⁸. Хиймэл оюун ухааны дэвшил, 3D принтер, голограф зураглал, шуурхай бичлэг хийгч, дуу хоолой таних ба дохио зангаа таних программ хангамж зэрэг нь туршилтын шатанд яваа шинэ технологийн зарим нэг жишээ юм. Тоон технологи нь өдөр тутмын амьдралаас олон улсын харилцаа хүртэл, ажлаас чөлөөт цаг хүртэлх хүний үйл ажиллагааг цоо шинэ хэлбэрт оруулж, бидний хувийн ба олон нийтийн амьдралын олон талуудыг шинээр тодорхойлж байна.

Ийм технологиуд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, нийгэм, иргэний болон улс төрийн хөдөлгөөнд оролцох боломжийг өргөжүүлсэн хэдий ч онцгой анхаарах зүйлсийг бий болгож байна. Цахим ертөнц дэх хувийн мэдээллийн бусдад хүртээмжтэй байдал нь хувийн нууцлал, хүний аюулгүй байдлын талаар чухал асуудлуудыг бий болгож байна. Харилцаа холбоо, нийгэмшилтийн шинэ орон зай нь “нийгмийн” гэх нэр томъёоны доор ойлгож байгаа үзэл санааг өөрчлөн хувиргаж байгаа бөгөөд түүнийг хэтрүүлж, зүй бусаар болон буруугаар ашиглахаас сэргийлэхийн тулд хууль эрх зүйн ба бусад хамгаалалтыг шаарддаг³⁹. Интернет, хөдөлгөөнт технологи, социал медиаг буруугаар ашиглахын тод жишээ нь цахим сүрдүүлгээс эхлэн эрүүгийн гэмт хэргийн үйлдэл, алан хядах ажиллагааг хүртэл хамардаг. Энэхүү цахим ертөнцөд багш, сурган хүмүүжүүлэгчид зөвхөн өнөөдрийн бус, ойрын ирээдүйд зохион бүтээгдэх тоон технологиудтай харьцах ёс зүйн ба нийгмийн чадавхитай “тоон нийгмийн уугуул

38 Өмнөхөөс үз

39 Hart, A.D. and Hart Frejd, S. 2013. *The Digital Invasion: How Technology Is Shaping You and Your Relationships*. (Тоон эриний түрэмгийлэл: Технологи хэрхэн биднийг болон бидний хоорондын харилцааг өөрчилж байна вэ?) Ada, MI, Baker Books.

40 Prensky, M. 2001. *Digital Natives, Digital Immigrants. On the horizon*. (Тоон нийгмийн уугуул иргэд ба цагаачид. Хаяанд иржээ) MCB University Press, Vol.9, No. 5.

41 OECD 2007. *Understanding the brain: The birth of a learning science*. (Тархины зүй тогтол: сурганы ухаан төрсөн нь) Paris, EDUCERI-OECD.

иргэд"-ийн шинэ үеийг сайн бэлтгэх хэрэгтэй байна⁴⁰.

Нейро шинжлэх ухааны дэвшил

Биологийн процесс ба хүний сурах үйл ажиллагааны харилцан үйлчлэлийг илүүтэйгээр ойлгохыг эрэлхийлж буй боловсролын салбарынхны сонирхлыг нейро шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтууд ихээхэн татаж байна. Энэ ололтуудыг боловсролын бодлогод тусгахад магадгүй эртэдсэн байж болох ч, сургах ба сурах үйл явцыг сайжруулахад тэдний боломж нь ихээхэн найдлага төрүүлж байна. Жишээлбэл, хүний амьдралын янз бүрийн үе шатанд тархи хэрхэн хөгжиж, ажилладаг талаарх хамгийн сүүлийн үеийн шинэ соргог мэдлэг нь бидний хэдийд яаж сурдаг талаарх ойлголтыг гүнзгийрүүлж байна.

Сурах үйл ажиллагааны "мэдрэмтгий үе"-ийн талаар судалгааны гол гол бүтээлүүд анхаарлаа хандуулсан байдаг⁴¹. Тухайлбал, хэл сурах хамгийн оргил үе нь хүүхэд насанд байдаг. Энэ нь бага насны хүүхдийн боловсролын ач холбогдлыг онцгойлон чухалчилж, хүүхэд бага насандаа олон хэл сурах боломжтойг тэмдэглэж байна. Зарим судалгааны бүтээлүүд нь тархины "уян хатан байдал"-ыг онцлон авч үзэж, хүний тархи хүрээлэн буй орчны нөлөөний хариуд амьдралын туршид өөрчлөгдөх чадвартайг тодорхой харуулсан байна⁴². Эндээс үзэхэд насан турш суралцах үзэл санаа болон нас үл харгалзан бүх нийтийг сурах боломжоор хангах бодлого үндэслэлтэй болохыг бататгаж байна.

Үүний зэрэгцээ, тархины зохистой үйл ажиллагаанд хоолны шим тэжээл, нойр, спорт, амралт, чөлөөт цаг зэрэг орчны олон хүчин зүйл нөлөөлдгийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Үүнтэй нэгэн адил эрүүл бие бялдар ба оюун санааны хоорондын харилцан хамаарал, сэтгэл хөдлөл ба танин мэдэхүйн, задлан шинжлэх болон бүтээлч үйл ажиллагааны харилцан үйлчлэлийг таньж мэдэх иж бүрэн арга шаардлагатайг хүлээн зөвшөөрөх ёстой. Нейро шинжлэх ухааны судалгааны шинэ чиглэлүүд нь төрөхөөс заяасан ба олдмол (nature-nurture) шинж чанарын харилцан уялдааны тухай бидний ойлголтонд нэмэр болох бөгөөд түүнд нь боловсролын талаарх санаачлагуудаа илүү сайтар тааруулж тохируулахад бидэнд тус болох юм.

Уур амьсгалын өөрчлөлт ба эрчим хүчний альтернатив эх үүсвэр

Энэ зууны чухал сорилтуудын нэг бол уур амьсгалын өөрчлөлт мөн бөгөөд түүний эсрэг авах хариу арга хэмжээнүүд болон түүний сөрөг үр дагаварыг нь даван туулахад зайлшгүй шаардлагатай арга хэрэгслүүдийн талаас ч тодорхой болж байна. Уур амьсгалын хор хөнөөлийг бууруулах хүчин чармайлтууд нь хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, улмаар эх дэлхийгээ түүний цаашдын сөрөг үр дагавраас хамгаалах, байгаль орчны эмзэг байдлыг бууруулж, дасан зохицох, сөрөг үр нөлөөг даван туулах уян хатан чадварыг бий болгох зэрэг бүх талын зохион байгуулалттай оролцоо чухал болохыг уриалж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн хор хөнөөлийг бууруулах, түүнд дасан зохицохын тулд түүний талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хүмүүсийн хандлагыг өөрчлөхийг хөхүүлэн дэмжихэд боловсрол нэн тэргүүний үүрэг гүйцэтгэдэг⁴³.

42 Өмнөхөөс үз

43 Lutz, W., Muttarak, R. and Striessnig, E. 2014. Universal education is key to enhanced climate adaptation. (Бүх нийтийн боловсрол бол уур амьсгалын өөрчлөлтөд амжилттай дасан зохицох түлхүүр мөн) *Science*. 28 November 2014. Vol. 346, No. 6213. Education is key to climate adaptation. (Боловсрол бол уур амьсгалын өөрчлөлтөд амжилттай дасан зохицох түлхүүр мөн) www.iasa.ac.at/web/home/about/news/20141127-Science-Pop.html [Accessed February 2015].

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулж чадах нүүрстөрөгчийн бус альтернатив сэргээгдэх эх үүсвэрийг ашиглахад нийтээрээ шилжих хөдөлгөөнийг хөхүүлэн дэмжихэд боловсрол чухал үүрэгтэй. Нүүрстөрөгчөөс холдож нүүрстөрөгчийн бус эрчим хүчний эх үүсвэр рүү шилжилт хийхийн тулд итгэл үнэмшил, тогтсон ойлголтоо өөрчилж, энэхүү шилжилтэнд дэм болох оюун ухааны цогц ухагдахууныг шинээр суулгах хэрэгтэй юм. Эрчим хүчний дэд бүтэц өөрөө аяндаа ийм өөрчлөлтийг хийж чадахгүй юм.

Үүний зэрэгцээ хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн өөрчлөгдөж буй бодит нөхцөл байдалд амьдрал, амьжиргааны арга барилаа дасган зохицуулахад зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагаа өнөөгийн болон ирээдүй хойч үедээ дамжуулан гэдэг утгаараа боловсрол нь дасан зохицох чадавхийн нэг гол бүрэлдэхүүн хэсэг болж байдаг. 2014 онд Лимад болсон Сайд нарын зөвлөлгөөнөөс боловсрол, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх талаар гаргасан тунхаглал нь “үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан үндэсний хөгжлийн болон уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний стратеги, төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхдээ уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх асуудлыг тусгах улмаар уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг сургалтын хөтөлбөрт тусгасан боловсролын стратегийг боловсруулах”-ыг Засгийн газруудад уриалсан байна.

Бүтээлч чанар, соёлын инноваци ба залуучууд

Сүүлийн жилүүдэд соёлын илэрхийллийн шинэ хэлбэрүүд гарч ирсэн. Эдгээр нь дэлхийн хэмжээнд харилцаа холбоо өргөжиж, соёлын солилцоо нэмэгдснээс шалтгаалж бусад соёлын нөлөөнд тухайн соёлын түвшин дээшилсний үр дүн мөн. Энэ үйл явцын хөдөлгөх хүч нь залуучууд юм. Олон ургальч үзэл шингэсэн нийгмийн цоо шинэ гоо сайхныг харах болж байна. Хувцас загвараас эхлээд хоол хүнс, хөгжим, хувийн харилцаа хүртэл залуучуудын амьдралын бүхий л салбарт шинэчлэл хийх шинэ хүсэл сонирхолтой байнга тулгарч эхэллээ. Өнөөдөр дэлхий дээрх 15-аас 24 насны нэг тэрбум гаруй залуучууд урд өмнө байгаагүй хамгийн их мэдээлэлтэй, идэвхтэй, өөр хоорондоо холбоотой, хөдөлгөөнтэй шинэ үеийнхэн болж байна⁴⁴. Дэлхий дээрх 15-аас 24 насны залуучуудын 90 гаруй хувь нь өнөөдөр Facebook, Twitter зэрэг социал сүлжээний ямар нэг хэлбэрт нэгдсэн байна. Тэд нийгмийн сүлжээнд эрж хайх, түүнийхээ үр дүнг солилцох зэрэгт ихэнх цагаа зарцуулдаг. Энэ нь бусдын соёлын тухай илүү мэдээлэл, ойлголт авах орчинг бүрдүүлж, бусад мэдлэгийн системүүдийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрөхөд хүргэж, дэлхий дахины гоо зүйн асуудалд татан оролцуулах болжээ. Шинэ нээлт, инновацийн нэг эх сурвалж гэдгээрээ соёлын олон төрөл нь улам бүр ач холбогдолтой болж байна. Өнөөдөр соёлын энэ олон төрөл нь хүний тогтвортой хөгжилд үнэ цэнэтэй баялаг болж байна⁴⁵.

44 'Youth-support' (Залуучуудыг дэмжих нь) by Cherner Bah, Chair, Youth Advocacy Group for Global Education First Initiative (GEFI); Panel discussions: 'Enabling conditions for the delivery of quality global citizenship education: Where are we? Where do we want to go?' 'Global Citizenship Education: Enabling Conditions & Perspectives, (Дэлхийн иргэн бэлтгэх чанартай боловсрол явуулах нөхцлийг бүрдүүлэх нь: Одоо бид хаана байна? Цаашид хаашаа явах вэ? Дэлхийн иргэн бэлтгэх боловсрол: нөхцөл бүрдүүлэх ба ирээдүй) 16 May 2014, UNESCO, Paris. www.unesco.org/new/fileadmin/MULTIMEDIA/HQ/ED/pdf/Cherner-Bah_16May2014.pdf [2015 оны 2 сард ашигласан].

45 UNESCO. 2009. *UNESCO World Report Investing in Cultural Diversity and Intercultural Dialogue*. (ЮНЕСКО-ийн Дэлхийн тайлан. "Соёлын төрөл зүйл, соёл хоорондын харилцаанд хөрөнгө оруулах нь) Paris, UNESCO. <http://unesdoc.unesco.org/images/0018/001852/185202e.pdf> [2015 оны 2 сард ашигласан].

■ Альтернатив арга замыг эрэлхийлэх нь

Олон ургальч орчин дахь ертөнцийг үзэх янз бүрийн үзлийг хүлээн зөвшөөрөх нь

Орчин үеийн нийгмийн хөгжлийн олон янзын нарийн төвөгтэй загваруудтай нүүр тулж байгаа өнөө үед хүний нийгмийн хөгжил, дэвшил, сайн сайхан аж байдлыг хангах арга замуудын хувилбаруудыг эрж хайх нь чухал ач холбогдолтой юм. Бөмбөрцгийн хойд ба өмнөд хэсгийн аль алинд нь байгаа нийгмийн олон талт байдлыг онцлох нь чухал юм. Соёлын олон төрөл бол хүн төрөлхтний бүтээлч чанар, баялгийн агуу их эх булаг юм. Энэ нь ертөнцийг үзэх олон янзын арга замыг дагуулна. Цаашилбал бидний амьдралд шууд нөлөө үзүүлдэг асуудлуудыг шийдэх, байгалийн экосистем, нийгмийн бүлэг, хувь хүн, шашин, оюун санаа зэрэг хүний амьдралын тулгуур зүйлүүдийн үнэ цэнийг тодорхойлох зэрэг янз бүрийн хандлагыг хэрэглэх боломж бий болгодог. Түгээмэл үнэт зүйлсийг шүтэн дээдлэхийн дээр амьдрал дээр туулж мэдэрсэн бодит байдлын олон талт шинжийг хүлээн зөвшөөрөх ёстой. Энэхүү олон талт байдал нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх тодорхойлолт, хандлагыг боловсруулах асуудлыг түвэгтэй болгодог учраас эрүүл мэнд, боловсрол, орлогын талаар уламжлалт тоон үзүүлэлтээс цааш өргөн хүрээнд харах оролдлогыг бүх талаар дэмждэг. Харамсалтай нь, хүний сайн сайхан аж амьдралын тухай олон янзын үзэл баримтлалд байнга оршиж байдаг субъектив шинж ба нөхцөл байдал нь бодлого боловсруулах олон арга хандлагыг хагас дутуу, үр дүн муутай болгосоор байна⁴⁶.

Түгээмэл үнэт зүйлсийн нийтлэг үндсийг шүтэн дээдлэхийн дээр амьдрал дээр туулж мэдэрсэн бодит байдлын олон талт байдлыг хүлээн зөвшөөрөх ёстой.

2. Мэдлэгийн төрөл бүрийн системийн зөрчилдөөн

Бидэнд Европын соёл зөвхөн өөрийн мэдлэгтэйгээ ирээд зогсохгүй мөн өөрийн хурд давтамжтай ирсэн. Хэдийгээр бид түүнийг төгс эзэмшиж чадахгүй, түүнийг дагалдах гажуудал их гарч байгаа ч бидний оюун санааг уламжлалт хэвшмэл байдлаас нь сэргээж, бидний оюун ухааны уламжлалт сэтгэлгээнд эсэргүүцэл үзүүлэн гэрэл гэгээтэй сэхээрэлд хүргэж байна. Энэхүү гадны боловсрол нь манай үндэсний оюуны бүх орон зайг эзэлж, үнэний тухай мэдлэгийг шинээр нэгтгэх замаар оюун санааны цоо шинэ хүчийг бий болгох сайхан боломжийг устгана, саатуулна гэсэн зохиомол ойлголтыг би эсэргүүцдэг. Бид өөрсдийн соёлын бүх үнэт зүйлээ улам бэхжүүлж, барууны соёлыг эсэргүүцэх биш, харин сэтгэлээсээ хүлээн авч, түүнийг нутагшуулах, ачаа дарамт гэж үзэхгүй, түүнийг хүнс мэт хэрэглэх, тэр соёлыг гартаа оруулах, боловсролгүй хүмүүс шиг түүний захад амьдрахгүй байхыг уриалахад намайг хүргэсэн юм.

46 "Сайн сайхан амьдрал" гэдэг ойлголтын тухай олон улсын хэмжээнд ерөнхий нэг ойлголт байхгүй байгаа боловч, уламжлалт нийгэм-эдийн засгийн үзүүлэлтийн аргыг хэрэглэх нь хангалттай биш гэдгийг өнөөдөр нийтээр хүлээн зөвшөөрч байгаа. Сүүлийн үед НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр орлого, эрүүл мэнд, боловсролын түвшинтэй холбоотой үзүүлэлтүүдийг нэгтгэсэн Хүний хөгжлийн индексийн (ХХИ) хүрэнээсээ гарах болсон. Өсөн нэмэгдэж байгаа тэгш бус байдал болон жендерийн асуудлууд нь тэгш бус байдлын зохицуулалттай Хүний боломжийн хөгжлийн индекс, Жендерийн хөгжлийн индекс, Жендерийн тэгш бус байдлын индексийг боловсруулахад хүргээд байна. Хүний ахиц дэвшлийн маш явцуу ойлголтоос улбаалсан шалгуур үзүүлэлтээс гарах оролдлого нь дэлхийн түвшний нэгдэл, тогтвортой байдлын альтернатив хэмжүүрийг судлах зарим нэг санаачлагыг багтааж байна. Тухайлбал, НҮБ-ын Их сургуулийн дэвшүүлсэн Хүртээмжтэй Баялгийн индекс юм. Өөр бусад жишээ гэвэл: Сайхан амьдрал санаачлага (OECD); EDP: Байгаль орчны зохицуулалттай дотоодын цэвэр бүтээгдэхүүн (UNSEEA93); EPI: Байгаль орчны үр өгөөжийн индекс (Йелийн их сургууль); ESI: Байгаль орчны тогтвортой байдлын индекс (Йелийн их сургууль); GPI: Бодит ахицын үзүүлэлт (Ахицын тухай шинэ тодорхойлолт); Ногоон өсөлтийн үзүүлэлт (OECD); Бодит эдийн засаг (Pearce, Atkinson & Hamilton); HCI: Хүний капиталын индекс (Дэлхийн эдийн засгийн форум); ISEW: Тогтвортой эдийн засгийн байдал (Cobb & Daly); NNW: Үндэсний цэвэр баялаг (Японы засгийн газар); SDI: Тогтвортой хөгжлийн үзүүлэлт (Европын холбоо; Их Британийн засгийн газар).

Мэдлэгийн альтернатив системүүдийг нэгтгэх нь

**Мэдлэгийн
альтернатив
системүүдийг
үгүйсгэж, үл
ойшоох гэхээсээ
илүү хүлээн
зөвшөөрч,
зохиж ёсоор
тайлбарлах**

Мэдлэгийн давамгайлсан загвараас өөр альтернатив системүүдийг судлах ёстой. Мэдлэгийн альтернатив системүүдийг шууд үгүйсгэж, үл ойшоохоос илүүтэйгээр зохих ёсоор хүлээн зөвшөөрөх шаардлагатай юм. Ертөнцийг үзэх бусад үзэл баримтлалуудыг судалж ойлгоход илүү нээлттэй байснаар нийгэм хаана байрлаж байгаагаасаа үл хамааран бие биеэсээ маш ихийг сурч чадна. Нийгэм байгаль орчинтой харилцах харилцааны тухай дэлхийн өнцөг булан бүрд байгаа хөдөөгийн, тэр тусмаа нутгийн уугуул иргэдийн жишээн дээр маш их зүйлийг мэдэж авч болно. Дийлэнх уугуул иргэдийн соёлд эх дэлхийг ээж гэж үздэг. Тиймээс эх дэлхий ба түүний аливаа үр өгөөжийг амь өрссөн нөхцөл шаардлагаас бусад нөхцөлд онцгой шалтгаангүйгээр хохироож гэмтээж болохгүй. Хүн бол байгалийн нэг гишүүн бөгөөд бусад амьд амьтадтай адилхан эрхтэй, тэднээс дээгүүр өөрийгөө тавих эрхгүй гэж хүн төрөлхтний янз бүрийн соёлд үздэг байна. Хөдөөгийн иргэд цаг хугацааны тухайд шугаман бус эргэлт давталттай гэсэн ойлголттой байдаг. Энэ нь газар тариалангийн үйлдвэрлэлийн онцлог, улирал солигдолт, нутгийн иргэдийн оюун санааг баяжуулж байдаг баяр наадам, зан үйлтэй холбоотой. Үүнтэй нэгэн адил хамтын шийдвэр гаргах хандлага нь ялгаатай байдаг. Зарим нийгэм нь хамтын шийдвэр гаргахдаа жижиг бүлэг дотроо ч ардчилсан зарчмаар санал хураах аргыг хэрэгжүүлдэг байхад бусад нь маргаан, хэлэлцүүлэг, итгүүлэх замаар зөвшилцөлд хүрэхийг хичээдэг. Хэрэв бид гарцаагүй үнэн гэсэн өөрийн итгэл үнэмшлээсээ татгалзахыг зөвшөөрч, хүрээлэн байгаа бодит орчныг өөрөөр тайлбарлах боломжид оюун санаагаа нээж өгвөл бид бүхний оюун ухааныг баяжуулж чадах ертөнцийг үзэх хязгааргүй олон үзэл, номлол байгаа.

Бид мэдлэгийн нэг хэлбэрт давуу эрх олговол, үнэн хэрэгтээ эрх мэдлийн нэг системд давуу эрх олгох тухай Франц Фанон, Эме Сезэр, Рабиндранат Тагор зэрэг суут сэтгэгчдийн үзэл санааг эргэн санах нь нэн чухал юм. Янз бүрийн нөхцөл байдалд бий болсон мэдлэгийн системүүдийг нэгтгэх, нийтлэг өв уламжлал бий болгох зорилгоор ертөнцийг үзэх янз бүрийн үзлүүдийн хооронд харилцан ярилцлагыг өрнүүлэхийг өнөөдрийн нийгмийн хөгжил, боловсролын ирээдүй шаардаж байна. Бөмбөрцгийн өмнөд хэсгийн дуу хоолойг боловсролын талаар хийж байгаа олон улсын маргаан хэлэлцүүлэгт хүргэх хэрэгтэй байна. Жишээлбэл, Латин Америк дахь Анде нурууны уугуул нутгийн иргэдийн хувьд хөгжил гэдгийг *sumac kawsay* гэдэг ойлголтоор дамжуулан, кечуа хэлний “*buen vivir*” буюу “нэр төртэй амьдрал” гэсэн үгээр илэрхийлдэг. Уугуул нутгийн соёл, ертөнцийг үзэх үзлээс үндэслэн *sumac kawsay* –г хөгжлийн альтернатив үзэл баримтлал болгон дэвшүүлж, Эквадор, Боливи зэрэг

47 M.K.Gandhi, 1960. Trusteeship. Compiled by Ravindra Kelekar. Ahemadabad, india, Jitendra T. Desai Navajivan Mudranalaya

48 Эквадорын үндсэн хуулийн 14 ба 387 дугаар зүйлийг хар. ст. 14 - Se reconoce el derecho de la poblacion a vivir en un ambiente sano y ecologicamente equilibrado, que garantice la sostenibilidad y el buen vivir, *sumak kawsay*; ст.387.- Sera responsabilidad del Estado: [...] 2. Promover la generacion y produccion de conocimiento, fomentar la investigacion cientifica y tecnologica, y potenciar los saberes ancestrales, para asi contribuir a la realizacion del buen vivir, al *sumak kawsay*.

улсуудын үндсэн хуульд тусгасан байна. Бид дэлхий дээрх баялгийг “эзэмшигчид” гэдэг утгаар бус, харин бүх амьд амьтан, ирээдүй үеийг “асран халамжлагчид” гэдэг утгаар харж хандаж байдаг гэсэн Махатма Гандигийн “халамжлал”-ийн тухай үзлийг авч үзэх нь ач холбогдолтой⁴⁷.

3. Sumac Kawsay: Хөгжлийн нэгэн альтернатив үзэл

Sumac kawsay-гийн үзэл баримтлал нь Эквадор дахь Андын нурууны Кечуа (Quechua) хүмүүсийн ертөнцийг үзэх үзэлд үндэслэсэн юм. Испаниар “*buen vivir*” гэх *сумак кавсай* үзлийг англи хэл рүү “good living” эсвэл “well living” (монгол хэл рүү “сайхан амьдрал” эсвэл “нэр төртэй амьдрал”) гэж орчуулж болно. Хамтдаа зохицон хөгжих гэсэн утга агуулгатай энэ үзэл баримтлалд хувь хүнийг нийгэм, соёлын бүлгүүд, хүрээлэн байгаа байгаль орчны нөхцөл байдалтай нь уялдуулан авч үздэг. Кечуагийн уугуул иргэдийн итгэл үнэмшлийн тогтолцоонд үндэслэсэн энэхүү үзэл баримтлал нь хүмүүс хоорондын болон хүмүүс ба хүрээлэн байгаа байгаль орчны зохицол дээр суурилсан альтернатив үзэл баримтлалыг санал болгодог хөгжлийн давамгайлалч загваруудын талаарх барууны шүүмжлэлүүдийг өөртөө тусгасан байдаг.

Саяхан Эквадор улс Үндсэн хуулиа өөрчилсөн шалтгаан нь энэхүү үзэл баримтлал бөгөөд “сумак кавсай” буюу нэр төртэй амьдралд хүрэхийн тулд байгальтай зохицон “нийтээр хамт оршин байх” шинэ хэлбэрийг тусгасан байна. Энэхүү Үндсэн хууль нь “тогтвортой байдал ба нэр төртэй амьдрал (сумак кавсай)–ыг хангасан, экологийн тэнцвэртэй эрүүл орчинд амьдрах талаарх ард түмнийхээ эрхийг хүлээн зөвшөөрөх үндсэн дээр тулгуурлажээ. Мөн “мэдлэг бүтээх, дэлгэрүүлэхийг дэмжих, шинжлэх ухаан, технологийн судалгааг хөхүүлэн дэмжих, сайхан амьдрал (сумак кавсай)–д хүрэх өвөг дээдсийнхээ хүсэл мөрөөдлийг хэрэгжүүлэх” зэрэг нь төрийн үүрэг байх ёстой гэжээ.⁴⁸

Өнөөгийн олон ургальч нөхцөлд боловсролын хэтийн төлөвийг төсөөлөх нь

Хүний болон нийгмийн эрх тэгш, өрсөлдөх чадвартай тогтвортой хөгжлийн талаарх шинэ үзэл баримтлалын дагуу боловсролын зорилгыг эргэн харах ёстой. Тогтвортой хөгжлийн талаарх үзэл баримтлал нь хүний хөгжлийн нийгмийн, байгаль орчны, эдийн засгийн талыг болон тэдгээрийн боловсролтой хамаарах уялдаа холбоог анхааралдаа авч харгалзан үзэх ёстой. “Үр бүтээлтэй, байнга суралцдаг, асуудлыг шийдвэрлэдэг, хамтдаа болон байгальтай энх тайвнаар болон харилцан зохицон амьдрах чадвар бүхий өнөө үед зайлшгүй шаардлагатай байгаа хүний нөөцийг бий болгодог боловсролын систем нь эрх мэдэл, өөртөө итгэх итгэл олгодог байна. Улс орнууд ийм боловсролыг бүх нийтэд амьдралынх нь туршид хүртээмжтэй болгосноор боловсрол тогтвортой хөгжлийн хөдөлгөгч хүч, илүү сайхан нийгэм бий болгох гол түлхүүр болох бөгөөд нэг ёсны чимээгүй хувьсгал гарна.”⁴⁹ Дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн шинэ үзэл баримтлалд боловсрол хувь нэмэр оруулж чадах бөгөөд оруулах ч ёстой.

4. Боловсролоор дамжуулан тогтвортой хөгжлийг дэмжих нь

“Боловсрол, түүний дотор албан боловсрол, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа, сургалт бол хувь хүн, нийгэм өөрийн бүрэн боломжиндоо хүрч чадах үйл явц гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Тогтвортой хөгжлийг дэмжих, хүрээлэн байгаа орчны ба хөгжлийн асуудлуудад анхаарлаа хандуулах чадварыг сайжруулахад боловсрол нэн чухал юм.”

49 Power, C. 2015. The Power of Education: Education for All, Development, Globalization and UNESCO. (Боловсролын хүч чадал: Бүх нийтийн боловсрол, хөгжил, даяаршил, ЮНЕСКО). London, Springer

Тогтвортой хөгжлийн боловсролын тухай 2014 оны Айчи-Нагоягийн тунхаглал нь “боловсрол, тогтвортой хөгжлийн талаарх бодлогодоо энэ чиглэлийн сургалтын асуудлыг тусгах ажлыг эрчимжүүлэхийг засгийн газруудад уриалсан байна.”

**Боловсролын тухай
зонхилох утилитар
үзэл баримтлалууд нь
хүний нийгмийн сайн
сайхан аж байдлыг
таньж мэдэх бусад
 аргуудыг тусгах
ёстой бөгөөд улмаар
нийтийн баялаг гэдэг
утгаар нь боловсролын
ач холбогдолд
анхаарлаа хандуулах
хэрэгтэй юм**

Зохион байгуулалттай суралцах аливаа хэлбэр нь дасан зохицох, өөрчилж, шинэчлэх чадварыг олгодог. Сайн чанартай суурь боловсрол, түүний дараах сургалтууд болон мэргэжлийн бэлтгэл нь дэлхийн болон үндэсний хэмжээнд гарч буй байгаль орчин, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтүүдэд дасан зохицох чадавхийг хувь хүн, нийгмийн бүлгүүдэд олгоход шийдвэрлэх үүрэгтэй. Түүний зэрэгцээ нийгмийн өөрчлөлт хийх чадавхийг хөгжүүлэх, хүний эрх, боломжийг өргөтгөхөд чухал ач холбогдолтой. Үнэн хэрэгтээ бидэнд хэвшин тогтсон сэтгэлгээний дүр төрх, ертөнцийг үзэх үзлийг өөрчлөх зэрэг түвэгтэй асуудлыг шийдвэрлэхэд боловсрол тус нэмэр үзүүлж чадна. Хүний нэр төрийг хүндэтгэх зарчимд тулгуурласан утга төгөлдөр амьдрал зохион байгуулах боломжийг өргөтгөхөд шаардлагатай чадавхийг хөгжүүлэхэд боловсрол шийдвэрлэх үүрэгтэй. Боловсролын шинэчилсэн үзэл баримтлал нь шүүмжлэлт сэтгэхүй, бусдаас хамааралгүй эргэцүүлэн бодох, мэтгэлцээнийг хөтлөн явуулах зэрэг чадварыг хөгжүүлэх асуудлыг хамрах ёстой. Хувь хүн ба нийгмийн бүлгийн сонирхолд нийцсэн эдийн засаг, нийгмийн хувьд ач холбогдолтой сургалт явуулах, чанартай боловсрол олгоход гарч буй эерэг өөрчлөлтүүд нь зохих ахиц дэвшил хийх үндэс болно.

Чанартай боловсрол эзэмших эрх бол агуулгаараа баялаг, цаг үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтад хамрагдах эрх юм. Гэсэн хэдий ч, олон талт өнөөгийн нийгэмд суралцах хэрэгцээ нь нийгмийн бүлэглэлүүдийн хувьд харилцан адилгүй байна. Тэгэхлээр, цаг үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалт бол янз бүрийн соёл, нийгмийн бүлэг тус бүрийн хувьд нэр төртэй амьдрахад шаардлагатай зүйлийн тусгал байна. Амьдралын чанарыг тодорхойлох маш олон арга зам байдгийн нэг адил сурах үйл ажиллагааны үр дүнд юунд суралцах шаардлагатайг тодорхойлох янз бүрийн арга бий гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Боловсролын тухай зонхилох утилитар үзэл баримтлалууд нь хүний нийгмийн сайн сайхан аж байдлыг таньж мэдэх бусад аргуудыг тусгах ёстой бөгөөд улмаар нийтийн баялаг гэдэг утгаар нь боловсролын ач холбогдолд анхаарлаа хандуулах хэрэгтэй юм. Энэ нь өнөөг хүртэл дуу хоолой нь сонсогдоогүй хүмүүсийн дуу хоолойг сонсох санааг агуулж байгаа юм. Ийм олон янзын төлөв байдалд оршиж буй асар их нөөц баялаг нь сайн сайхан байдлыг хангах хамтын хүсэл эрмэлзлэлийн учрыг олж ухаарахад тусалж чадна. Боловсрол, хүний сайн сайхан байдлыг хангахын төлөөх альтернатив арга замуудыг хайхдаа хүмүүнлэг хандлагыг удидлага болгох хэрэгтэй юм.

2. Боловсролын хүмүүнлэг үзэл баримтлал



2. Боловсролын хүмүүнлэг үзэл баримтлал

*“Миний хүн чанар та нарын хүн чанартай салшгүй
холбоотой. Учир нь бид хамтдаа байснаараа хүн байж
чадна”*

Десмонд Туту, Өмнөд Африкийн нийгмийн эрхийн төлөө зүтгэлтэн, хамба лам

Хорин нэгдүгээр зууны боловсролын үндсэн зорилго бол хүний нэр төр, авьяас чадвар, амьдралын сайн сайхан бүхнийг хүрээлэн буй бусад хүмүүс, байгальтай уялдаатайгаар хадгалан бэхжүүлэхэд оршино. Энэ зорилгыг хүмүүнлэг үзэл гэж тодорхойлж болох бөгөөд түүнийг онол практикийн талаас нь судалж үзэх явдал ЮНЕСКО-гийн зорилго юм. Хүмүүнлэг үзлийн тухай ойлголт бол ЮНЕСКО-д эртнээс яригдаж ирсэн уламжлалтай. Бүр 1953 онд Нью Делид хуралдсан “Зүүн ба барууны орнууд дахь хүмүүнлэг үзэл ба боловсрол” сэдэвт олон улсын дугуй ширээний ярилцлагын тайланг ЮНЕСКО хэвлүүлсэн байдаг⁵⁰.

Хүмүүнлэгийн тухай үзэл баримтлалыг дээр үеэс олон янзын соёл, шашин, философийн олон тооны өөр хоорондоо ялгаа бүхий номлолд хэлэлцэж ирсэн уламжлалтай. Тухайлбал, хүмүүнлэг үзлийн тухай нэгэн тодорхойлолт нь түүнийг шашингүйн үзэл болон шашнаас ангид байх рационализмтай адилтгасан байдаг. Хүмүүн төрөлхтөн ба байгаль дэлхий хоёрын хоорондын онтологи ялгааг онцгойлон үздэг феноменологи, экзистенциализм болон бусад философийн сургаальд хүмүүнлэг үзлийг цааш нь дэлгэрэнгүй авч үзсэн байдаг. Түүний зэрэгцээ хүмүүнлэг үзлийн талаар шашны ул суурьтай тайлбарууд бий. Тэдгээр тайлбарын дагуу боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хүн төрөлхтний олсон ололт амжилт бол хүн төрөлхтөн, байгаль, орчлон ертөнц, бурхан зэргийн уялдаа холбоог харуулсан жишээ гэж үздэг. Хорьдугаар зууны сүүл, хорин нэгдүгээр зууны эхэнд хүн төвтэй үзлийн болон шашин төвтэй хүмүүнлэг үзлийг пост-модернистууд, зарим феминист, экологийн талыг баримтлагчид шүүмжилж

50 UNESCO Unity and Diversity of Cultures. 1953. *Humanism and Education in East and West: An international roundtable discussion*. («Зүүн ба Барууны орнууд дахь хүмүүнлэг үзэл ба боловсрол: Олон улсын дугуй ширээний ярилцлага» Paris, UNESCO).

эхэлсэн. Хожим нь биологийн селекц хийх, хүнийг биологийн талаас нь сайжруулах зэрэг уриалга дэвшүүлдэг өөрсдийгөө транс-хүмүүнлэг, пост-хүмүүнлэг үзэлтэн гэж үздэг хүмүүс тэрхүү шүүмжлэлд нэгдсэн байна.

Энэ бүх номлолд ёс суртахууны ба ёс зүйн тулгуур асуудлууд хөндөгдөж байгаа учраас боловсролын тухай асуудлыг авч үзэхэд эдгээрийг анхаарах ёстой.

■ Боловсролд хүмүүнлэгийн үүднээс хандах нь

Бүх нийтийн боловсролын зорилго, зохион байгуулалтад иж бүрнээр хандахад үндэс болох ёс зүйн түгээмэл зарчмуудыг хүмүүнлэг үзэл баримтлал улам бататгаж байдаг. Хүн төрөлхтний сонирхолд нийцсэн мэдлэг олж авах, дадлага чадварыг суулгахад чиглэсэн сургалтын үйл ажиллагаанд ийм хандлага нөлөө үзүүлж байдаг. Хүмүүнлэг хандлага бол боловсролын тухай маргаан хэлэлцүүлгийг эдийн засгийн хөгжилд түүний гүйцэтгэх утилитар үүрэг, ролийн хүрээнээс цааш гаргаж өгдөг. Хүртээмжтэй боловсрол, түүний нөхцөлд нэг ч хүнийг нийгмээс тусгаарлаж орхигдуулахгүй, нийгмээс хаягдсан байдалд оруулахгүй байхад хүмүүнлэг хандлага гол анхаарлаа хандуулдаг. Ийм хандлага нь дэлхийн хэмжээнд боловсролын салбарыг өөрчлөх үйл явцад баримтлах гол зарчим болдог. Энэ өөрчлөлтийн хүрээнд бүх нийтийн тогтвортой хөгжлийн тусын тулд суралцах үйл ажиллагааг явуулахад багш, сурган хүмүүжүүлэгчдэд урдын адил чухал үүрэг ногдоно.

Хөгжлийн талаарх түгээмэл үзэлтэй сөргөлдөх нь

Боловсролын зорилго, чиглэлийн тухай болон бидний тэмүүлж байгаа нийгмийн тухай асуулыг илүү өргөн хүрээнд авч үзэхдээ соёл, нийгэм, эдийн засаг, ёс зүй, иргэний асуудлуудыг харгалзан авч үзэх ёстой. Боловсролын эдийн засгийн асуудлууд эргэлзээгүй чухал. Гэхдээ олон улсын хүрээнд өнөө үед явагдаж байгаа хөгжлийн тухай яриа хэлэлцүүлгийн анхаарлын төвд байнга байдаг хүний нөөцийн хөгжлийн асуудалд хандах утилитар үзлийн хүрээгээр хязгаарлагдаж болохгүй.⁵¹ Бид боловсролын тухай зөвхөн ур чадвар эзэмших тухай биш, олон төрхт өнөөгийн ертөнцөд нийгмийн уянга зохицлыг хангахад шаардлагатай хүний амь нас, нэр төрийг хүндэтгэх үнэт зүйлс зан чанарыг бүрдүүлэх тухай ярьж байна. Хөгжлийн үйл явцад ёс зүйн асуудал тулгуур ач холбогдолтой болохыг ухамсарлан ойлгох нь өнөөдөр олон улсын хүрээнд явагдаж байгаа түгээмэл үзэл яриа хэлэлцүүлэгтэй зөрчилдөж байна.

Амарта Сенийн дэвшүүлсэн хөгжлийн тухай альтернатив үзэл баримтлалын дагуу утга учир дүүрэн, нэр төртэй амьдрахад шаардлагатай ур чадвар бүрдүүлэхэд боловсролын гүйцэтгэх үүргийг дээшлүүлэхэд дээрх ойлголт чухал үүрэг гүйцэтгэнэ⁵².

Ёс зүй, ёс суртахуунд үндэслэсэн нэгдмэл хандлага

Дээр дурдсантай уялдан нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилд хувь нэмэр оруулахын тулд амьдралын туршид суралцах үйл ажиллагаанд хүмүүнлэг үзлийн үүднээс хандахын зайлшгүй болохыг бататгах шаардлагатай юм. Мэдээжээр, боловсролын тухайн

51 2015 оноос хойших хөгжлийн асуудал эрхэлсэн Дээд түвшний ажлын хэсгийн 2013 онд гаргасан илтгэлийн боловсролын асуудалтай холбоотой хоёр хуудсанд боловсролд оруулсан хөрөнгө оруулалтын үр өгөөж, "үр бүтээлтэй иргэн" бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмэр гэсэн утгаар хүний капиталын тухай дурдсан байна.

52 Sen.A.1999. *Development as Freedom*. (Хөгжил бол Эрх чөлөө) New York, Random House; Sen.A. 1999. *Commodities and Capabilities*. (Товар ба чадавхи) New Delhi, Oxford University Press.

системийн онцлог, амьдралын явц дахь янз бүрийн үе шатнаас хамааран анхаарал хандуулах хүрээ чиглэл өөрчлөгдөж болох юм. Гэхдээ боловсролыг зохион байгуулах зарчим гэдэг утгаар насан туршдаа суралцах үйл ажиллагааг цаг үедээ нийцсэн, ач

Хүний нэр төр, авьяас чадвар, сайн сайхныг бусадтай нь болон байгальтай уялдуулан хамгаалж бэхжүүлэх нь хорин нэгдүгээр зууны боловсролын үндсэн зорилго байх ёстой

холбогдолтой гэдгийг дахин нотлохын тулд нийгэм, эдийн засаг, соёлын асуудлуудыг нэгтгэж хамруулах нь маш чухал юм.⁵³ ЮНЕСКО-гийн анхны ерөнхий захирал Жулиан Хаксли ЮНЕСКО-ийн баримтлах тулгуур зарчим болгон дэвшүүлж, улмаар 1972 оны Форийн илтгэлд дахин гаргаж ирсэн хүмүүнлэг ёсны тухай шинжлэх ухааны ойлголтоос боловсролд хандах хүмүүнлэг үзэл илүү өргөн хүрээтэй юм.⁵⁴ Дээр дурдсанаар, хүмүүнлэг ёсны үзэл баримтлал нь боловсролын үзэл баримтлалыг авч үзэхэд ач холбогдол бүхий ёс суртахууны ба ёс зүйн асуудлуудыг хөндсөн эсрэг тэсрэг олон тооны тайлбар гаргасан байдаг. Үүнтэй уялдан хүний нэр төр, авьяас чадвар, сайн сайхныг бусадтай нь болон байгальтай

уялдуулан хамгаалж бэхжүүлэх нь хорин нэгдүгээр зууны боловсролын үндсэн зорилго байх ёстой⁵⁵.

Хүний амьдрал ба нэр төрийг хүндлэх, тэгш эрх ба нийгмийн шударга ёс, соёлын болон нийгмийн олон янз байдал, хүн төрөлхтний эв санааны нэгдэл ба нийтлэг ирээдүйн төлөөх хамтын хариуцлага зэрэг хүмүүнлэг үнэт чанарууд боловсролын зорилго, түүний үндэс суурь болох ёстой. Үүнтэй уялдан Мартин Бубер⁵⁶ Пауло Фрейре⁵⁷ нарын дэвшүүлсэн харилцан яриа, хэлэлцүүлгийн үндсэн дээр сурах хандлага чухал юм. Зарим хэсэг бүлэг хүмүүст орон зай олддоггүй, тэднийг бараа мэт үздэг сургалтын систем болон хүмүүсийг хагаралдуулж, хүнлэг чанарыг алдагдуулдаг нийгмийн практикаас бид татгалзах ёстой. Хэрэв бид тогтвортой байдал, энх тайванд хүрэхийг эрмэлзэж байгаа бол ийм үнэт чанар, зарчмуудаар хүмүүсийг хүмүүжүүлэх нь нэн чухал юм.

Хамрах хүрээг ийнхүү өргөтгөснөөр боловсрол нь бүх нийтэд тогтвортой ирээдүйг хангахад дэмжлэг үзүүлэх, өөрчлөн шинэчлэх хүч болох юм. Ёс зүйн хэм хэмжээнд тулгуурласан шүүмжлэлт сэтгэхүй, бие даан тунгаан бодох, асуудал шийдэх, мэдээллийн цагаан толгой зэрэг мэдлэг чадвар зэрэг нь өөрчлөн байгуулах чадварыг бүрэлдүүлэн бий болгох гол түлхүүр юм. Тогтвортой байдлыг хангах асуудал дэлхий нийтийн хөгжлийн анхаарлын төв болсон өнөөгийн нөхцөлд 1996 онд Делорийн илтгэлд дэвшүүлсэн боловсролд нэгдмэл байдлаар хүмүүнлэгийн үүднээс хандах

53 Боловсролтой холбоотой 2015 оноос хойших тогтвортой хөгжлийн санал болгож буй зорилго нь насан туршийн боловсролын үзэл санааны дор томъёологдсон юм. "Бүх нийтэд насан туршдаа сурах боломжийг дэмжих, бүхнийг хамарсан чанартай боловсролоор хангах нь" <https://sustainabledevelopment.un.org/content/documents/1579SDGs%20Proposal.pdf>.

54 Huxley, J. 1946. UNESCO: Its purpose and philosophy. («ЮНЕСКО: түүний зорилго ба философи») Paris, UNESCO Preparatory Commission; мөн Haddad, G. and Aubin, J. P. 2013. Toward a humanism of knowledge, action and cooperation. («Мэдлэг, үйл ажиллагаа, хамтын ажиллагааны хүмүүнлэг мөн чанар»). International Review of Education, Vol. 59, No. 3, pp. 331-341.

55 'On Dignity', («Хүний нэр төрийн тухай») Diogenes, August 2007, Nol. 54, No. 3, <http://dio.sagepub.com/content/54/3.toc#content-block> [Использовано в феврал 2015 г.].

56 Morgan, W. J. and Guilherme, A. 2014. Buber and Education: Dialogue as conflict resolution. («Бубер ба боловсрол: Харилцан ярилцлага бол зөрчлийг шийдэх арга») London, Routledge.

57 Roberts, P. 2000. Education, Literacy, and Humanization: Exploring the work of Paulo Freire. («Боловсрол, бичгийн соёл ба хүмүүнлэг үзэл: Пауло Фрейрийн бүтээлийг судлах нь») Westport, CT and London, Bergin and Garvey.

асуудал ач холбогдлоо алдаагүй байна. Хүрээлэн байгаа орчинд хариуцлагатай хандах, нийгмийн шударга ёсыг дээдлэх зарчимд тулгуурлан эдийн засгийн өсөлтийг хангах замаар тогтвортой хөгжлийн зорилтыг шийдвэрлэхдээ боловсролд иж бүрэн хандаж, улмаар нийгэм, ёс зүй, эдийн засаг, соёл, иргэний болон оюун санааны олон талын асуудлуудыг тооцохыг шаардаж байна. Танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, ёс зүйн хоорондох уламжлалт ялгааны хүрээг давсан иж бүрэн хандлагыг боловсрол ба суралцах үйл ажиллагаанд тусгах шаардлагатай байна. Когнитив ба сургалтын бусад хэлбэрүүдийн хоорондох зөрчлийг даван туулах нь боловсролын гол зорилго гэдгийг улам бүр хүлээн зөвшөөрөх болж байна. Сургалтын төлөвлөгөөний хүрээнд сургалтын үнэлгээнд онцгой анхаарал хандуулж байдаг хүмүүсийн хувьд ч энэ нь үнэн зүйл юм. Саяхан мэдлэг дүгнэх уламжлалт аргыг хэрэглэх хүрээнээс гадна жишээлбэл, нийгмийн болон сэтгэл зүйн сургалт, соёл урлагийн хүрээг хамарсан өргөн хүрээтэй иж бүрэн үнэлгээний ерөнхий бүтцийг дэвшүүлж тавьсан байна. Нийгмийн болон сэтгэл хөдлөл, ёс зүйн зэрэг сургалтыг тоон хэмжүүрээр үнэлэх шаардлагатай эсэх талаар дэлхийн хэмжээнд эргэлзээ байдаг ч дээрхи оролдлого нь ердийн уламжлалт академик сургалтын хүрээнээс гарч үнэлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрөх болсныг гэрчилж байна.

Боловсролын дөрвөн тулгуур зарчмыг шинээр тайлбарлаж, хамгаалах нь

1996 оны Делорийн илтгэлд тусгагдсан чухал үзэл баримтлалуудын нэг бол *суралцах үйл ажиллагааны дөрвөн тулгуур зарчим* юм. Албан боловсролын системд мэдлэгийн тодорхой төрлүүдийг онцлон анхаараад, хүний тогтвортой хөгжлийг хангахад зайлшгүй чухал бусад мэдлэгийг орхигдуулах хандлагатай байна гэж илтгэлд тэмдэглэсэн. Мөн бүх төрлийн зохион байгуулалт бүхий сургалтын системд дараах дөрвөн тулгуур зарчимд ижилхэн анхаарал хандуулах ёстой гэжээ⁵⁹. Үүнд:

- Мэдэхийн тулд суралцах – өргөн хүрээтэй ерөнхий мэдлэг олж авахын зэрэгцээ цөөн тооны хичээлийг гүнзгий судлах боломжтой байх
- Хийж чадахын тулд суралцах – мэргэжлийн чадвар олж авахын зэрэгцээ янз бүрийн нөхцөл байдлыг зөв үнэлэх, багаар ажиллах чадвартай болох
- Хүн болохын тулд суралцах – тунгаан бодох чадвар, хувийн хариуцлагадаа тулгуурлан бие даан ажиллах чадвараа хөгжүүлэх, бие хүн болж төлөвших
- Хамт амьдрахад суралцах – бусад хүмүүсийн тухай ойлгох, харилцан хамаарлыг үнэлэх чадвараа хөгжүүлэх

Энэхүү суралцах үйл ажиллагааны дөрвөн тулгуур зарчимд тусгасан боловсролд нэгдмэл хандах санаа нь боловсролын бодлого, багш бэлтгэх, сургалтын хөтөлбөр боловсруулах зэрэг асуудлаар дэлхийн олон оронд явагдаж байгаа хэлэлцүүлэгт ихээхэн нөлөө үзүүлсэн байна. Саяхны нэг жишээг авч үзье. Испанийн Баск мужид бага боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулахдаа энэхүү дөрвөн тулгуур зарчмыг хөтөч санаа болгон ашигласан байна. Суралцах үйл ажиллагааны эдгээр дөрвөн тулгуур зарчим боловсролд нэгдмэл хандахад ач холбогдолтой хэвээр байна. Тэдгээрийн ерөнхий шинж нь янз бүрийн нөхцөл байдал, цаг хугацаанд тохирсон шаардлагатай иж бүрэн сургалтын хэлбэрийг тодорхойлох боломж өгдөг. Тогтвортой байдлыг хангах асуудалд илүүтэй анхаарах болж байгааг харгалзан дээр дурдсан зарчмуудыг шинээр тайлбарлах хэрэгтэй байж болох юм. Тухайлбал, “*хамт амьдрахад суралцах*” зарчмын хувьд хүмүүс хоорондын харилцааны нийгмийн ба соёлын асуудлаас хальж, хүний нийгмээс хүрээлэн байгаа байгаль орчинтой харилцах харилцааны асуудлыг хамруулахыг чухалчлах ёстой.

**Өнөөгийн нийгмийн өмнө тулгарч
буй асуудлуудын нөхцөлд дээрх
дөрвөн тулгуур зарчим ялангуяа,
боловсролын нийгэмшүүлэх
үүргийг хамгийн сайн тусгадаг
хүн болохын тулд суралцах
болон хамт амьдрахад суралцах
зарчмууд хүнд байдалд орж**

Өнөөгийн нийгмийн өмнө тулгарч буй асуудлуудын нөхцөлд дээрх дөрвөн тулгуур зарчим ялангуяа, боловсролын нийгэмшүүлэх үүргийг хамгийн сайн тусгадаг хүн болохын тулд суралцах болон хамт амьдрахад суралцах зарчмууд хүнд байдалд орсон нь онцгой санаа зовоож байна. Боловсролын хүмүүнлэг үзэл баримтлалын үндсэн эдгээр

зарчмуудыг хамгаалахын тулд сургалтын явцад ёс зүйн болон үнэт чанарын талаарх зарчмыг бэхжүүлэх нь чухал болж байна.

Танин мэдэхүйн тулд суралцах ба мэргэжлийн чадамжийг дээшлүүлэх нь

Өнөөгийн ээдрээтэй, тодорхойгүй нөхцөл байдалд ямар төрлийн мэргэжлийн чадамж шаардагдах тухай олон улсад идэвхитэй маргаан хэлэлцүүлэг өнөөдөр өрнөсөөр байна. Гэсэн хэдий ч мэргэжлийн чадвар ба чадамжийн талаар олон янзын, ихэвчлэн ижил төстэй тодорхойлолтууд, тэдгээрийн ангиллын олон хувилбарууд нь төөрөгдөл бий болгож болох юм. Хэдийгээр чадвар, чадамж гэсэн хоёр нэр томъёог голдуу харилцан орлуулж хэрэглэдэг боловч энэ хоёр нэр томъёоны хооронд тодорхой ялгаа байдаг. Чадамж гэдэг ойлголт бол илүү өргөн хүрээтэй. Тодорхой орчин нөхцөлд болон тухайн шаардлагын дагуу мэдээлэл, аливаа зүйлийн тухай ойлголт, чадвар, үнэт зүйлс, хандлага зэргийг өргөн утгаар хамруулсан мэдлэгийг хэрэглэх чадварыг мэргэжлийн чадамж гэнэ.

5. Суурь, хөрвөх, техникийн болон мэргэжлийн чадвар

2012 оны “Бүх нийтийн боловсролын хяналт, үнэлгээний дэлхийн тайлан”-д хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой янз бүрийн чадварын талаар авч үзэх чухал хандлагыг дэвшүүлсэн байна. Бүх залуу хүмүүст шаардагдах суурь, хөрвөх, техникийн болон мэргэжлийн гэсэн үндсэн гурван төрлийн чадварыг, мөн тэдгээрийг олж авах боловсролын орчин нөхцлийг энэ тайланд тогтоосон.

Суурь чадвар: Хамгийн энгийн нь гэж болох суурь чадвар нь хүний өдөр тутмын хэрэгцээг хангахуйц хөлс бүхий ажил олоход зайлшгүй шаардлагатай бичиг үсгийн ба тоо бодох чадвар юм. Энэ суурь чадвар нь цаашид үргэлжлүүлэн боловсрол, мэргэжил эзэмшихэд болон хөрвөх чадвар ба техникийн болон мэргэжлийн чадвар олж авахад нь урьдчилсан нөхцөл болно.

Хөрвөх чадвар: Янз бүрийн ажлын байрны хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалд хэрэглэж болох, ажил хайж олох, түүн дээрээ тогтож ажиллахад шаардлагатай өргөн хүрээтэй чадваруудыг хөрвөх чадвар гэнэ. Асуудлыг задлан шинжлэх, зохих шийдлийг олох, өөрийн санаа болон мэдээллийг оновчтой хүргэх, ажилдаа бүтээлч хандах, манлайлал ба ухамсартай байдлаа харуулах, энтерпренер авьяас чадвараа үзүүлэх зэргийг хөрвөх чадварт багтаана. Эдгээр чадвар нь боловсролын орчны гадуур төлөвших тал бий. Гэхдээ тэдгээрийг нэмэлт боловсрол, давтан сургалтаар цаашид сайжруулж болно.

Техникийн болон мэргэжлийн чадвар: Олон төрлийн ажлын байр нь тусгай техник, мэргэжлийн мэдлэг чадвар шаардана. Тухайлбал, үр суулгах машин ашиглан ногоо тарих, тоосго өрөх, мужааны ажил хийх, эсвэл компьютер дээр ажиллах зэргийг дурдаж болно. Техникийн болон мэргэжлийн чадварыг дунд сургуульд суралцах явцдаа үйлдвэрлэлийн дадлага, хөдөлмөрийн хичээлийн хүрээнд, албан ёсны техник мэргэжлийн боловсрол олж авах замаар эсвэл дагалдан сургах уламжлалт арга, хөдөө аж ахуй дээр ажиллуулах зэрэг ажлын байран дээрх сургалтаар олж авч болно.

Эх сурвалж: UNESCO, 2012. *Youth and Skills: Putting education to work. EFA Global Monitoring Report 2012*. Paris, UNESCO.

“Зөөлөн”, “хөрвөх”, “когнитив бус”, “хорин нэгдүгээр зууны” зэрэг чадваруудыг төлөвшүүлэхийн ач холбогдолд анхаарлаа төвлөрүүлж байгаа нь боловсролын агуулга, арга зүйн талаарх өнөөгийн үзэл бодлыг баяжуулж байна. Үүний цаана илэрхий биш байдлаар байгаа гол үндэслэл бол өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд бүтээлч сэтгэлгээ, ажил хэрэгч байдлыг хөгжүүлэх шаардлага юм. Хэдийгээр энэ шаардлага эдийн засагт боловсролын гүйцэтгэх үндсэн үүрэгт чухал боловч хүний амьдралын олон талт байдлаас авч үзэхэд хувь хүн ба нийгмийн бүлгүүдэд зайлшгүй шаардлагатай чадварууд, ялангуяа хүн бүрийн эрх, боломжийг өргөтгөхөд чиглэсэн чадамжуудыг хөгжүүлэх ач холбогдлыг бууруулах ёсгүй. Ийм чадамжууд нь тухайн өгөгдсөн нөхцөлд шийдлийг олох, бусадтай шинэ харилцаа холбоо үүсгэхэд харгалзах мэдлэг (мэдээлэл, ойлголт, чадвар, үнэт зүйлс)-ийг бүтээлчээр, хариуцлагатайгаар ашиглах чадварыг хөгжүүлдэг.

Эзэмшвэл зохих мэдлэгийн агуулгыг ямар нэг төв байгууллагын заавраар биш, харин сургууль, багш, нийгмийн бүлгүүдийн оролцоотойгоор тодорхойлно. Энд мэдлэгийг дамжуулах тухай бус, мэдлэгийн тусламжтайгаар судлах, турших, эрж хайх, улмаар хүн төрөлхтөнд зайлшгүй хэрэгцээтэй байгаа шинэ мэдлэгийг бий болгох тухай ярьж байна. Энэ бол хэл яриа, харилцааны суурь чадварыг хөгжүүлэх, асуудлыг шийдвэрлэх, өндөр эрэмбийн тухайлбал, задлан шинжилж, баяжуулан нэгтгэх чадвар, логик дүгнэлт гаргах, дедукц, индукцийн арга эзэмших, таамаглал дэвшүүлэх зэрэг чадварыг хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэгийн тухай ярьж байна. Энэ бол хамгийн чухал ур чадвар болох мэдээллийг олж, шүүмжлэлтэйгээр үнэлэх чадварыг төлөвшүүлдэг аргаар илэрдэг мэдлэгийн тухай ярьж байна. Өнөөдөр танин мэдэх зорилгоор сурах нь урд өмнө байгаагүйгээр чухал ач холбогдолтой болж байна.

Өнөөдөр танин мэдэх зорилгоор сурах нь урд өмнө байгаагүйгээр чухал ач холбогдолтой болж байна.

Өнөөдөр интернэт дээр байгаа мэдээллийн хэмжээ үнэхээр гайхшралыг төрүүлж байна. Үүнтэй уялдан өнөөгийн гол зорилт бол суралцаж буй хүн бүрийг өдөр тутам тулгарч буй энэхүү асар их мэдээллийн учрыг нь зөв олох, найдвартай эх сурвалжийг тогтоох, уншиж байгаа зүйлийнхээ үндэслэл, баталгаа нотолгоог үнэлэх, мэдээллийн жинхэнэ эх сурвалж болох ба үнэн зөв байдлыг эргэцүүлэн бодох, шинэ мэдлэгийг өмнөхтэй нь холбох, урд өмнө эзэмшсэн мэдээлэлтэй харьцуулах замаар ач холбогдлыг нь ялган таньж сурахад оршиж байна⁶⁰.

Сургалтын хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааг эргэн харах нь

Боловсролын бодлого ба сургалтын агуулгыг тодорхойлох байр сууринаас харахад хүмүүнлэгийн зарчимд үндэслэсэн сургалтын хөтөлбөр ямархуу байх вэ? Сургалтын агуулга, арга зүйн хувьд хүмүүнлэг зарчимд чиглэсэн сургалтын хөтөлбөр нь хариулт өгөхөөсөө илүү олон асуултыг тавьж байна. Түүнд олон ургальч байдлыг хүндлэх, бүх төрлийн дээрэнгүй үзэл, хэвшмэл үзэмж, ялгаварлан гадуурхах үзлээс татгалзахыг дэмждэг. Энэ бол олон ургальч үзэл ба хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсийг тэнцвэртэйгээр хослуулахын зэрэгцээ нийгэмд олон ургальч байдлыг дэмждэг соёл хоорондын боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн тухай ярьж байна. Бодлогын

60 Facer, K. 2011. *Learning Futures: Education, Technology and Social Challenges*. («Ирээдүйд суралцах нь: Боловсрол, технологи, нийгмийн асуудлууд») New York, Routledge.

үүднээс авч үзвэл, сургалтын хөтөлбөрийн ерөнхий бүтэц нь боловсролын салбарын өргөн хүрээний зорилгууд ба түүнд хүрэх аргуудыг холбох хэрэгсэл гэдгийг санах ёстой. Сургалтын хөтөлбөрийг хууль ёсны болгохын тулд сургалтын зорилгыг тодорхойлох чиглэлээр явагдах бодлогын хэлэлцүүлэгийн үйл явц нь хамтын бөгөөд бүхнийг хамруулсан байх ёстой⁶¹. Сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсруулах стратеги нь тогтвортой хөгжлийн үндэс болох нийгэм, эдийн засгийн шударга ёс, эрх тэгш байдал, хүрээлэн буй орчны хариуцлагын зарчмуудад тулгуурлах ёстой.

■ Хүртээмжтэй боловсрол олгох нь

Суурь боловсролд тэгш бус байдал үргэлжилсээр байгаа нөхцөл дэх ахиц дэвшил

Мянганы тунхаглалд томъёолсон хөгжлийн зорилтууд болон Бүх нийтийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2000 оноос хойш суурь боловсрол эзэмших эрхийг хангах дээр мэдэгдэхүйц ахиц гаргасан. Сургуульд хамрагдалтын үзүүлэлтүүд сайжирсан, сургуулиас завсардсан хүүхдийн тоо цөөрсөн, залуучуудын дунд бичиг үсэгт тайлагдсан байдал дээшилсэн, сургуульд хамрагдалтын хүрээнд ч, насанд хүрэгчдийн дунд бичиг үсэгт тайлагдалтыг дэлгэрүүлэх хүрээнд ч жендерийн зөрүү багассан зэргээр дээрх ахиц илэрхийлэгдэж байна.

Ийм ахиц байгаа хэдий ч “хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн боловсролын үндсэн хэрэгцээг хангана” гэсэн засгийн газрууд, олон улсын түншүүдийн аль 1990 онд авсан амлалт биелж чадаагүй л байна. Дэлхий даяар ойролцоогоор 60 сая хүүхэд, 70 сая өсвөр шилжилтийн насныхан чанартай суурь боловсролыг хүртэж чадахгүй байна. 2011 оны байдлаар 775 сая орчим насанд хүрэгчид бичиг үсэгт хангалттай тайлагдаагүй байна. Тэр ч байтугай албан ёсны суурь боловсролд хамрагдагчдын дунд сургуулиа дуусгахгүй хаях явдал, чанар муутай боловсрол зэрэг нь эзэмшсэн суурь чадвар түвшин хангалтгүй байгаа шалтгаан юм. Энэ тохиолдолд боловсролын чанар ба олж авсан мэдлэгийн ач холбогдол гол асуудал хэвээр байна. Хамгийн багаар авч үзэхэд 250 сая хүүхэд сургуульд наад зах нь дөрвөн жил сурсны дараа ч хангалттай уншиж, бичиж, тоолж чадахгүй байна⁶².

Үүний зэрэгцээ улс орнуудын хооронд маш их ялгаа, тэгш бус байдал илэрхий байсаар байгаа бөгөөд улс орны дотоодод суурь боловсролоор олсон мэдлэг, түүний чанарын талд дээр байгаа тэгш бус байдал нь олон улс оронд үндэсний дундаж үзүүлэлтүүдээр хаацайлагдаж байна⁶³. Боловсролд гадуурхалт үүсэх уламжлалт хүчин зүйл болох жендер, хот, хөдөөгийн ялгаа зэрэг нь орлого, хэл, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээл зэрэг хүчин зүйлсээр хүрээгээ тэлж улмаар “харилцан хүч нэмж буй таагүй нөхцөл”-ийг ялангуяа орлогын түвшин доогуур болон мөргөлдөөнд нэрвэгдсэн орнуудад бий болгож байна.⁶⁴

61 Amadio, M., Opertti, R., Tedesco, J.C. 2014. Curriculum in the Twenty-First Century: Challenges, Tensions and Open Questions (XXI зууны сургалтын хөтөлбөр: асуудлууд, эсрэг тэсрэг байр суурь, шийдэгдээгүй асуудлууд). *ERF Working Papers*, No. 9. Paris, UNESCO. См. также: International Bureau of Education UNESCO. 2013. The Curriculum Debate: Why It Is Important Today (Сургалтын хөтөлбөрийн талаарх хэлэлцүүлэг: яагаад өнөөдөр чухал болов). IBE Working Papers on Curriculum Issues No. 10. Geneva, IBE UNESCO. <http://unesdoc.unesco.org>.

62 UNESCO. 2014. *Teaching and Learning: Achieving quality for all EFA Global Monitoring Report 2013-2014* (Сурах ба сургах: бүх нийтээрээ чанарт хүрэх нь. Бүх нийтийн боловсролын хяналт үнэлгээний дэлхийн тайлан 2013-2014 он.) Paris, UNESCO.

63 Маскатын хэлэлцээрийн (2014 г.) Бүх нийтийн боловсролын хяналт үнэлгээний дэлхийн тайлангийн мэдээллэд үндэслэсэн хэсгээс. 57сая гаруй хүүхэд 69 сая өсвөр насныхан чанартай суурь боловсролд хамрагдаж чадахгүй байна. 2011 онд 774 сая орчим насанд хүрэгчид бичиг үсэгт тайлагдаагүй байна.

6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд анхаарал дутагдаж байдаг

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших эрх нь ихэвчлэн зөрчигддөг. Тэдний сургуульд явж байгаа онцлог байдал бага судлагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаар мэдээлэл цуглуулахад тодорхой бэрхшээл байдаг хэдий ч эдгээр хүүхдүүдэд тулгарч байгаа бэрхшээлийг шийдэхэд чиглэсэн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд ийм мэдээлэл туйлын чухал ач холбогдолтой.

2004 оны байдлаар 14-өөс доош насны 93 сая хүүхэд буюу дэлхийн нийт хүүхдийн 5.1% нь “дунд эсвэл хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээл”-тэй амьдарч байна гэсэн тооцоо бий. Дэлхий дээрх эрүүл мэндийн байдалд хийсэн судалгаагаар бага болон дунд орлогын түвшинтэй 15 улсын 14-т нь бага боловсрол эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны хүмүүсийн тоо бага боловсролтой бусад хүн амтай харьцуулахад ойролцоогоор гуравны нэгээр бага байна. Тухайлбал, Бангладеш хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 30% нь бага сургууль дүүргэсэн байхад хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт 48% байх жишээтэй. Энэхүү хувь хэмжээ Замби-д харгалзан 43% ба 57%, Парагвай-д 56% ба 72% байна.

Хөгжлийн бэрхшээл бий болох өндөр эрсдэлтэй хүүхдүүдийн хувьд сургуульд явах боломжийг нь гол төлөв хаах магадлалтай гэдэг нь бодит баримтаас харагдсан. Бангладеш, Бутан, Иракт оюуны хомсдолтой хүүхдүүдэд энэ эрхээ хэрэгжүүлэхэд нь гол төлөв татгалздаг. Тухайлбал, 2006 оны байдлаар Иракт хөгжлийн бэрхшээлийн эрсдэлгүй 6-аас 9 насны хүүхдүүдийн 10% нь сургуульд хэзээ ч явж байгаагүй байсан бол сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн 19% нь, сэтгэхүйн өвчний улмаас оюуны бэрхшээл үүсэх өндөр эрсдэлд байгаа хүүхдүүдийн 51% нь сургуульд хэзээ ч явж байгаагүй байна. 2005–2006 оны хичээлийн жилд Тайландад хөгжлийн бэрхшээлгүй 6-аас 9 насны бараг бүх хүүхдүүд сургуульд сурч байсан бол хөдөлгөөний хомсдолтой хүүхдүүдийн 34% нь сургуулийн ширээнд хэзээ ч суугаагүй байна.

Эх сурвалж: UNESCO, 2014. *Teaching and Learnings: Achieving quality for all. EFA Global Monitoring Report 2013–2014*. Paris, UNESCO.

Суурь боловсрол дахь жендерийн тэгш байдал

Боловсрол дахь жендерийн эрх тэгш байдлыг албан боловсролын янз бүрийн түвшин дэх жендерийн тэнцвэрт байдалтай адилтган явцуу хүрээнд авч үзэх уламжлалтай. Хүйсийн харьяалал бол боловсрол дахь тэгш бус ба ялгавартай байдлын уламжлалт хүчин зүйл бөгөөд гол төлөв охид, эмэгтэйчүүд гадуурхалд өртөх талтай. Гэсэн хэдий ч 2000 оноос хойш дэлхий даяар жендерийн зөрүүтэй байдлыг багасгахад ихээхэн ахиц гарсан нь албан боловсролын янз бүрийн түвшинд охид, эмэгтэйчүүдийн эзлэх хувь өссөнөөр илэрч байна. Төв ба Зүүн Европ, Төв Ази, Зүүн Ази ба Номхон далайн орнууд, Латин Америк болон Карибийн орнууд, Хойд Америк, Баруун Европт бага боловсрол дахь жендерийн тэнцвэрт байдалд хүрсэн байна. Үүний зэрэгцээ, 2000 оноос хойш, ялангуяа Өмнөд ба Баруун Азид жендерийн зөрүүтэй байдлыг багасгахад ихээхэн ахиц гарсан бол Сахарын цөлөөс урагш орших Африкийн орнууд болон Арабын улс орнуудад бага зэргийн ахиц гарсан. Энэ чиглэлд бодитой ахиц гарч байгаа хэдий ч сургуулиас гадуурх хүүхдүүдийн дийлэнх нь охидууд, бичиг үсгийн боловсрол доогуур түвшинд байгаа залуучууд, насанд хүрэгчдийн гуравны хоёр нь эмэгтэйчүүд байна. Эмэгтэйчүүдийн эрх боломжийг өргөтгөхөд жендерийн тэгш бус байдлын эсрэг тэмцэлд хөвгүүд, эрэгтэйчүүд бас оролцох ёстой. Үүнийг суурь боловсролоос эхлэх ёстой.

64 UNESCO. 2011. *The hidden crisis: Armed conflict and education. EFA Global Monitoring Report 2011* (Далд хямрал: зэвсэгт мөргөлдөөн ба боловсрол. Бүх нийтийн боловсролын хяналт үнэлгээний дэлхийн тайлан. 2011 он) Paris, UNESCO.

7. Боловсролоос тусгаарлагдсан охины дуу хоолойг сонсох нь

Боловсрол бол амьдралаас бидэнд өгсөн азтай боломж бөгөөд бас амьдралын хэрэгцээ шаардлагын нэг юм.

Өнөөдөр . . . миний дуу хоолой ганцаар биш, бид олуулаа.

Би бол боловсролоос тусгаарлагдсан 66 сая охидын нэг, тиймээс миний дуу хоолой тэдгээр 66 сая охидын дуу хоолойтой нэг юм.

Нобелийн Энх тайвны шагнал хүлээн авахдаа Малала Юсуфзайгийн хэлсэн үг, Осло, 2014 оны 12 сарын 10

Дунд, дээд боловсрол дахь жендерийн тэгш байдал

Төв болон зүүн Ази, Латин Америк болон Карибийн сав газар, хойд Америк болон баруун Европ зэрэг бүс нутгуудад дунд боловсрол дахь жендерийн тэнцвэрт байдалд хүрэх зорилгыг хангасан байна. Дэлхийн бусад бүс нутагт, тухайлбал Өмнөд ба Баруун Азийн орнуудад жендерийн зөрүүтэй байдал буурч байгаа нь ажиглагдаж байна. Арабын орнуудад бага хэмжээгээр буурч байна. Дунд сургуульд суралцагчдын тухай үзүүлэлтүүдэд хамгийн өндөр жендерийн зөрүүтэй байдал Сахарын цөлөөс урд хэсгийн Африк, Баруун Ази, Өмнөд Азид харагдаж байгаа юм. Дээд боловсролын тухайд Сахарын өмнөд хэсгийн орнуудад дээд сургуульд суралцагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь бага хэвээр байгаа нь дээд боловсрол дахь жендерийн тэнцвэрт байдлыг хангах зорилгод хүрэхэд түвэгтэй болгож байна. Дэлхийн дийлэнх бүс нутагт ялангуяа Арабын улсууд, Зүүн Ази ба Номхон далай, Өмнөд, Баруун Азийн орнуудад энэ чиглэлээр тодорхой ахиц ажиглагдаж байна. Төв болон Зүүн Европ, Карибийн сав бүс нутаг, Хойд Америк, Номхон далайн бүс, Баруун Европ зэрэг зарим бүс нутгуудад дээд боловсрол эзэмшиж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс дээгүүр байна. Энэ бол дунд боловсролд хамрагдсан охидын тоо хурдан өссөнөөс бус харин хөвгүүд сурлагаар хоцорч байгаатай болон нилээд бүс нутагт хөвгүүдийн дунд сургууль төгсөлт доогуур байгаатай холбоотой юм. Дэлхийн зарим бүс нутагт тухайлбал, Карибийн сав болон Латин Америкийн орнуудад хөвгүүдийн дунд сургууль завсардах үзэгдэл өндөр байгаа нь өөр нэг түвэгтэй асуудал болж байгаа бөгөөд улмаар нийгмийн нэгдэл нягтралын асуудлыг гүнзгийрүүлж байна.

Боловсрол тэнцүү боломжийг хангах хэрэгсэл мөн

Боловсрол заримдаа тэгш бус байдлыг бий болгож, даамжруулдаг боловч тэнцүү боломжийг хангах хэрэгсэл болж чадна. Боловсролын бүх нийтэд хүртээмжтэй байх шинж чанар нь шударга хөгжлийг хангахад чухал ач холбогдолтой бөгөөд боловсролын үйлчилгээг үзүүлэх боловсролын янз бүрийн түвшинд энэ нь бас үнэн байх талтай.

Бага насны хүүхдийн боловсрол: Цаашдын боловсрол, улмаар амьдралдаа амжилтанд хүрэхэд бага насны хүүхдийн боловсролын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх болж байна. Иймээс тэнцүү боломжийг хангах асуудал сургуулийн өмнөх насны боловсролд хамрагдана.

Судалгааны үр дүнгээс харахад бага насны хүүхдүүдийг багаас нь боловсролд хамруулах нь зөвхөн тэдний өөрсдийнх нь сайн сайхны төлөө ач холбогдолтой

65 Global Child Development Group. 2011. *Child Development Lancet Series: Executive Summary*. (Хүүхдийн хөгжил, Цуврал сэтгүүл «The Lancet») www.globalchilddevelopment.org [2015 оны хоёрдугаар сарын байдлаар энэ сайтад хандах боломжтой.].

66 Baron-Cohen, S. 2008. *The Facts: Autism and Asperger Syndrome* (Мэдээ баримт: аутизм ба Аспергерын синдром). Oxford, UK, Oxford University Press.

төдийгүй хүний хөгжил, нийгмийн нэгдэл нягтрал, эдийн засгийн амжилттай хөгжилд тогтвортой, урт хугацааны үр нөлөө үзүүлдэг байна. Ядуу бүлгийн, угсаатны ба хэлний цөөнхөд хамрагдсан, жендерийн ялгаварлалтад өртсөн, алслагдмал нутагт амьдардаг, хөгжлийн бэрхшээлтэй, хүчирхийлэл ба ХДХВ/ДОХ-ын өвчлөлт зэрэг шалтгаанаар хүнд нөхцөлд байгаа хүүхдүүд бага насны хүүхдийг хөгжүүлэх сайн чанартай хөтөлбөрүүдээс хамгийн гайхалтай ашиг тусыг амсдаг. Гэхдээ эдгээр хүүхдүүд нь ийм хөтөлбөрт хамрагдаж чадахгүй байх магадлал өндөр байдаг⁶⁵.

Багаас нь боловсролд хамруулах талаар хийсэн судалгаагаар сургуулийн өмнөх боловсролын үр өгөөжийн шалтгааныг олж тогтоосон байна. Нас ахих тутам хүүхдийн өсөлтийн дундаж үзүүлэлт ба өсөлтийн саатлын дундаж үзүүлэлтийн хоорондох ялгаа нэмэгддэг байна. Аль болох эрт үе шатанд хүүхдэд туслах нь хөрөнгө, хүч чармайлт бага шаардах бөгөөд илүү үр дүнтэй байдаг гэдэг нь өнөөдөр илэрхий болжээ. Хөгжлийн тодорхой бэрхшээлтэй, тусгай халамж шаардлагатай хүүхдүүд, жишээлбэл, аутизм юмуу Аспергерийн өвчтэй хүүхдүүдийг боловсролд эртнээс хамруулах нь чухал ач холбогдолтой юм⁶⁶.

8. Сенегал: “Бага насны хүүхдийн гэр” хөтөлбөрийн туршлага

Хүүхэд хамгааллын талаар дорвитой арга хэмжээ авч байгаа хэдий ч Сенегалд хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн хангамжийг хамгаалах тал дээр таагүй байдал үргэлжилсээр байгаа бөгөөд урдын адил сэтгэл зовоосон асуудал хэвээр байна. Энэ нөхцөл байдалтай холбогдуулан Сенегалын засгийн газраас бага насны хүүхдүүдийн хүмүүжлийн асуудлыг хөгжлийн тэргүүлэх зорилго болгон авч үзэж байна. 2002 оноос хойш ‘Бага насны хүүхдийн гэр’ гэсэн хөтөлбөрийн хүрээнд хүүхдийг төрсний дараах эхний жилүүдэд хүмүүжүүлэх шинэ хэлбэрийг нэвтрүүлсэн байна. Энэ хөтөлбөр нь албан, албан бус сургуулийн өмнөх боловсролын хүрээн дэх янз бүрийн байгууллагуудын хамт зэрэгцэн хэрэгжиж байна. Энэ хөтөлбөр хэдийгээр зарим нэг зүйлийг сайжруулж болох ч орон нутгийн ардын соёлын уламжлалд үндэслэж нутгийн хүмүүсийн туршлагыг хэрэглэж байгаа үнэ цэнэтэй туршлага юм.

‘Бага насны хүүхдийн гэр’ хөтөлбөр нь хөдөө орон нутагт амьдарч байгаа дөнгөж төрснөөс эхлээд 6 хүртэлх насны хүүхдүүдийг дэмжихэд зориулсан олон нийтийн бүтэц юм. Энэхүү гэр буюу уламжлалт орон сууц гэсэн утга бүхий хөтөлбөр нь амьдралын уламжлалт хэв маяг, ертөнцийг мэдрэх, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэхэд анхаардаг бөгөөд Африк тивийн үнэт зүйлсэд хандах итгэл үнэмшлийг суулгахад чиглэдэг. Хүүхдийн амьдарч, нийгэмшиж, хүмүүжих байр болох утгаараа “гэр” нь хүүхэд амьдралынхаа туршид олж авах боловсролын эхлэл гэж үздэг.

Эхний үед ийм “гэр” нь нийгмийн эмзэг бүлэг, хөдөөгийн хүүхдүүдэд иж бүрэн, зохистой нэгдсэн үйлчилгээ баталгаатай олгоход чиглэж байлаа. Тэдгээрийг иргэд өөрсдөө удирдан ажиллуулдаг бөгөөд Сенегалын бага насны хүүхдэд зориулсан бүтцийн 20%-ийг ийм бүтэц эзэлдэг байна. Архитектурын хувьд ‘Бага насны хүүхдийн гэр’ нь хоёр өрөөнөөс бүрдсэн зургаан өнцөгт байгууламж бөгөөд нэг өрөө нь хүүхэдтэй хичээллэхэд, нөгөө нь эцэг эхийг сургахад зориулагдсан байна. Ийм бүтцэд нь боловсрол, эрүүл мэнд, зөв хооллох зэрэг хөтөлбөрүүдийг багтаасан бага насны хүүхдийн хүмүүжлийн бүх талыг хамарсан иж бүрэн хандлагыг хэрэгжүүлдэг байна.

Ийм “гэр”-т хамрагдах нь төлбөртэй боловч бага насны хүүхдийн бусад байгууллагуудаас төлбөр бага байдаг. Санхүүгийн энэ өчүүхэн оролцоо нь бэлгэдлийн шинжтэй бөгөөд гэр бүлүүдэд тухайн нийгмийн бүлгийн нийтлэг эрх ашгийн хүрээнд хамтран ажиллах боломж өгдөг. Энэхүү сайн туршлагыг цаашид ч хадгалж чадна гэж найдаж байна.

Эх сурвалж: Turpin Bassama, S., 2010. La case des tout-petits au Sénégal. Revue Internationale d'éducation de Swires. No. 53-2010, pp. 65-75. –ээс хялбаршуулан авав.

Дунд боловсрол: Тэнцүү боломжийг хангах асуудал дунд ба дээд боловсролд бас хамааралтай. Дэлхий даяар бага боловсролын хүртээмж тэлсэн нь дунд ба дээд боловсролын эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, ялангуяа залуучуудын ажилгүйдэл өсөн нэмэгдэж, мэргэжлийн ур чадвар ба давтан сургалтаар олсон мэргэшлийг хүлээн зөвшөөрөх талаар тодорхой ажил явагдаж байгаа нөхцөлд мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх сонирхол нэмэгдэж байна. Латин Америк, Карибын бүс нутгийн зарим оронд хүн амын ядуу давхаргын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн төрийн бодлогоор суурь боловсролын дараах сургалтын боломжийг өргөжүүлсэн нь тэгш бус байдлыг багасгахад хүргэсэн байна. “Боловсрол, хөдөлмөрийн зах зээлийн байгууллагуудад хөрөнгө оруулах харгалзах эрх зүйн хэм хэмжээг боловсруулах нь тэгш бус байдлын илрэх хэлбэрүүдийг өөрчилж чадна. Тэгш бус байдал буурсан Латин Америкийн орнуудад боловсролын хүртээмжийг өргөжүүлсэн, ядуу гэр бүлүүд рүү чиглэсэн төрөөс дэмжлэг үзүүлсэн гэсэн хоёр гол хүчин зүйл нөлөөлсөн. Латин Америк, Карибын бүх орнуудад боловсролын салбарт оруулах улсын зардал өссөнөөс дунд сургуульд суралцагчдын тоо, сургууль төгсөлтийн хувь хэмжээ нэмэгдсэн бөгөөд энэ нь тэгш бус байдлыг бууруулах гол хүчин зүйл болсон юм”⁶⁷.

Дээд боловсрол: Сүүлийн арван таван жилд дээд боловсролын хүртээмж гайхалтай өргөжжээ. 2000 оноос хойш дээд боловсролд хамрагдалтын ерөнхий үзүүлэлт хоёр дахин өссөн ба өнөөдөр дэлхий даяар 200 сая оюутан байгаагийн тал хувь нь эмэгтэйчүүд байна⁶⁸. Сүүлийн жилүүдэд бодлогын янз бүрийн арга хэмжээ авсан хэдий ч орлогын түвшин болон нийгмийн гадуурхалт зэрэг бусад хүчин зүйлээс хамаарсан тэгш бус байдал урдын адил ихэд тархсан хэвээр байна. Харьцангуй өндөр түвшний орлоготой нийгмийн бүлэгт харьяалагдах суралцагчид дээд боловсролд хамрагдах харьцангуй давуу талаа хадгалсаар байгаа дүр төрх дэлхий даяар харагдаж байна. Боловсролд хамрагдалтын түвшингээрээ өндөр үзүүлэлттэй орнуудад ч боловсролд үндэсний цөөнхийн хамрагдсан байдал улсын хэмжээний дундаж үзүүлэлтэд хүрэхгүй хэвээрээ л байна. Дээд боловсролд хамрагдалтын үндсэн өсөлт нь хувийн секторын ачаар хангагдаж байсан ба одоо ч хангагдаж байна гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Хувийн сургуулиудын эзлэх хувь өсөж, дэлхий даяар улсын секторыг хувьчлах чиг хандлага гарсан нь боловсролын салбар дахь тэгш эрх, хүртээмжэд шууд нөлөөлж байна. Дээд боловсролын сургалтын шууд ба шууд бус зардал нь хүн амын зарим давхаргын хувьд дээд боловсрол эзэмших боломж гол шалтгаан хэвээр байгаагийн дээр боловсролын зээлийн талаар сайн хөтөлбөрүүд өргөн хүрээнд дэлгэрч чадахгүй байна⁶⁹.

9. Мексикийн соёл хоорондын харилцааны их сургуулиуд

Хэдийгээр Мексикийн хүн амын дөнгөж 10% нь нутгийн уугуул иргэд боловч тэдний төлөөлөл дээд боловсролын түвшинд бага байна. Мексикийн дээд сургуулийн оюутны зөвхөн 1–3 хувь нь нутгийн уугуул иргэд байна гэсэн тоо баримт бий.

2004 онд энэ байдлыг засах зорилгоор тус улсын Боловсролын яамны Соёл хоорондын харилцааны болон давхар хэлний боловсролын асуудал эрхэлсэн удирдах газраас бүс нутаг бүрт нутгийн уугуул иргэдийн байгууллага болон шинжлэх ухааны байгууллагуудын идэвхтэй оролцоотойгоор соёл хоорондын харилцааны их сургуулиудыг байгуулсан юм. Эдгээр их сургуулиуд нь нутгийн уугуул иргэд шигүү

67 UN DESA. 2013. *Inequality Matters. Report of the World Social Situation 2013*. («Тэгш бус байдлын үр дагавар. Дэлхийн нийгмийн байдлын тухай илтгэл. 2013.») New York, United Nations.

68 ЮНЕСКО-ийн Статистикийн институтын мэдээлэл

суурьшдаг дүүргүүдэд тэдэнд зориулан байгуулагдсан бөгөөд элсэлт нь бусад хүмүүст нээлттэй байна. Соёлын хоорондын харилцааны зарчимд тулгуурласан эдгээр их сургуулиуд нь янз бүрийн соёл хоорондын харилцааг өргөжүүлэх, нутгийн уугуул иргэдийн түүхэн болон өнөөгийн тулгамдсан асуудлуудад хариу өгөх арга замын нэг илэрхийлэл болж байгаа.

Соёлын олон төрлийг хүлээн зөвшөөрөх зарчмыг удирдлага болгон, соёл хоорондын харилцааны их сургуулиуд боловсролын үйл ажиллагаандаа хатуу тогтоосон хандлагыг хэрэглэдэггүй. Зарим үндсэн зарчмуудыг дагаж мөрдөх хэдий ч, их сургууль бүр өөрийн байрлаж байгаа бүс нутгийн хэрэгцээ шаардлага, хүч боломжтой нийцүүлж хөтөлбөрөө боловсруулдаг байна. Оюутнууд тухайн орон нутаг, тэнд амьдарч буй хүмүүс, тэдний соёлын хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой судалгаа хөгжлийн төслүүдээр дамжуулан орон нутгийн иргэдтэй ойртож ажилладаг байна. Одоогоор ийм 12 их сургуульд ойролцоогоор 7000 оюутан суралцаж байна. Тэдний дотор эмэгтэй оюутны тоо харьцангуй өндөр хувьтай байна. Хэдийгээр эдгээр их сургуулиуд санхүүгийн, оюутны амьдрах нөхцөлийн, төрийн бодлогын зэрэг бэрхшээлүүдтэй тулгарч байгаа ч боловсролын тэгш байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулж байна.

Эх сурвалж: Schmelkes, S. 2009. Intercultural Universities in Mexico: Progress and difficulties. (Мексик дэх соёл хоорондын харилцааны их сургуулиуд: амжилт ба хүндрэлүүд) *Intercultural Education*, Vol. 20, No. 1, pp. 5–17. www.tandfonline.com/doi/full/10.1080/14675980802700649 [2015 оны 2 сард авсан].

■ Боловсролын дүр төрхийн өөрчлөлт

Өнөөдөр дэлхий дахинаа сургалтын арга, агуулга, суралцах орчны хувьд томоохон огцом өөрчлөлт явагдаж байгаагаар боловсролын дүр төрх онцлог юм. Энэ өөрчлөлт ерөнхий боловсролын сургуулиуд, тэр ч байтугай дээд боловсролын байгууллагуудад ч явагдаж байна. Мэдлэгийн өсөн нэмэгдэж байгаа эх сурвалжууд, түүний хүртээмжтэй байдал өргөжиж байгаа явдал суралцах үйл ажиллагаанд зохион байгуулалтын хувьд төгс бус боловч илүү бүтээлч нэмэлт боломжуудыг нээж өгч улмаар танхимын хичээл, сурган заах арга зүй, багшийн эрх мэдэл, сурах үйл ажиллагаанд нөлөөлж байна.

Боловсролын дүр төрхийн байдалд гарч буй одоогийн өөрчлөлтийг хамарч байгаа цар хүрээгээр нь XIX зуунд эхэлсэн үйлдвэржүүлэлтийн өмнөх боловсролын уламжлалт загвараас үйлдвэрлэл дээр сургах боловсролын загвар руу шилжсэн түүхэн шилжилттэй зүйрлэж болно. Үйлдвэржилтийн өмнөх уламжлалт загварт хүмүүсийн сурч байсан ихэнх ур чадвар нь тэдний өдөр тутмын ажил, амьдралтай холбоотой байсан. Үйлдвэржүүлэлтийн хувьсгалаар бий болсон олноор нь сургах боловсролын загварт мэдлэгийг зөвхөн сургуульд суралцаж байж олж авах болсон. Хэдийгээр амьдрал дээр сурах үйл ажиллагааны нилээд хэсэг нь гэрт юм уу, хаа нэгтэй явагдаж байдаг ч мэдлэг олж авах үйл ажиллагааг анги танхимд хичээл заалгахтай холбож авч үзэх нь одоо хүртэл үргэлжилж байна. Мэдлэгийн гол туйл болох анги танхимын бодит орон зай урдын адил албан боловсролын бүх шатны сургалтын системд гол онцлог хэвээр үлдсэн байна⁷⁰.

Сургуулиар боловсрол олж авдаг үе өнгөрсөн үү?

Цахим эриний өнөө үед цахим сургалт, хөдөлгөөнт төхөөрөмж, бусад тоон технологийн тусламжтай сурах боломжуудын үүднээс авч үзвэл сургуулиар боловсрол

70 Frey, T. 2010. The future of education («Ирээдүйн боловсрол»). *FuturistSpeaker*. www.futuristspeaker.com/2007/03/the-future-of-education [2015 оны 2 сард авлаа].

69 Altbach, P. G., Reisberg, L. and Rumbley, L. E. 2009. Trends in Global Higher Education: *Tracking an Academic Revolution* («Дээд боловсролын салбарын ерөнхий чиг хандлага: боловсролд гарч буй хувьсгалыг шинжих нь»). ЮНЕСКО-ийн зохион байгуулсан *Дээд боловсролын дэлхийн бага хуралд бэлтгэсэн илтгэл* (2009 он).

олж авдаг загвар ирээдүйгүй болж байна гэж зарим шинжээчид үзэж байна. Үүнтэй холбоотойгоор сургуулиар боловсрол олгох хэлбэрээс татгалзах нь зүйтэй эсэх талаар жар, далаад оны үед явагдаж байсан маргаан хэлэлцүүлэг, тухайлбал Пол Гүүдман⁷¹, Иван Иллич⁷² нарын бүтээлийг эргэн үзэх нь хэрэгтэй байж болох юм. Өнөөгийн сургуулиар боловсрол олгох загвар нь аль зуу гаруй жилийн өмнө үйлдвэрлэлийн хэрэгцээг хангахын тулд гарч ирсэн. Өнгөрсөн хорин жилийн хугацаанд сургалтын аргууд эрс өөрчлөгдөж, мэдлэгийн эх сурвалжууд болон мэдлэг солилцох, түүнтэй ажиллах арга өөрчлөгдсөн. Албан боловсролын систем өнгөрсөн хоёр зууны турш байсан загварыг хадгалсаар маш удаан өөрчлөгдөж байна.⁷³ Гэсэн хэдий ч сургуулиар боловсрол олгох хэлбэр урдын адил чухал хэвээр байна. Энэ бол зохион байгуулалттай сургалт бөгөөд хүүхдийг гэр бүлээс гадна нийгмийн харилцаанд оруулах эхний алхам бөгөөд хүн болохын тулд суралцах ба хамт амьдрахын тулд суралцах зэрэг нийгмийн сургалтын гол бүрэлдэхүүн хэсэг юм. Сурах үйл ажиллагаа бол зөвхөн хувь хүний үйл ажиллагаа байж болохгүй. Нийгмийн хуримтлуулсан туршлагыг судлах арга болохын үүднээс мэдлэг олж авах үйл ажиллагаа нь бусадтай хамт суралцах, бусдын тусламжаар, үе тэнгийхэн, багш нартайгаа санал бодлоо солилцох, хэлэлцүүлэг хийх замаар суралцахыг шаарддаг.

Боловсролын сүлжээ бүхий орон зай бий болгох замд

Сургалтын тасралтгүй цогц үйл ажиллагаа гэдэг үүднээс боловсролд илүү уян хатан хандах хэрэгтэй болж байна. Энэхүү тасралтгүй сурах үйл ажиллагааны хүрээнд бага наснаас эхлээд насан туршийн боловсрол олгох бүхий л шатанд сургууль, албан боловсролын байгууллагууд албан бус сургалтын системүүдтэй ойр ажиллах ёстой.

Орчин үед дэлхий ертөнцөд явагдаж байгаа боловсролын дүр төрхийн өөрчлөлтийн нөхцөлд албан боловсролын байгууллагаас гадуур суралцах ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрөх болж байна. Уламжлалт боловсролын байгууллагуудаас холимог, олон чиглэлтэй боловсролын цогц төрх байдал руу шилжих үйл явцыг ажиглаж байна. Энд албан ба албан бус сургалтыг олон төрлийн боловсролын байгууллагууд болон боловсролын үйлчилгээ үзүүлдэг хөндлөнгийн бүтцүүд явуулж байна⁷⁴. Сургалтын тасралтгүй цогц үйл ажиллагаа гэдэг үүднээс боловсролд илүү уян хатан хандах хэрэгтэй болж байна. Энэхүү тасралтгүй сурах үйл ажиллагааны

хүрээнд бага наснаас эхлээд насан туршийн боловсрол олгох бүхий л шатанд сургууль, албан боловсролын байгууллагууд албан бус сургалтын системүүдтэй ойр ажиллах ёстой. Сурах үйл ажиллагаа явагдаж байгаа орон зай, цаг хугацаа, харилцаан дахь өөрчлөлтүүд нь албан боловсролын системийг албан бус ба сургуулиас гадуурх сургалтын орон зайгаар өргөтгөн, суралцах үйл ажиллагааны сүлжээний орон зайг бий болгох таатай нөхцөл бүрдүүлж байна.

71 Goodman, P. 1971. *Compulsory Miseducation*. («Албан бөгөөд буруу боловсрол») Harmandsworth, UK, Penguin Books.

72 Illich, I. 1973. *Deschooling Society*. («Альтернатив сургалттай нийгэм») Harmandsworth, UK, Penguin Books.

73 Davidson, C.N. and Goldberg, D.T. with Jones, Z.M. 2009. *The Future of Learning Institutions in the Digital Age*.

(«Тоон эриний сургуулийн ирээдүй») Cambridge, MA, MIT Press (МакАртурын сангийн дэмжлэгтэй бэлтгэсэн сургалт, мэдээллийн тоон хэрэгслүүдийн тухай илтгэл).

74 Scott, C. 2015. *The Futures of Learning* («Сурах үйл ажиллагааны ирээдүй»). ERF Working Papers. Paris, UNESCO.

Суралцах үйл ажиллагааны шинэ орон зай

Мэдлэгийн хүртээмж өргөжиж, хичээлийн танхим, сургууль, их сургууль, бусад боловсролын байгууллагуудаас гадна сурч боловсрох шинэ олон орон зай гарч ирснээр бидний дасал болсон танхимд сурах систем шүүмжлэлтэй тулгарч байна. Олон нийтийн сүлжээ бол хамтран ажиллах, хамт зохион бичих зэрэг боломжуудыг нээж өгснөөр танхимын хичээлийг баяжуулж өгдөг. Хөдөлгөөнт төхөөрөмжүүдийн тусламжтай суралцагчид сургалтын материал олж авах, өөр хоорондоо харьцах, танхимд болон түүнээс гадуур өөрөө контент бүтээх боломжтой⁷⁵. Дээд боловсролын хүрээнд онлайн хичээлийн агуулгыг нэмэгдүүлэх зорилгоор янз бүрийн хичээлүүдээр боловсруулсан өөрсдийн агуулгыг нэгтгэсэн нийтийг хамарсан онлайн нээлттэй хичээлийг их сургуулиуд явуулж эхэлсэн нь дэлхийн хэмжээнд олон оюутныг хамрах шинэ боломжийг нээж өгч байна.

Боловсролын дүр төрхийн өөрчлөлт нь боловсролын бүх төрлийн орон зайг албан боловсрол, мэргэшил дээшлүүлэх болон бусад бүтэцтэй харилцан үр өгөөжтэй байдлаар нэгтгэх нөхцлийг бүрдүүлж байна. Эдгээр өөрчлөлт нь туршилт, инноваци хийх шинэ боломжуудыг нээж байна.

10. “Ханан дахь цонх” туршилт

“Ханан дахь цонх” туршилтыг санаачилсан эзэн нь NIIT компаний эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан доктор Сугата Митра юм. Бүр 1982 онд тэрээр компьютер ашиглахтай холбоотой багшгүй сургалт буюу хяналтгүй сургалт явуулах санааг турших гэж оролджээ. Эцэст нь 1999 онд доктор Митрагийн ажилтнууд компанийхаа байшингийн Нью-Дели дэх Калкажи дүүргийн ядуусын хороолол руу харсан талын хананд цонх гаргаж, түүндээ үнэ төлбөргүй ашиглуулахаар компьютер байрлуулжээ.

Ядуу дүүргийн хүмүүс, ялангуяа хүүхдүүдийн дунд энэхүү компьютер нь тэр дороо алдартай болжээ. Компьютертай ажиллах ямар ч туршлагагүй тэд бие даан компьютер ашиглаж сурсан байна. Зугаатай, тэдний сонирхол татсан агуулга бүхий программ хангамжтай компьютертай ажиллах боломж олгож, бага зэргийн арга зүйн тусламжийг үзүүлэхэд хүүхдүүд компьютертай харьцах суурь чадварыг системтэй бус сургалтаар олж авч чадна гэсэн таамаглалыг эндээс дэвшүүлж байна.

Калкажийн туршилтын амжилтанд урамшин, Шивпури (Мадхья-Прадеш муж) болон Мадантуси (Уттар-Прадеш муж) хотуудад компьютеруудыг чөлөөтэй ашиглуулахаар тус тус байрлуулсан байна. Эдгээр туршилтыг “ханан дахь цонх” гэж нэрлэх болжээ. Шивпури, Мадантуси-д хийсэн туршилтад хийсэн дүгнэлт Калкажид хийсэн туршилтын үр дүнг баталжээ. Энэ хоёр газар хүүхдүүд компьютертай ажиллах чадварыг өөрсдөө олж авсан байна. Энэхүү сурах үйл ажиллагааны шинэ арга зүйг хөндлөнгийн оролцоо багатай сургалт гэж нэрлэжээ.

1999 оны эхний туршилтаас хойш, “ханан дахь цонх” туршилт өргөн хүрээнд тархсан байна. Делигийн Калкажи дүүрэгт байрлуулсан ганц компьютерээс эхэлсэн энэхүү туршилт Энэтхэг, Бутан, Камбож, Төв Африкийн БНУ-ын алслагдмал, хүрэхэд хүндрэлтэй газруудад 100 гаруй компьютер байрлуулан өргөжүүлжээ.

Эх сурвалж: www.hole-in-the-wall.com [2015 оны 2-р сард авав].

-
- 75 Hannon, V., Patton, A. and Temperley, J. 2011. *Developing an Innovation – Ecosystem for Education*. («Инновацийн төсөл боловсруулах нь: боловсролын экосистем») Indianapolis, CISCO; Taddei, F. 2009. *Training creative and collaborative knowledge-builders: A major challenge for 21st century education*. («Мэдлэг бүтээх хамтын болон бүтээлч арга зүйд сургах нь: 21 зууны боловсролын гол асуудлууд») Боловсролын хөгжлийн ирээдүйн асуудлаар бэлтгэсэн илтгэл. Paris, OECD.
- 76 Grimsus, M. and Ebner, M. 2013. *M-Learning in Sub Saharan Africa Context- What is it about*. («Сахарын цөлөөс урагш Африкийн орнуудад хэрэглэж байгаа хөдөлгөөнт сургалт: Түүний тухай»), Мультимедиа, гипермедиа холбооны технологийг боловсролд хэрэглэх асуудлаар болсон Дэлхийн бага хурлын материал, 2013 г., pp. 2028-2033. Chesapeake, VA: AACE.

Хөдөлгөөнт сурах үйл ажиллагаа

Сүүлийн үед сурах үйл ажиллагаанд хөдөлгөөнт технологийг хэрэглэх талаар ихээр сонирхох болж байна. Хөдөлгөөнт төхөөрөмжийг дангаар нь болон бусад мэдээлэл холбооны технологитой хослуулан ашиглаж сурах явдал бол дурын цаг хугацаанд, дуртай газраа сурах боломжийг олгодог⁷⁷. Хөдөлгөөнт технологи байнга өөрчлөгдөж сайжирч байгаа бөгөөд одоогоор гар утас, ухаалаг утас, гар компьютер, цахим ном унших төхөөрөмж, зөөврийн дуу тоглуулагч, гар удирдлага зэргийг өөртөө багтааж байна. Шинэ технологи гарч ирснээр сурах үйл ажиллагааны мөн чанарыг эрс өөрчилсөн. Гар утас, гар компьютерээс эхлээд халаасны компьютер зэрэг хөнгөн, авсаархан төхөөрөмжүүд орчин үеийн нийгэмд мэдлэг олж авах үйл ажиллагааны мөн чанарыг өөрчлөн, сургалтыг урдаас тогтоосон тодорхой газар явуулах шаардлагаас чөлөөлж байна⁷⁸. Ингэснээр сурах үйл ажиллагаа илүү албан бус, хувь хүнд тохирсон бүх нийтийг хамарсан шинжтэй болж байна⁷⁹. Хөдөлгөөнт технологи нь ширээний компьютертай харьцуулахад хямд, интернет дээрх асар их нөөц материалыг ашиглах боломтой учраас багш нарын сонирхлыг ихэд татаж байна⁸⁰.

Боловсролын салбарын янз бүрийн хүрээнд хөдөлгөөнт сургалт өргөн тархаж байгаа нь суурь болон дээд боловсролын хөгжилд нөлөөлөхийн дээр албан ба албан бус боловсролын хооронд “гүүр” болж өгсөн юм⁸¹. Авсаархан байдал, өртөг бага зэрэг онцлог шинжүүдээрээ сургалтад зориулсан хямд үнэтэй хөдөлгөөнт төхөөрөмжүүд суурь боловсролын хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой юм⁸². Хөдөлгөөнт технологи бол “өнөөдрийн тоон ялгаатай байдлыг бүх нийтэд чанартай эрх тэгш боловсрол олгох замаар тоон ашигтай байдал болгох түлхүүр хүчин зүйл” юм⁸³. Хөдөлгөөнт технологийн хөгжил нь бичиг үсгийн боловсрол ба хэлний сургалтад өргөн боломж нээж байгааг тэмдэглэх хэрэгтэй⁸⁴. Суралцагчдын бичиг үсгийн чадварыг дээшлүүлэхэд хөдөлгөөнт технологи үр дүнтэй болохыг судалгаагаар баталжээ. Өргөн олон түмнийг хамруулах боломжтой учир хөдөлгөөнт технологи нь нийгмээс тусгаарлагдсан, эсвэл боловсрол

77 UNESCO. 2013. *Policy Guidelines for mobile learning* («Хөдөлгөөнт сургалтын талаар баримтлах бодлогын гол зарчмууд»). Paris, UNESCO.

78 O'Malley, C., Vavoula, G., Glew, J.P., Taylor, J., Sharples, M. and Lefrere, P. 2003. *MOBILearn WP4 – Guidelines for Learning/Teaching/Tutoring in a Mobile Environment*. («Хөдөлгөөнт сургалтын орчинд сургалт явуулах, хичээл заах, давтан сургах үндсэн зарчмууд»). www2.le.ac.uk/Members/gv18/gv-publications [2015 оны 2 сард авав].

79 Traxler, J. 2009. *Current State of Mobile Learning*. («хөдөлгөөнт сургалтын өнөөгийн байдал»). M. Alley (ed.), *Mobile Learning Transforming the Delivery of Education and Training* («Хөдөлгөөнт сургалт боловсрол, сургалтыг өөрчилж байгаа нь») Athabasca, AB, Canada, AU Press. pp. 9-24.

80 Kukulska-Hulme, A. 2005. Introduction. J. Traxler and A. Kukulska-Hulme (eds), *Mobile learning – a handbook for educators and trainers* (Хөдөлгөөнт сургалт: боловсролын салбарт ажиллагчид ба багш нарт зориулсан лавлах) New York, Routledge, pp. 1-6.

81 Traxler, өмнөх бүтээлийг үз.

82 Kim, P.H. 2009. Action Research Approach on Mobile Learning Design for the Underserved. *Education Technology Research Development*. («Боловсролд харгалзах хүртээмжгүй хүмүүст зориулсан хөдөлгөөнт сургалтын загвар боловсруулах судалгааны арга зүй: Боловсролын технологийн судалгаа, хөгжил»). Vol. 57, No. 3, pp.415-435.

83 ITU and UNESCO. 2014. Mobile learning week: A revolution for inclusive and better education. («Хөдөлгөөнт сургалтын долоо хоног: чанартай хүртээмжтэй боловсролын хувьсгал»). UNESCO website. www.unesco.org/new/en/media-services/in-focus-articles/mobile-learning-week-a-revolutionfor-inclusive-better-education [2015 оны 2-р сард авав].

84 Joseph, S., Uther, M. 2006. Mobile language learning with multimedia and multi-modal interfaces. *Proceedings of the fourth IEEE International Workshop on Wireless, Mobile and Ubiquitous Technology in Education* («Мультимедиад тулгуурласан хөдөлгөөнт төхөөрөмжийн тусламжтайгаар хэл сурах нь», Боловсролд утасгүй хөдөлгөөнт технологи нэвтрүүлэх асуудлаар болсон IEEE-ийн олон улсын семинарын материал), (ICHIT '06), pp. 124-128.

85 Saechao, N. 2012. Harnessing Mobile Learning to Advance Global Literacy («Дэлхий дахинаа бичиг үсэгт тайлагдахад хөдөлгөөнт сургалтыг ашиглах нь»). The Asia Foundation. <http://asiafoundation.org/ina-sia/2012/09/05/harnessing-mobile-learning-to-advance-global-literacy/> [2015 оны 2-р сард авав].

олж авахад бусад бэрхшээлтэй тулгарч байгаа залуучууд хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх тал дээр эрс өөрчлөлт хийх боломжийг нээж байна⁸⁵.

11. Пакистаны охидод бичиг үсгийн боловсрол олгох хөдөлгөөнт сургалт

Бичиг үсгийн боловсрол олгох уламжлалт сургалтыг өргөтгөх зорилгоор хөдөлгөөнт сургалтаар бичиг үсгийн боловсрол олгох ЮНЕСКО-ийн төслийн хүрээнд Пакистаны алслагдмал орон нутагт амьдардаг өсвөр насны 250 охидод гар утас ашиглан сургалт явуулжээ. Пакистанд бичиг үсэг үл мэдэх явдал, ялангуяа охид эмэгтэйчүүдийн хувьд хурц асуудлын нэг юм. Улсын хэмжээнд насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсрол эрэгтэйчүүдийн хувьд 69%, харин эмэгтэйчүүдийн хувьд дөнгөж 40% байна. Боловсролын салбарт хийсэн судалгаагаар байнгын практик хийхгүй бол шинээр эзэмшсэн бичиг үсгийн чадвар хурдан мартагдаж алдагддаг нь харагдсан тул төсөл боловсруулагчид курсээ дүүргэсний дараа охидод алсаас тусламж үзүүлэх арга замыг олохыг хичээжээ.

Ямар ч компьютер байхгүй, интернетийн найдвартай холбоогүй хөдөө тосгонд амьдардаг сурагчдад хичээл сонсгох ганц арга бол гар утас байсан. Багш зааварлагчид сурагч охидуудад бичих чадварын дасгал хийх, даалгаварт өгсөн хэсгүүдийг сурах бичгээс дахин уншихыг сануулсан текстэн мессеж илгээдэг байна. Мөн багш нар асуулт тавьж, охид текст мессежээр хариулж байсан. Энэ бүх үйл ажиллагаа, мэдээлэл солилцоо нь хичээлийн үед охидын олж авсан бичиг үсгийн чадварыг бататгах зорилготой байсан.

Төсөлд хөдөлгөөнт төхөөрөмж ашиглахаас өмнө бичиг үсгийн курсийг дүүргэсэн охидын зөвхөн 28% нь шалгалтандаа дээд балл авсан байна. Харин хөдөлгөөнт төхөөрөмж хэрэглэснээр энэ үзүүлэлт 60%-ийг давжээ. Энэхүү амжилт дээр үндэслэн төслийг өргөтгөхөөр шийдсэн бөгөөд одоо 2500 гаруй сурагчдыг хамрах болжээ.

Эх сурвалж: UNESCO. 2013. *Policy Guidelines For Mobile Learning*. (Хөдөлгөөнт сургалтын талаар баримтлах бодлогын гол зарчим) Paris, UNESCO, p. 15

Нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээл (МООС): хэтийн төлөв ба хязгаарлалтууд

Дээд боловсролын дүр төрхийг нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээл (МООС) тодорхой хэмжээгээр өөрчилж байна. Энэ нь засгийн газар, боловсролын байгууллагууд, бизнесийн бүлгийнхний сонирхлыг ихээхэн татаж байна⁸⁶. Нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээл нь дээд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, онлайн сургалтын хүрээнд инновацийг нэвтрүүлэх чухал талбар болж өгсөн. Үүний зэрэгцээ ийм хичээлүүд бий болсноор хичээл заах арга зүй, чанарын баталгаа, төгсөлтийн доогуур түвшин, сургалтын үр дүнгийн үнэлгээ, түүнийг хүлээн зөвшөөрөх талаар санаа зовоосон асуудлуудыг шинээр тавихын зэрэгцээ тэгш бус байдлыг нэмэгдүүлж мэдэх юм⁸⁷. Нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээл нь үндсэндээ бие даан сурах сургалт бөгөөд бусад онлайн хичээлүүдийн нэг адил түүнийг дэмжих бүтэц тогтоогүй учраас чанарын асуудал онцгой санаа зовоодог⁸⁸. Ихэнх нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээлүүдийн хувьд “мэдээллийг хүртээмжтэй болгох, даалгавар өгөх, түүнийг нь компьютераар эсвэл бусад суралцагчдаар дүгнүүлэхэд” гол анхаарлаа

86 Yuan, L. and Powell, S. 2013. *MOOCs and Open Education: Implications for Higher Education – A White Paper*. («Нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээл ба нээлттэй боловсрол: Дээд боловсролд үзүүлэх үр дагавар – Цагаан ном»). Centre for Educational

Technology, Interoperability and Standards. <http://publications.cetis.ac.uk/2013/667> [2015 оны 2-р сард авав].

87 Daniel, J.S. 2012. Making Sense of MOOCs: Musings in a Maze of Myth, Paradox and Possibility. *Journal of Interactive Media in Education*. Vol. 3, No. 18. <http://jime.open.ac.uk/article/view/259> [2015 оны 2-р сард авав].

хандуулдаг учраас сургах арга барил нь хоцрогдсон гэж шүүмжилдэг⁸⁹. Тодорхой хувь хүний хувьд амьд харьцаа, харилцан ярилцлага дутагддаг тул түүний хэрэгцээг бүрэн хэмжээгээр хангахад хүндрэлтэй болгодог⁹⁰. Үүний нэг адил, нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээлүүдийг үзэж байгаа оюутны үнэлгээ баталгаа муутай буюу эсвэл шаардлага хангадаггүй. Хэдийгээр боловсролын байгууллагууд нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээлүүдийн кредитийг тооцож, тоон таних тэмдэг зэрэг үнэлгээний шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлж эхэлж байгаа ч түүнийг сургалтын бүрэн хэмжээний хэлбэр, мэдлэгийн үнэлгээний хангалттай үзүүлэлт гэж үзэхгүй хэвээр байна⁹¹. Ийм шүүмжлэлүүд бөмбөрцгийн хойд хэсгийн орнуудын их сургуулиудад илүү хамаатай байж болох ч нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээлүүд бөмбөрцгийн өмнөд хэсгийн орнуудын хүн амын янз бүрийн бүлгийн төрөл бүрийн хэрэгцээг хангаж чадах юм.

12. Дээд боловсролын уламжлалт хэлбэрийн дараах үе рүү шилжих зам

Дээд боловсролын байгууллага бол гол төлөв 18–22 насны хүмүүс амьдралдаа нэг удаа очиж, 4 жилийн сургалтыг шулуун замаар туулж өнгөрөөдөг газар гэж бид ойлгодог. Хичээлийн танхим, багш нарыг мэдээллийн үндсэн эх сурвалж, оюутны хотхоныг суралцах үйл ажиллагааны төв гэж үздэг.

Гэсэн хэдий ч энэ дүр зураг хурдтай өөрчлөгдөж байна. Өнөөдөр мэдээлэл солилцох чадвар, шүүмжлэлт сэтгэлгээний чадварыг боловсролын байгууллагад суралцах замаар бус, албан бус бие даасан сургалтын аргаар хялбар эзэмшихийг мэргэжил бүхэн шаардаж байна.[...] Үүнтэй нэг адилаар зайн болон онлайн сургалтын шинэ аргууд нь оюутны суралцах үйл ажиллагааны төрх байдлыг тэр тусмаа их сургуулийн хотхонд сурах явдлыг үндсээр нь өөрчилж байна.

Эх сурвалж: Butcher, N. and Hoosen, S. 2014. *A Guide to Quality in Post-Traditional Online Higher Education*. Dallas, TX, Academic Partnerships.

Их сургуулийн уламжлалт загварын зарим асуудлууд

Өнөөдрийн дээд боловсролын салбар дахь гол асуудлын нэг бол судалгаа шинжилгээний ажилд сургахын сацуу эрдэм шинжилгээний ажлаар дамжуулан сургах үндсэн үүргээ хадгалахын хамт нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх дэлхий дахины асар их эрэлт хэрэгцээг хангахад оршиж байна. Дэлхий нийтээр өсөн нэмэгдэж буй өрсөлдөөний нөхцөлд дээд боловсролын байгууллагууд ба нийгэм хоорондын харилцааг тодорхойлж байдаг нийгмийн гэрээг дахин авч үзэх шаардлагатай болж байна. Энэ нь их сургуулийн боловсролын

Дэлхий нийтээр өсөн нэмэгдэж буй өрсөлдөөний нөхцөлд дээд боловсролын байгууллагууд ба нийгэм хоорондын харилцааг тодорхойлж байдаг нийгмийн гэрээг дахин авч үзэх шаардлагатай болж байна.

ирээдүйн загварын талаар үндсэн хэд хэдэн асуудлуудыг гаргаж тавьдаг.

88 Butcher, N. and Hoosen, S. 2014. *A Guide to Quality in Post-Traditional Online Higher Education*. («Уламжлалт бус онлайн дээд боловсролын системд чанарын баталгааг хангах гарын авлага»). Dallas, TX, Academic Partnerships. www.icde.org/filestore/News/2014_March-April/Guide2.pdf [2015 оны 2-р сар.].

89 Bates, T. 2012. *What's right and what's wrong about Coursera-style MOOCs?* («Coursera төрлийн Нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээлийн платформын давуу ба дутагдалтай талууд»). www.tonybates.ca/2012/08/05/whats-right-and-whats-wrong-aboutcoursera-style-moocs [2015 оны 2-р сард авав.].

90 Daniel, түүний дээрх бүтээлийг хар.

91 Bates, түүний дээрх бүтээлийг үз

92 Marope, P.T.M., Wells, P.J. and Hazelkorn, E. 2013. *Rankings and Accountability in Higher Education: Uses and Misuses*. («Дээд боловсролын чансаа ба хариуцлага: давуу ба сул талууд»). Paris, UNESCO.

Боловсролын байгууллага, бусад бүтцийн төрөл олширсон, дээд боловсролын салбарт үйлчилгээ, тухайлбал дээр дурдсан нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээлүүд дэлгэрснээр олон улсын шинж чанартай болсон, чанарын үнэлгээ ба нийгмийн шаардлага хангасан сургалтыг нэхсэн шинэ соёл бий болж байгаа, төр-хувийн хэвшлийн түншлэл өсөн нэмэгдэж байгаа зэргээс хамаарч дээд боловсролын дүр төрх өөрчлөлт шинэчлэлийн шатандаа явж байна. Энэхүү өөрчлөлтүүд нь санхүүгийн ба хүний нөөцийн үүднээс авч үзвэл ноцтой үр дагавартай бөгөөд боловсролын удирдлагын тогтсон хэлбэрүүдийн талаар асуудал тавьж, их сургуулийн уламжлалт загварын үндэс суурь болсон бие даасан байдал, академик эрх чөлөөний асуудлын талаар санаа зовоход хүргэж байна.

Их сургуулиудын чансаа: давуу ба сул тал⁹²

Их сургуулийн чансааг тогтоох явдал бол дээд боловсролын интернационалчлал, дээд боловсролын байгууллагуудын сургалтын чанарыг харьцуулан харах талаар өсөн нэмэгдэж буй сонирхол зэрэг чухал хандлагыг илэрхийлж байна. Их сургуулийн чансааны талаарх сонирхол ихээхэн өссөн ч, их сургуулийн эрдэмтэд, оюутнууд, боловсролын үйлчилгээ үзүүлэгчид, бодлого тодорхойлогчид, хөгжлийн салбарын байгууллагуудын зүгээс нэлээдгүй шүүмжлэл гарч байна. Нэг талаас дээд сургуулиудын “чанарын” талаар хүртээмжтэй, зохимжтой бөгөөд харьцангуй энгийн хэлбэрээр нэгтгэсэн мэдээллийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг их сургуулийн чансаа хангаж байна.

Дээд боловсролын цар хүрээ өргөн олныг хамрах болсон, харгалзах үйлчилгээ үзүүлэгчдийн зах зээл эрчимтэй өсөж байгаа нөхцөлд их сургуулиудын талаар үндэслэлтэй сонголт хийж шийдвэр гаргах хэрэгцээ ийм чансааны талаарх эрэлт хэрэгцээг улам хөөрөгдөж байна. Түүнээс гадна чансаа тогтоох нь дээд боловсролын байгууллагуудын мэдээллийг илүү ил тод болгох, тайлан тооцоог дээшлүүлэхэд хувь нэмэр оруулсан гэж олон хүмүүс боддог. Нөгөө талаас, их сургуулиудын чансаа тогтоох нь тэдний анхаарлыг сургалтын чанар, нийгмийн хариуцлагын асуудлаас холдуулж, чансаа тогтооход хэрэглэдэг тодорхой үзүүлэлтүүдэд нөлөө үзүүлэх эрдэм шинжилгээний явцуу чиглэлүүд рүү анхаарлаа төвлөрүүлэхэд хүргэдэг. Дэлхийн хэмжээнд их сургуулиудад хязгаарлагдмал тооны шалгуур хэрэглэж, шилдэг 200 их сургуулийн тоонд орох хүсэл эрмэлзлэлийг хөөрөгдснөөр их сургуулиудын хоорондын ялгааг тэгшлэн, тэднийг оршин байгаа нөхцөл байдалдаа анхаарал бага хандуулж, уян хатан биш болгож байгаад тэд санаа зовж байгаагаа илэрхийлж байна. Их сургуулийн чансаа нь шилдэг 200 их сургуульд давуу тал эдлэх таатай боломж олгодог учраас тэгш байдлыг хангах талаас чухал асуудал юм.

■ Мэдлэгт суурилсан нийгэмд багшийн үүрэг

Тоон технологи багшийг орлохгүй⁹³

Мэдээлэл, мэдлэгийн хуримтлагдсан хэмжээ асар их өсөж байгаа нь түүнийг хувь хүн ба хэсэг бүлэг, олон түмэнд дамжуулах, түгээх, эзэмших үр дүнтэй аргыг шаардаж байна. Мэдээлэл, холбооны технологийн боломжийг анхаарч үзвэл өнөөдөр багш хүн сурагчиддаа бага наснаас нь эхлэн амьдралынх нь туршид мэдлэгийн байнга

93 Marope, P.T.M., Wells, P.J. and Hazelkorn, E. 2013. *Rankings and Accountability in Higher Education: Uses and Misuses*. («Дээд боловсролын чансаа ба хариуцлага: давуу ба сул талууд»). Бүтээлийн материалд тулгуурлав. Paris, UNESCO.

өсөн нэмэгдэж байгаа ээдрээтэй замаар урагшлан хөдлөхөд туслах хөтөчийн үүргийг гүйцэтгэх ёстой. Энэ нөхцөл байдалд

Мэдээлэл, холбооны технологийн боломжийг анхаарч үзвэл өнөөдөр багш хүн сурагчиддаа бага наснаас нь эхлэн амьдралынх туршид мэдлэгийн байнга өсөн нэмэгдэж байгаа ээдрээтэй замаар урагшлан хөдлөхөд нь туслах хөтөчийн үүргийг гүйцэтгэх ёстой.

тоон шинэ технологи аажмаар багшийг орлож, боловсролын хүртээмжийг дээшлүүлж, улмаар хөрөнгө мөнгө, нөөцийг хэмнэх хувь тавилантай гэж зарим хүмүүс эхэндээ тааварлаж байсан. Гэсэн хэдий ч эдгээр таамаглал одоогоор батлагдаагүй байна. Багшийн ажлын үр өгөөжийг мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдүүлэхийг урьдын адил бүх улс

орны боловсролын бодлогын тэргүүлэх чиглэл байлгах ёстой.

Багш нарын мэргэжлийн түвшинг бууруулахгүй байх нь

Хэрэв хувь хүн өөрийн мэдлэг чадвараа бүрэн нээж, ашиглах, хөгжлийн шинэ загварыг бэхжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулах ёстой бол багш сурган хүмүүжүүлэгчид боловсролын үйл ажиллагаанд гол үүрэгтэй хэвээр байна. Багшийн үүрэг ач холбогдлын талаар яриа маргаан давамгайлах хандлагатай байгаа ч бөмбөрцгийн хойд ба өмнөд хэсгийн орнуудын аль алинд багш нарын мэргэжлийн түвшин буурах чиг хандлага гарч байна. Эдгээр хандлагад багшлах боловсон хүчин дутагдалтай байдал, санхүүгийн шалтгааны улмаас шаардлага хангахгүй багш нар олноор орж ирэх, багш нарыг орон тооноос гаргаж боловсролын үйлчилгээ үзүүлэх гэрээгээр цагаар багшлах хэлбэрт шилжүүлэх, ялангуяа дээд боловсролын салбарт сургалтын ачаалал нэмэгдэж буй нөхцөлд цагийн багшийг татан оролцуулцах явдал газар авах болсон, багш нарыг шийдвэр гаргахад оролцуулахыг хязгаарлах болсон, стандарт сорил, мэргэжлийн шалгалтын үр дүнгээр ажлын чанарыг үнэлэх болсонтой уялдан хичээл заах ажлын чанар буурсан, хувийн секторт ашигладаг удирдлагын арга барилыг боловсролын байгууллагуудад нэвтрүүлсэн, олон оронд ажиглагдаж байгаа багш нар ба бусад салбарын мэргэжилтнүүдийн хөдөлмөрийн цалин хөлс, урамшууллын хоорондох ялгаа зэрэг олон чиг хандлага багтаж байна.

13. Финляндад багш нарыг өндөр түвшинд бэлтгэж, багшийн мэргэжил өндөр нэр хүндтэй байдаг

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)–аас явуулдаг сурагчдын мэдлэгийн олон улсын үнэлгээний хөтөлбөр (PISA)–ийн дагуу 15 насны сурагчдын дунд унших, тоо бодох, байгалийн шинжлэх ухааны хичээлүүдийн мэдлэгээр хамгийн өндөр үзүүлэлттэй орнуудын нэг бол Финлянд юм. Энэ амжилтыг олон хүчин зүйлээр тайлбарлаж болох бөгөөд юуны өмнө Финлянд улсад багш нарыг мэргэжлийн өндөр түвшинд чанартай бэлтгэдэг, багшийн мэргэжилд хүндэтгэлтэй ханддаг явдалтай шууд холбоотой. Энэ улсад багшлах ажил бол нэр хүндтэй ажилд тооцогддог бөгөөд финляндын нийгэм үндэснийхээ боловсролын системд болон түүнд ажиллаж байгаа багш нартаа бүрэн итгэдэг байна. Тэдний багш нар бол өндөр мэдлэг чадвартай байдаг (багшийн орон тоонд ажиллахын тулд доод тал нь магистрийн зэрэг шаарддаг). Багш шалгаруулах ажил нь маш нарийн үйл ажиллагаа бөгөөд хамгийн сайн өрсөлдөгч нь багшлах эрх олж авдаг байна. Багш нар сургалтын агуулга, заах аргын талаар гүнзгий мэдлэгтэйн дээр бие даасан, туршлагатай эрдэм шинжилгээний шинжээчид байдаг.

Эх сурвалж: Niemi, H., Toom, A. and Kallioniemi A. (eds). 2012. *Miracle of Education: The Principles and Practices of Teaching and Learning in Finnish Schools*. (Боловсролын гайхамшиг: Финляндын сургуульд хичээл заах, сургах арга зарчим). Rotterdam, Sense Publishers.

Тийм учраас, боловсролын агуулга, зорилгыг болон багш бэлтгэх талаар дахин бодож үзэх ёстой болж байна. Мэдлэг эзэмших үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хүрээлэн байгаа ертөнцийн олон талт байдлыг ойлгох, боловсролын үйл ажиллагааны хүртээмжтэй байдлыг хангах, энэ дэлхий дээр хамт амьдрах, хүрээлэн буй орчноо хамгаалж, сайжруулах чадварыг хэвшүүлж чаддаг байхаар багш нарыг бэлтгэх ёстой. Багш нар анги танхимыг тайван, бие биенээ хүндэлсэн орчин болгох, суралцагчдын бие даасан байдал, өөрийгөө хүндлэх чадварыг урамшуулахын дээр сурган хүмүүжүүлэх ба сургах арга зүйн тал бүрийн арга барилыг ашигладаг байх ёстой. Багш нар бол эцэг эх, олон нийттэй үр бүтээлтэй харилцаж чаддаг байх ёстой. Тэд сургуулийнхаа эрх ашгийн төлөө хамт ажилладаг бусад багш нартайгаа нэг баг болон ажиллах шаардлагатай. Багш өөрийн сурагчид, тэдний гэр бүлийнхний талаар мэддэг байхын хамт сургах үйл ажиллагааг тэдний тодорхой нөхцөл байдалтай уялдуулан явуулах чадвартай байх хэрэгтэй. Тэд тухайн нөхцөл байдалд холбогдох агуулга бүхий материалыг сонгох, түүнийгээ зохих чадамжийг хөгжүүлэхэд үр дүнтэй хэрэглэх чадвартай байх ёстой. Мөн технологийг бусад материалуудтай хамт сурах хэрэгсэл болгон ашиглах чадвартай байх ёстой. Багш нар мэргэжлээ байнга дээшлүүлж, үргэлжлүүлэн суралцаж байхыг дэмжих хэрэгтэй юм.

Багш нарт илүү сонирхол татсан, урам хайрласан, тогтвортой амьдралын болон ажиллах нөхцөл, цалин хөлс, ажил дээрээ өсөж дээшлэх боломжийг санал болгох ёстой. Энэ нь манай дэлхий дээр байгаа хамгийн чухал гэж үздэг мэргэжилд хандах сонирхлыг сулруулах аюулыг зайлуулахад маш чухал юм.

Багш нарт илүү сонирхол татсан, урам хайрласан, тогтвортой амьдралын болон ажиллах нөхцөл, цалин хөлс, ажил дээрээ өсөж дээшлэх боломжийг санал болгох ёстой. Энэ нь манай дэлхий дээр байгаа хамгийн чухал гэж үздэг мэргэжилд хандах сонирхлыг сулруулах аюулыг зайлуулахад маш чухал юм. Дэлхий даяар байнга өөрчлөгдөж байгаа боловсролын салбарын зорилго, шинэ шаардлагыг харгалзан багшийн албан тушаалд өсөж дэвших нөхцөл, зорилго шинэчлэгдэж байх ёстой. Үүнтэй уялдан ерөнхий суурь боловсролоос хамгийн нарийн мэргэжил хүртлэх бүх шатанд багш бэлтгэхдээ мэргэжил хоорондын уялдааг хангах санааг бүрэн тусгах хэрэгтэй. Мэргэжил хоорондын уялдааг хангах хандлага нь байгалийн болон соёлын нийтлэг өвийг хүндэтгэх үндсэн дээр бүх нийтийн хөгжил дэвшлийн хүмүүнлэг үзэлд чиглэсэн бүтээлч бөгөөд оновчтой зам руу биднийг хөтлөхөд багш нарт тусалж чадах юм.

Дээд боловсролын салбар дахь мэргэжлийн үйл ажиллагааны гол асуудлууд

Дэлхий даяар их сургуулийн багш нарын ажиллах нөхцөл, нийгмийн үнэлэмж нь дээд боловсролын хүртээмж өргөжиж тэлсэн, нөгөө талаас төсвийн хэмжээ хязгаарлагдаж эхэлсэн зэргээс хамаарч санаа зовоох болж байна. Энэ мэргэжлийн хүмүүс янз бүрийн бүс нутагт янз бүрийн бэрхшээлтэй тулгарч байгаа бөгөөд ялангуяа их сургуулийн профессор багш нар хаа сайгүй хамгийн их хүндрэлтэй учирч байна. Дээд боловсролын хүртээмж өргөжиж тэлсэн нь их сургуулийн багш нарын хэрэгцээг гэнэт асар их хэмжээгээр бий болгосон. Гэвч энэхүү хэрэгцээний дагуу их сургуульд шаардлагатай боловсон хүчин бэлтгэх ажил хоцрогдож байна. Зарим тооцоогоор өнөөдөр ажиллаж

байгаа их сургуулийн багш нарын тал хувь нь дөнгөж бакалаврын зэрэгтэй байна. Дэлхийн олон оронд их сургуулийн багш нарын тэн хагас нь тэтгэврийн насанд ойртсон байна.

Их сургуулийн багшийн хөдөлмөрийн үнэлгээ хангалтгүй учраас докторын зэрэг горилогчдын дийлэнх нь докторын сургалт эрдэм шинжилгээний ажлаа орхих, эсвэл их сургуулийн үйл ажиллагаатай огт холбоогүй ажил эрхлэх болсноор их сургуульд шинээр орж байгаа эрдэмтдийн тоо тэтгэвэрт гарч буй профессоруудын тоог нөхөж чадахгүй байна. Латин Америкийн олон оронд дээд боловсролын салбар дахь багш нарын 80 хүртэлх хувь нь цагийн буюу орон тооны бус багш байна. Энэ байдал нь дээд сургуулийн багш нар багшлах ажилдаа бүрэн анхаарлаа зориулж чадахгүй байдгаас сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна. Ийм багш нарын хувьд эрдэм шинжилгээний ажлын талаар ярих нь утгагүй юм. Түүнээс гадна сүүлийн жилүүдэд их сургуулийн багш нарын дэлхийн хэмжээний зах зээл бий болсон нь их сургуулийн багш нар олон улсын хэмжээнд шилжин ажиллах боломжтой болсон. Ийм шилжилт хөдөлгөөнийг хөдөлгөгч гол хүчин зүйл нь илүү сайн хөдөлмөрийн хөлсний нөхцөл юм. Түүнээс гадна, ажлын байрны таатай нөхцөл, ялангуяа судалгааны сайн дэд бүтэц, ажил мэргэжилдээ өсөх боломж, академик эрх чөлөө зэрэг орж байна. Дараагийн хэсэгт илүү дэлгэрэнгүйгээр авч үзэх “оюуны гадагшлалт”, “чадварлаг боловсон хүчний солилцоо” зэрэг нийгмийн эдгээр үзэгдлүүд нь дээд боловсролын салбарын бодлого боловсруулах, үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл үүсгэж байна.

Албан боловсролын сектороос гадуур ажиллаж байгаа багш нар

Эцэст нь албан боловсролын системээс гадуур насан туршийн боловсрол олгох чиглэлээр ажиллаж байгаа багш нарын гүйцэтгэж буй онцгой үүргийг бид дурдах ёстой. Албан бус боловсрол олгох ажлыг хангадаг янз бүрийн байгууллагуудад ажиллаж байгаа багш нарт зориулсан сургалтын хөтөлбөрүүд дэлхий дахинаа олширч байгаа нь тэдгээр багш нарын үүрэг роль чухал болохыг харуулж байна. Ийм багш нар олон нийтийн төвүүд, шашны байгууллагын дэргэд, техник мэргэжлийн сургалтын төвүүдэд ажилладаг бөгөөд тухайлбал, бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрт оролцож, залуучууд сайн дурын холбоод урлаг спортын хөтөлбөрүүд дээр ажилладаг байна. Боловсрол олж авах ийм боломжууд нь хувь хүн болон нийгмийн хөгжил, сайн сайхан аж байдлын үүднээс авч үзвэл ихээхэн үнэ цэнэтэй байдаг.

Албан боловсролын системээс гадуур насан туршийн боловсрол олгох чиглэлээр ажиллаж байгаа багш нарын гүйцэтгэж буй онцгой үүргийг бид дурдах ёстой.

3. Нарийн төвөгтэй болж буй өнөөгийн нийгэмд боловсролын бодлого боловсруулах нь



3. Нарийн төвөгтэй болж буй өнөөгийн нийгэмд боловсролын бодлого боловсруулах нь

Даяаршлалын үйл явц улс үндэстнүүдийн бие даан улс орноо удирдахад бэрхшээл учруулж, улмаар төрийн бодлого боловсруулах үйл явцыг илүү төвөгтэй болгож байна. Тухайлбал, эдийн засгийн үйл ажиллагаа илүү ихээр даяаршлын шинжтэй болж байгаа боловч улс төрийн шийдвэр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ урдын адил үндэсний хэмжээнд явагдсан хэвээр байна. Тийм учраас үндэсний түвшинд улс төрийн шийдвэр гаргагчдын хувьд үндэсний хөгжилд даяаршлын үр дагаврыг тусгах, түүнийг зохицуулахад улам бүр хүндрэлтэй болж байна. Ийм дүгнэлтийг батлах нэг жишээ бол 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын үр дагавар, эсвэл залуучуудын дунд ажилгүйдэл тэр тусмаа дэлхийн бөмбөрцгийн Хойд хэсгийн улсуудад өссөн явдал юм. Үүний нэг адил суралцагчид, ажилчдын хил дамнасан шилжилт хөдөлгөөн, “оюуны солилцоо” (өндөр мэргэжилтэй боловсон хүчний шилжилт хөдөлгөөн)-ий шинэ загвар, иргэдийн оролцооны шинэ хэлбэрүүд зэрэг нь үндэсний хэмжээнд бодлого боловсруулахад шинэ хүндрэлүүдийг бий болгож байна. Энэ бүлэгт бид боловсролын салбарын бодлого боловсруулахад энэ бүх үзэгдэл хэрхэн нөлөөлж байгааг жишээ баримттай авч үзнэ.

■ Боловсрол, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний хоорондын өсөн нэмэгдэж буй зөрүү

Хөдөлмөр эрхлэлтийн өсөлт буурч, эмзэг байдал өсөж байгаа нь

Эдийн засгийн даяаршил эрчимжиж байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн өсөлтийг бууруулж, залуучуудын дунд ажилгүйдэл болон тогтвортой биш ажил эрхлэлтийг өсгөх дүр төрхийг бий болгож байгаа учраас бөмбөрцгийн Хойд болон Өмнөд орнуудын аль алинд сөргөөр нөлөөлж байна. Хөдөлмөр эрхлэлтийн өсөлт буурч байгаа хандлага Европын зарим оронд нөлөөлөх болсон бөгөөд эдгээр орнуудад шинэ үеийн залуучууд хөдөлмөрийн зах зээлд оройтож орох, эсвэл огт орж чадахгүй байх асуудалтай тулгарч байна. Боловсрол, сургалтаар олж авсан ур чадварууд ба хөдөлмөрийн зах

зээлийн эрэлт хэрэгцээний шүтэлцээг тохируулах асуудал шинэ биш бөгөөд урьд өмнө ч байсан гэдгийг санах хэрэгтэй⁹⁴. Түүнээс гадна залуучуудын ажилгүйдэл бол нэг талаас, боловсролын салбарын нийлүүлэлт, мэргэжлийн бэлтгэл, нөгөө талаас хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагын шүтэлцээ алдагдсныг харуулахын зэрэгцээ эдийн засгийн бодлогын хүрээнд гаргасан шийдвэрүүд, эрх баригчдын улс төрийн хариуцлагатай холбоотой юм. Гэсэн хэдий ч, хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн чиг хандлага нь олон улсын хөгжлийн онол практик хүний нөөцөд хөрөнгө оруулахад тулгуурлах болсныг үндэслэн албан боловсрол ба хөдөлмөрийн зах зээл хоорондын уялдаа холбооны талаарх бидэнд тогтож бий болсон ойлголтыг эргэж харах асуудлыг тавих болсон.

Залуучуудын урам улам хугарч байна.

Ажлын байрны тоо хумигдаж байгаа нь дэлхий даяар эцэг эхчүүд болон их дээд сургууль төгсөгч залуучуудын урмыг улам ихээр хугалах шалтгаан болж байна. Залуучууд, ажилчдын боловсролын түвшин өсөж байгаа явдал ажлын байрны төлөөх өрсөлдөөнийг нэмэгдүүлж байна. Ялангуяа, бөмбөрцгийн Өмнөд хэсгийн олон улс оронд хумигдаж буй хөдөлмөрийн зах зээл рүү өөрсдийн нутаг орондоо боловсролын хүртээмж өссөний ач тусыг хүртсэн залуучуудын давалгаа бусдаас өрсөн түрэн орж ирснээр албан боловсрол олж авснаар бий болсон хүлээлт, ажлын байрны хомсдолтой бодит байдлын хоорондын зөрүүтэй байдлыг улам ихээр даамжруулж байна. Албан ёсны боловсрол олж авч байгаа залуучуудын дийлэнх хэсэг нь дипломтай болсноор ажил хялбар олж авах, ирээдүйдээ илүү итгэлтэй байх зэрэг давуу талаа ашиглаж, түүний ачийг хүртэж чадахгүйд хүрч байна.

Нийгмийн зарим анги, давхарга тэр ч байтугай, зарим улс орны хувьд нийгмийн байр сууриа ахиулах, сайн сайхан аж амьдралын бодит хүчин зүйл нь боловсрол гэдэгт итгэх итгэл алдрах явдал нэмэгдэж байна. 1990-ээд оноос хойш боловсролын хүртээмж эрс нэмэгдсэнтэй уялдан нийгэм дотор өсөн дэвших талаарх итгэл найдвар бөмбөрцгийн Өмнөд хэсэгт төдийгүй Хойд хэсгийн олон оронд унтарч эхэлсэн байна. Ирээдүйд “илүү дээгүүр байр суурь”-т хүргэх гол түлхүүр бол боловсрол гэж үздэг уламжлалт ойлголтоос татгалзаж, түүнд оруулсан “хөрөнгө оруулалтын өгөөж”-ийн тухай асуулт тавих болж байна⁹⁵.

Үүний зэрэгцээ залуучууд боловсролоос ажил хөдөлмөрийн салбар руу шилжих үед явагдаж байгаа үйл явцыг анхааралтай судалж, сайтар ойлгох явдал чухал болж байна. Энэ шилжилтийн үе удаашралтай явагдаж байгаа нь боловсролоор олж авсан ур чадвар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ хоёрын хоорондын уялдаа шүтэлцээний зөрүүтэй тэр бүр холбоогүй бөгөөд өөр олон янзын шалтгаантай байдаг. Хэдийгээр эдийн засгийн талаас шилжилтийн энэ үе үр ашиггүй байж болох ч, зарим

Нийгмийн зарим анги, давхарга, тэр ч байтугай, зарим улс орны хувьд нийгмийн байр сууриа ахиулах, сайн сайхан аж амьдралын бодит хүчин зүйл нь боловсрол гэдэгт итгэх итгэл алдрах явдал нэмэгдэж байна.

94 Тухайлбал дараах жишээг үз: Blaug, M. 1965. The Rate of Return on Investment in Education in Great Britain. («Их Британид боловсролд хийсэн хөрөнгө оруулалтын үр өгөөж») *The Manchester School*. Vol. 33.

95 Facer, K. 2011. *Learning Futures: Education, Technology and Social Challenges*. («Боловсролын хэтийн төлөв: Боловсролын, технологийн, нийгмийн асуудлууд») New York, Routledge.

залуучуудын хувьд энэ нь олон нийтийн болон сайн дурын хөдөлгөөнд оролцох, аялалд явах, чөлөөт цагаараа урлаг болон бусад үйл ажиллагаанд оролцох замаар сурах чухал үе болж өгдөг. Түүнээс гадна боловсролтой залуучууд ажилгүй байсан ч гэсэн иргэний, нийгмийн, улс төрийн үйл ажиллагааны тэргүүн эгнээнд орж ирж болох юм.

Боловсрол ба хурдацтай өөрчлөгдөж буй хөдөлмөрийн ертөнцийн хоорондох холбоог эргэцүүлэн тунгаах нь

Албан боловсрол ба хөдөлмөрийн зах зээлийн хоорондох харилцан уялдаагүй байдлыг шийдэх талаар ажилчдыг давтан сургах, “хоёр дахь боломж” олгох хөтөлбөр, үйлдвэрлэлийн салбартай түншлэлийн холбоог бэхжүүлэх зэрэг тодорхой арга хэмжээнүүдийг авч байна. Мөн сонгосон мэргэжлээс харгалзан ажил мэргэжилд дасан зохицох чадварыг хөгжүүлэхэд илүү анхаарал хандуулах болсон нь харагдах боллоо. Үнэн хэрэгтээ, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хурдац нь шинээр гарч ирэх мэргэжил, түүнтэй холбоотой ур чадваруудыг урьдчилан таамаглах ажлыг хүндрэлтэй болгож байна. Энэ нь илүү уян хатан боловсролын систем бий болгох, хурдацтай өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагад мэргэжлийн мэдлэгийг хэрэглэх тал бүрийн ерөнхий дадал чадварыг хөгжүүлэхэд түлхэц болох, ажилтан хүн гадны нөхцөл байдалд илүү уян хатан зохицох, өөрийгөө үр дүнтэй хөгжүүлэх чадвартай, тодорхой мэргэжлийн ажилд шаардлагатай мэргэшлийн ур чадварыг амьдрал дээр хэрэгжүүлэх чадвартай байхыг шаардана⁹⁶. Ийм ур чадварын тоонд харилцааны соёл, цахим цагаан толгой, асуудал шийдвэрлэх чадвар, хамт олонтой багаар ажиллах, энтрепренер байх зэрэг “дамжуулж болох чадвар”, “хорин нэгдүгээр зууны чадвар”, “когнитив бус чадвар” гэж янз бүрээр нэрлэгддэг ур чадварууд орно.

14. Залуучуудын хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлэх нь

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлын нарийн төвөгтэй байдлыг анхааралдаа авахын зэрэгцээ хэрэв гол сонирхогч талууд иж бүрэн боловсруулсан стратеги, амлалтын хүрээнд нэгдэж чадахгүй бол санал болгож буй шийдэл нь ач холбогдол бага байдгийг ихэнхдээ тэмдэглэдэг. Дэлхийн янз бүрийн орнуудад үйлдвэрлэлийн янз бүрийн салбаруудын ажилд илүү үр дүнд хүрэх талаар хамтын чармайлт гаргаж байгаа нь харагдсан.

Өмнөд Африкт 18–28 насны гурван хүний хоёр нь ажилгүй байдаг бөгөөд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг эрчимжүүлэх зорилго бүхий “Харамби” төсөл хэрэгжүүлж бага орлоготой залуучуудыг сонгон хувийн секторт анхны ажлаа олоход нь “гүүр” болж тусалж байна. Хэдийгээр хамрах хүрээний хувьд одоогоор бага боловч энэ санаачилга бол хувийн секторын оролцооны сайн жишээ болж байна. Өмнөд Африкийн жижиглэнгийн худалдаа, зочид буудал, аялал зуучлалын зарим том компаниуд энэ төслийн түнш болж, ажлын байрны баталгаа гаргаж өгөх болжээ. Өмнөд Африкийн хөгжлийн банк Харамби төслийн хамрах хүрээг өргөжүүлэхэд зориулж, хувийн хөрөнгө оруулагчид, ажил олгогчдын хураамжаас бүрдсэн ажлын байрны фонд байгуулжээ.

Коста-Рикагийн технологийн компаниудын аж үйлдвэрийн холбоо /CAMTIC/ мэдээллийн технологийн салбарт байгаа хэдэн мянган сул ажлын байрыг дүүргэхэд чиглэсэн “Мэргэжилтэн” хөтөлбөр хэрэгжүүлж,

96 UNESCO. 2011. *Education and Skills for Inclusive and Sustainable Development Beyond 2015*. («2015 оноос хойших тогтвортой хүртээмжтэй хөгжлийг хангах боловсрол ба ур чадвар.»). 2015 оноос хойших хөгжлийн хөтөлбөр боловсруулах НҮБ-ын ажлын хэсэгт зориулж бэлтгэсэн материал. Paris, UNESCO.

эмзэг давхаргын залуучуудыг мэдээллийн технологийн шаардлагатай ур чадварт сургаж байна. Cisco, Microsoft зэрэг компаниудаас мэдээллээ авдаг боловсролын байгууллагууд програмчлалын ур чадвар, хэл, техникийн зохих бэлтгэлийг олгох батламжлагдсан бэлтгэл курс нээж, улмаар тухайн орны цалингийн доод хэмжээнээс гурваас тав дахин их цалинтай ажлын байранд орох боломжийг олгож байна.

Эх сурвалж: Banerji, A., Lopez, V., McAuliffe, J., Rosen, A., and Salazar-Xirinachs, J.M., with Ahluwalia, P., Habib, M., and Milberg, T. 2014. An 'E.Y.E.' to the Future: Enhancing Youth Employment. *Education and Skills 2.0: New Targets and Innovative Approaches*. (Ирээдүй рүү харах: Залуучуудын ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх. Боловсрол ба ур чадвар 2.0: Шинэ зорилго бүтээлч хандлага) Geneva, World Economic Forum.

Үүнтэй холбоотойгоор хэд хэдэн чухал асуулт гарч ирж байна. Боловсрол ба ажил эрхлэлтийн хоорондын уялдаа холбоог хэрхэн бэхжүүлэх вэ? Өнөөгийн нөхцөлд боловсрол, сургалтын эдийн засгийн ба нийгмийн үнэ цэнийг хэрхэн нэмэгдүүлэх вэ? Залуу үеийнхний амьдрал, тэдний хөдөлмөр эрхлэх хэтийн төлөвт боловсрол, ялангуяа дунд боловсролыг хэрхэн илүү мэдрэмтгий болгох вэ? Одоо авч байгаа арга хэмжээнүүд хангалттай байна уу? Эцэст нь, энэ асуудлын шийдэл бол ажлын шинэ байр бий болгох бөгөөд энэ нь хөдөлмөр эрхлэлтийн талаар нухацтай бодлогыг боловсруулахад төрийн хариуцлагыг дээшлүүлэх гэсэн үг юм. Ажилгүйдлийн асуудлыг боловсрол дангаараа шийдэж чадахгүй. Гол шийдэл бол эдийн засгийн хөгжлийн үндсэн загварыг эргэж харах явдал бөгөөд үүний зэрэгцээ боловсрол ба хөдөлмөрийн зах зээлийн хоорондын уялдаа холбоог эргэцүүлэх боломж гарч ирж байна. Эцэст нь, албан боловсролын системээс гадуур явагдаж байгаа сургалт, давтан бэлтгэлийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Харгалзах ур чадварыг бие даан суралцах, бусадтай хамтран суралцах, ажлын байран дээр сурах (дадлага хийх, дагалдаж ажиллах замаар), ажлын байран дээр мэргэшлийн нарийн ур чадвар эзэмших, сургуульд заадаггүй ур чадварыг хөгжүүлэх, түүнд сургах бусад хэлбэрүүд зэргээр олж авна. Иймээс бид сурах бүх хэлбэрийн боломжийг бүрэн дүүрэн ашиглахын тулд ур чадварыг хөгжүүлэх шинэ хандлагын талаар сайтар бодох ёстой болж байна.

Ажилгүйдлийн асуудлыг боловсрол дангаараа шийдэж чадахгүй.

■ Өнөөгийн хөдөлгөөнт орчинд сургалтыг хүлээн зөвшөөрөх, батламжлах нь

Хүмүүсийн шилжилт хөдөлгөөний өөрчлөгдөж буй хэв загвар

Олон улсын түвшинд болон улс орнуудын дотоодод хүмүүсийн шилжилт хөдөлгөөн урд өмнө түүхэнд байгаагүй дээд түвшиндээ хүрч байна⁹⁷. Өнөөдөр дэлхий дээр

97 Рио+20, НҮБ-ын тогтвортой хөгжлийн асуудлаарх бара хурал. 2012. Migration and sustainable development. (Шилжилт ба тогтвортой хөгжил.) *Rio 2012 Issues Briefs*. No. 15, p. 1.

98 Шилжилт хөдөлгөөний олон улсын байгууллага. 2011. *World Migration Report 2011. Communicating effectively about migration*. (Шилжилт хөдөлгөөний тухай дэлхийн илтгэл 2011 он.) Geneva, International Organization for Migration.

99 ООН. 2011. *Urban Population, Development and the Environment*. (Хотын хүн ам, хөгжил, хүрээлэн буй орчин) New York, United Nations.

100 *Perspectives on Global Development 2012: Social Cohesion in a Shifting World*. (Олон улсын хөгжлийн ирээдүйн хандлага 2012 онд. Өөрчлөгдөж буй ерөнц дэх нийгмийн нягтрал) Paris, OECD.

101 Шилжилт хөдөлгөөний олон улсын байгууллага. 2013. *Migrant, Well-Being and Development. World Migration Report 2013*. (Шилжигчдийн аж байдал. Шилжилт хөдөлгөөний тухай дэлхийн илтгэл 2013 он.) Geneva, IOM; ОЭСР. 2013. *International Migration Outlook 2013*. (Олон улсын шилжилт хөдөлгөөний тойм 2013 г.) Paris. OECD.

оршин суугч 7 хүний нэг буюу ойролцоогоор нэг тэрбум хүн байнгын “хөдөлгөөн”-д байна⁹⁸. Бөмбөрцгийн өмнөд хэсгээс хойд руу чиглэсэн нүүдэл үргэлжлэхийн зэрэгцээ өмнөдөөс өмнөд рүү чиглэсэн нүүдлийн урсгал илүү хурдан нэмэгдэж байгаа бөгөөд ойрын ирээдүйд бүр ч илүү хурдтай нэмэгдэх магадлалтай байна⁹⁹. Түүнчлэн, “эдийн засгийн өсөлтийн газар зүйн өөрчлөлт”¹⁰⁰-ийн үр дүнд ажил эрхлэлт, сайн сайхан амьдрахын тулд бөмбөрцгийн хойд хэсгийн улс орнуудад амьдарч буй хүмүүс өмнөд хэсгийн орнууд руу олноор шилжин суурьшихад түлхэц болж байна¹⁰¹. Хүмүүсийн шилжилт хөдөлгөөний эдгээр өөрчлөгдөж байгаа хэв шинж нь боловсрол, ажил эрхлэлтэнд чухал нөлөөтэй юм.

Оюуны гадагшлалтаас мэргэжлийн боловсон хүчин татахад

Дэлхийн хүн ам зүйн ерөнхий чиг хандлагыг харгалзаж үзвэл дэлхийн ажиллах хүчний дийлэнх нь өмнөд хэсгийн улс орнуудад байдаг. 2030 он гэхэд дэлхийн нийт ажиллах хүчний буюу “дэлхийн авьяаслаг нөөц”-ийн 25%-ийг Энэтхэг улс дангаараа хангана гэсэн тооцоо байна. Оюуны нөөцийн шилжилтийн ийм загвар нь бэлтгэгдсэн ажиллах хүчний дийлэнх хэсэг нь гадаадад ажиллах, амьдрах бодолтой байгаа учраас боловсрол, мэргэшлийн сургалтын төрийн санхүүжүүлэлтэд бэрхшээл учруулж байна. 2012 онд Энэтхэгээс гадагш явсан “хүний нөөц”-ийг 2 тэрбум америк доллараар үнэлсэн байна¹⁰². Мэргэшлийн боловсон хүчнээ гадагш алдах явдал нь тэднийг эргүүлэн татахад бас хүргэж болох юм. Учир нь шилжин суурьшсан хүмүүс очсон улсдаа өөрсдийн холбоог байгуулж, улмаар өөрийн эх орондоо технологи, хөрөнгө оруулалт хийх эх үүсвэр болдог¹⁰³.

15. Бангалор, Хайдарабад хот руу чиглэсэн эргэсэн нүүдэл

Бангалор болон Хайдарабадийг мэдээллийн технологийн салбарт дэлхийд тэргүүлэх хотууд гэж үздэг. 1970–80-аад оны үед Энэтхэг улс өндөр боловсролтой ажиллах хүчнээ “оюуны гадагшлалт” үзэгдлийн үр дүнд барууны орнууд руу, юуны өмнө АНУ руу алдаж байна гэж ярьдаг байжээ. Сүүлийн үед АНУ-д боловсрол олж авсан энэтхэг мэргэжилтнүүд эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн давуу талыг ашиглах зорилгоор олноор эх орондоо буцаж ирэх болсон нь оюуны гадагшлалт эргэж байгааг сүүлийн үеийн мэдээ баримт харуулж байна. Олон улсын хэмжээнд ажиллах өндөр ур чадвартай хүний нөөц Бангалор, Хайдарабад хотын нийгэм эдийн засгийн янз бүрийн салбар болон дэд бүтцэд зэрэг нөлөө үзүүлж, Энэтхэг, АНУ-ын хоорондын харилцаа холбоог бэхжүүлж байна.

Эх сурвалж: Chacko, E., 2007. From brain drain to brain gain: reverse migration to Bangalore and Hyderabad, India's globalizing hightech cities. (Оюуны хүчээ гадагш алдахаас буцааж авах: Энэтхэгийн өндөр технологийн Бангалор, Хайдарабад хот дахь эргэсэн нүүдэл). *GeoJournal*, 68 (2), стр. 131–140.

Ажилчид, оюутнуудын өсөн нэмэгдэж байгаа шилжилт хөдөлгөөн

Өндөр ур чадвартай ажиллах хүчний хил дамнасан шилжих хөдөлгөөн идэвхжихийн зэрэгцээ мэргэжлийн салбарууд дахь ажилчдын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж байгаа

102 Winthrop, R. and Bulcho, G. 2012. *The Talent Paradox: Funding education as a global public good*. (Авьяас: Бүх нийтийн баялаг болох боловсролын санхүүжүүлэлт.) Brookings Institution. www.brookings.edu/blogs/up-front/posts/2012/11/06-funding-education-winthrop [2015 оны 2-р сард авав.].

103 Morgan, W. J., Appleton, S. and Sives, A. 2006. *Teacher mobility, brain drain and educational resources in the Commonwealth*. (Багш нарын шилжилт хөдөлгөөн, оюуны нөөцийн шилжилт, Хамтын нийгэмлэгийн орнууд дахь боловсролын нөөц материал.) Educational Paper No. 66. London, UK Government Department for International Development.

нь ажиглагдаж байна. Өсөн нэмэгдэж буй мэргэжлийн болон хил дамнасан шилжилт хөдөлгөөнд хариулт өгөх үүднээс дэлхийн 140 улс оронд “мэргэшлийн үндэсний чадварын тогтолцоо”-г боловсруулсан байна. Үүнтэй төстэй байдлаар, Европын мэргэшлийн чадварын тогтолцоо дээр үндэслэн бүс нутгийн хэмжээний мэргэшлийн чадварын тогтолцоог боловсруулсан байна. Гэвч шилжилт хөдөлгөөний өсөн нэмэгдэж буй цар хүрээ, өөрчлөгдөж буй хэв загвар нь өндөр ур чадвартай ажилчдын шилжилт хөдөлгөөнийг илүү нарийн төвөгтэй, дэлхийн бүх бүс нутгуудыг хамарсан үйл явц болгож байна.

Үүнтэй нэг адилаар дэлхийн аль ч хэсэгт суралцах чадвартай оюутны тоо 21-р зууны эхний арван жилд эрс нэмэгдсэн ба цаашид ч өсөх хандлагатай байна. Үүний үр дүнд, дээд боловсролын курс, диплом, эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенциуд нь олон улсын шинжтэй болж буй дээд боловсрол болон оюутны өсөн нэмэгдэж буй шилжилт хөдөлгөөнд огт тохирохгүй байна.

Үүнээс гадна, суралцагчдын шилжилт хөдөлгөөн нь нэг боловсролын байгууллагаас нөгөөд шилжихээр хязгаарлагдахгүй болжээ. Энэ нь албан, албан бус болон бусад төрлийн боловсролын байгууллагуудын хооронд явагдаж байгаа суралцагчдын шилжилт хөдөлгөөнийг багтаах болж байна. Үүнтэй уялдан мэдлэг, чадамжийг тэдгээрийг олж авсан арга замаас үл хамааран үнэлэх, баталгаажуулах тухай асуудал гарч ирж байна.

Сурах үйл ажиллагааны өргөн хүрээг хамарсан нарийн үнэлгээ хийх сонирхол: давуу тал ба эрсдэл

Сургалтын агуулга, хөтөлбөрт түлхүү анхаардаг байсан уламжлалаас олж авсан мэдлэгийг үнэлэх хүлээн зөвшөөрөх, батламжлахад шилжиж байна. Үр дүнд чиглэсэн мэргэшлийн чадварын үндэсний болон бүс нутгийн тогтолцоог боловсруулахын дээр насанд хүрэгчдийн ур чадварын түвшинг үнэлэх тухайлбал Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын “Насанд хүрэгчдийн мэдлэгийг үнэлэх олон улсын хөтөлбөр” зэрэг ур чадварын өргөн хүрээтэй үнэлгээ чухал ач холбогдолтой болж байна. Сургалтын чанарын талаар суралцагчид санаа зовох болсон нь сүүлийн хориод жилийн дотор сургалтын чанарын өргөн хүрээтэй үнэлгээний системийн тоо, хамрах хүрээ мэдэгдэхүйц өссөнтэй холбоотой¹⁰⁴. Сургалтын чанарын өргөн хүрээтэй үнэлгээний эдгээр системүүд нь боловсролд төр болон хувийн сектороос хийж байгаа хөрөнгө оруулалтын талаар үндэсний тайлан гаргах, тухайлбал, боловсрол олж авах боломжийн талаас хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийн сургалтын үр дүнд хяналт

Сургалтын агуулга, хөтөлбөрт түлхүү анхаардаг байсан уламжлалаас олж авсан мэдлэгийг үнэлэх хүлээн зөвшөөрөх, батламжлахад шилжиж байна.

104 ЮНЕСКО. 2014. *Teaching and Learning: Achieving quality for all. EFA Global Monitoring Report 2013-2014*. (П Сурах ба сургах: бүх нийтээрээ чанарт хүрэх нь. Бүх нийтийн боловсролын хяналт үнэлгээний дэлхийн тайлан 2013-2014 он.) Paris, UNESCO.

105 Сургалтын хөтөлбөрийн даяарших хандлагын асуудлаар дараах материалыг үз., Baker, D. and LeTendre, G.K. 2005. *National Differences, Global Similarities: World Culture and the Future of Schooling*. (Үндэсний ялгаа, олон улсын ижил төстэй байдал: Дэлхийн соёл, ирээдүйн боловсрол) Stanford CA, Stanford University Press. мөн:ЮНЕСКО. 2013. *Learning in the post-2015 education and development agenda*. (2015 оноос хойших боловсрол хөгжлийн хөтөлбөрт сургалтын асуудлыг тусгах нь) Geneva, IBE UNESCO. Англи, франц, испани, араб хэл дээр бий

шинжилгээ хийхэд үнэтэй хэрэгсэл болдог. Гэвч ийм үнэлгээнүүд нь санаа зовох бас нэг шалтаг болдог. Ийм үнэлгээнүүд нь сургалтыг зөвхөн шалгалт өгөхөд чиглүүлж, улмаар сургалтын хөтөлбөрийг боловсруулахад нэгдсэн хандлага хэрэглэснээр сургалтын чанар, цаг үедээ нийцсэн байдал, олон талт шинж чанарт сөрөг нөлөөдөг¹⁰⁵. Төрийн бодлого гол төлөв сургалтын үр дүнгийн хязгаарлагдмал явцуу үзүүлэлтүүдэд анхаарлаа хандуулдаг. Сурах үйл ажиллагааны өргөн хүрээг хамарсан нарийн үнэлгээг боловсролын бодлого тодорхойлоход мэдээллээр хангахаас өөр зорилгоор тухайлбал, багшийн цалин хөлс, сургуулиудын чансаа тогтооход хэрэглэвэл эрсдэл ихтэй байна.

Насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан системд шилжих нь

Амьдралын турш суралцах үйл ажиллагааны нэг хэсэг бол боловсролын янз бүрийн системд сурч олж авсан мэдлэг, чадамжийг баталгаажуулах, хүлээн зөвшөөрүүлэх явдал юм. Өмнө өгүүлснээр, нийгмийн хөгжил нь боловсролын ач холбогдлыг насан туршид болон амьдралын бүхий л хүрээнд улам бататгаж байна. Энэхүү үзэл баримтлал бол шинэ зүйл биш боловч сурах үйл ажиллагааг иж бүрэн, эрх тэгш, системтэй зохион байгуулах гол арга болохын хувьд ач холбогдлоо хадгалсаар байна¹⁰⁶. Энэ үзэл баримтлалын гол санаа нь бүх насны хүмүүст сурах боломжийг олгох явдал юм¹⁰⁷. Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн нарийн төвөгтэй байдал, өмнө дурдсан мэдээлэл, мэдлэгийн огцом өсөлтийг харгалзан үзвэл насан туршийн боловсрол бол хөдөлмөр эрхлэлтийн шинэ хэв маягийг хангах, хувь хүмүүс, нийгэмд шаардлагатай чадамжийн төрөл, түвшинг эзэмшихэд онцгой чухал юм.

Насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан системийг хэрэгжүүлэх нь боловсрол ба хөдөлмөрийн зах зээлийн орчинд мэдлэг, чадамжийг хүлээн зөвшөөрөх, батламжлах, үнэлэх арга замуудаас хамаарна.

• Үр дүнд чиглэсэн ил тод мэргэшлийн ур чадварын тогтолцоо бий болгох нь

Техник мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар болсон олон улсын III бага хурал (Шанхай, 2012)-аас “Үр дүнд чиглэсэн ил тод сайтар боловсруулсан мэргэшлийн ур чадварын системээр бие даан суралцах үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх уян хатан арга замыг дэмжих” гэсэн зөвлөмжийг энэ зорилгоор дэвшүүлсэн байна.

• Сургалтын үр дүнг хүлээн зөвшөөрөх “олон улсын стандартын түвшин”-г бий болгох

Ажилчдын бүс нутаг дамжсан шилжилт хөдөлгөөн ихээхэн нэмэгдэж байгаа нь дэлхийн түвшинд мэдлэг, чадамжийг хүлээн зөвшөөрөх олон улсын стандартын түвшин боловсруулах шаардлагатай эсэхийг судалж байгаа судалгааны ажлын үндэс суурь болж байна¹⁰⁸.

106 ЮНЕСКО. 2014. *The Muscat Agreement*. (Маскатын гэрээ.) «Бүх нийтийн боловсрол» хөтөлбөрийн дэлхийн зөвлөлтөөн. Маскат, Оман 2014 оны 5 сарын 12-14., ED-14/EFA/ME/3 and United Nations.2014. *Open Working Group proposal for Sustainable Development Goals*. (Тогтвортой хөгжлийн зорилго тодорхойлох нээлттэй ажлын хэсгийн санал.) New York, UN General Assembly.

107 *Annual Report 2009*. (Годовой доклад за 2009 г.) Hamburg, UNESCO –ийн насан туршийн боловсролын асуудал эрхэлсэн хүрээлэн.

108 Keevy, J. and Chakroun, B. 2015. *The use of level descriptors in the twenty-first century*. (XXI зуунд дескриптив хэрэглэх нь.) Paris, UNESCO.

- **Дээд боловсролыг хүлээн зөвшөөрөх тухай олон улсын конвенц боловсруулах**

Дээд боловсролыг хүлээн зөвшөөрөх бүс нутгийн конвенцүүдээс гадна саяхан ЮНЕСКО-гоос дээд боловсролыг хүлээн зөвшөөрөх тухай олон улсын конвенцийг боловсруулах боломжийг судалж эхэлсэн байна.

■ **Олон өнгө төрхтэй, харилцан холбоотой Дэлхийд иргэний боловсрол, хүмүүжлийн үзэл баримтлалыг эргэн харах нь**

Иргэний тухай шинэ илэрхийлэл

Өнөөг хүртэл төрөөс олгож байгаа боловсрол нийгэм, иргэн, улс төрийн хувьд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн нь үндэсний онцлох байдал, нийтлэг хувь тавилангийн тухай мэдрэмж бий болгох, иргэн хүнийг хүмүүжүүлэх төлөвшүүлэхтэй холбоотой юм. Иргэн гэдэг ойлголт нь улс үндэстний доторх улс төрийн бүлэглэлд хамрагдаж буй хувь хүнийг хэлдэг. Энэ утгаараа иргэн гэдэг ойлголт нь янз бүрээр тайлбарлаж болох, ялангуяа хуваагдмал нийгэмд маргаан үүсгэж болох юм. Шилжин суурьшигчид, дүрвэгсэд зэрэг цөөнхийн бүлгийн хувьд иргэний үндсэн эрхийг үгүйсгэхтэй тулгарч болно. Өнөөдөр иргэний тухай ойлголт урьдын адил улс үндэстэн гэсэн төвтэй хэвээр байгаа боловч энэ үзэл баримтлал, түүний практик хэрэгжилт нь даяаршлын нөлөөн дор өөрчлөгдөж байна¹⁰⁹. Үндэстэн дамнасан нийгэм, улс төрийн бүлэглэлүүд, иргэний нийгэм, олон нийтийг хамарсан улс төрийн үйл ажиллагаа нь “үндэстэний дараах” иргэний шинэ хэлбэрийн илэрхийлэл юм¹¹⁰. Улс үндэстний хил хязгаараас давсан эдийн засаг, нийгэм-соёлын шинэ орон зай бий болгосноор даяаршил нь улс үндэстний хил хязгаартай холбоогүйгээр өөрийн өвөрмөц онцлогоо тодорхойлох, түүнийгээ хамгаалах шинэ арга замууд гарч ирэхэд хувь нэмрээ оруулж байна.

Үндэсний боловсролын системд тулгарч буй аюул бэрхшээл

Иргэний үндэстэн дамнасан хэлбэр бий болсноор иргэн гэдэг ойлголтыг бүрдүүлэх, тодорхойлоход төрөөс гүйцэтгэх үүргийн тухай асуудлыг түвэгтэй болгож байна. Хэдийгээр хувь хүний албан ёсны эрх зүйн статус, хэм хэмжээ, хүсэл эрмэлзлэлийн үүднээс төр иргэн хүний хувьд чухал байршил хэвээр байгаа ч ийм асуудал гарч байна¹¹¹. Мэдээлэл холбооны шинэ технологи, социал сүлжээ нь ялангуяа залуучуудын дунд эдгээр өөрчлөлтийг хөдөлгөгч хүч болж байна. Өнөөдрийн залуучууд хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд хамгийн өндөр боловсролтой, хамгийн их мэдээлэлтэй, өөр хоорондоо холбогдсон учраас асар

Тоон мэдээллийн хэрэгслийн хөгжлийн үр дүнд бий болсон шинэ орон зай, харилцааны шинэ хэлбэр зэргээс хамаарч нийгэм болон улс төрийн нийгэмшлийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцоог хангахад албан боловсролын үүрэг роль эргэлзээтэй болж байна.

109 Tawil, S. 2013. *Education for 'global citizenship': A framework for discussion*. («Дэлхийн иргэн бэлтгэх нь») ERF Working Papers, No. 7. Paris, UNESCO.

110 Sassen, S. 2002. Towards Post-national and Denationalized Citizenship. («Үндэстний дараах иргэншлийн тухай») E.F. Isin and B.S. Turner (eds), *Handbook of Citizenship Studies*, London, Sage Publications Ltd, pp. 277-291.

111 Sassen, өмнөхийг үз

их нөөц боломжийг тэд эзэмшиж байна. Залуучууд оюун ухаанаа дайчлах, хамтран ажиллах, инноваци хэрэгжүүлэх шинэ боломжийг нээж өгч байгаа нийгмийн сүлжээ, технологийн хөгжлөөр тэтгэгдсэн иргэний, нийгмийн, улс төрийн үйл ажиллагааны альтернатив хэлбэрүүдэд идэвхтэй оролцох болжээ. Тоон мэдээллийн хэрэгслийн хөгжлийн үр дүнд бий болсон шинэ орон зай, харилцааны шинэ хэлбэр зэргээс хамаарч нийгэм болон улс төрийн нийгэмшлийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцоог хангахад албан боловсролын үүрэг роль эргэлзээтэй болж байна. Блог, Facebook, Twitter болон бусад нийгмийн сүлжээ бүхий тоон шинэ ертөнц төрийн болон хувийн секторын хоорондын ялгаа, үндсэн ойлголтуудыг эргэж харахыг шаардаж байна.

Соёлын олон төрлийг хүлээн зөвшөөрөх, соёлын дээрэнгүй үзлээс татгалзах нь

Дэлхий дээр улс орнуудын түүхэн уламжлалт (хэл ба соёлын цөөнх, нутгийн уугуул иргэд зэргийг багтаасан) болон шилжилт хөдөлгөөний үр дүнд бий болсон соёлын олон төрлийг хүлээн зөвшөөрөх явдал өсөж байна. Шилжин суурьших хөдөлгөөн нь ялангуяа, боловсролын систем, ажлын байр, нийгэмд бүхэлд нь соёлын олон төрлийг бий болгоход их хувь нэмэр оруулж байна. Гэвч түүний зэрэгцээ гарал үүсэл, үндэс угсаанд үндэслэсэн соёлын дээрэнгүй үзэл, улс төрийн хөдөлгөөн өсөж байгаа нь дэлхий даяар нийгмийн нэгдэл нягтралд аюул учруулж байна. Соёлын олон төрөл нь өсөж хөгжихийн эх үүсвэр хэдий ч нийгмийн нэгдэл нягтрал хямралд орсон үед зөрчил үүсэх үндэс болж болох юм.

Дэлхий дахинаа хариуцлагатай иргэн, эв санааны нэгдлийг хангах нь

Мэдлэг чадварыг олж авахад боловсрол бол чухал үүрэгтэй бөгөөд бид цааш нь тэдгээрийг хөгжүүлэх шаардлагатай болдог. Үүнд, нэгдүгээрт, өөрийн орон нутгийн болон үндэсний хэмжээний, тэр ч байтугай хүн төрөлхтний хүрээнд нийгэм, соёл, улс төрийн орчинд хамрагдаж байгаа байдал, нийтлэг хувь тавилангийн талаар мэдрэмжтэй болгон хүмүүжүүлэх тухай, хоёрдугаарт, улс үндэстний болоод дэлхийн түвшинд гарч байгаа нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны өөрчлөлтийн хэв маягийн харилцан хамаарлыг ухамсарлан ойлгох замаар нийгмийн хөгжлийн явцад тулгарч байгаа бэрхшээлүүдийг ойлгож мэдэх тухай, гуравдугаарт, орон нутаг, үндэсний болон дэлхийн түвшинд хүн төрөлхтний өмнө хүлээсэн хувь хүний хариуцлагаа ухамсарлан иргэний болон нийгмийн үйл ажиллагаанд оролцоход бэлтгэх зэрэг орж байна.

• Боловсрол дахь соёлын төрлийг дэмжих нь¹¹²

Боловсрол соёлын олон төрлийг тал бүрээр хөхүүлэн дэмжих ёстой. Боловсролын салбарт соёлын олон төрлийг нэвтрүүлэх нь манай дэлхий дээрх соёлын олон төрөл, амьдралын хэв загварын олон багш, суралцагчдыг танилцуулах замаар сургалтын чанарыг дээшлүүлж болно. ЮНЕСКО-ийн 2001 оны соёлын олон янз байдлын тухай түгээмэл тунхаглал болон 2005 оны соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах болон хөхүүлэн дэмжих тухай конвенц¹¹³-ийн үзэл санааны дор боловсролын хүрээний соёлын асуудлыг авч үзэх ёстой.

¹¹² Tawil, өмнөхийг үз

¹¹³ Sharp, J. and Vally, R. 2009. Unequal cultures? Racial integration at a South African university («Тэгш эрхгүй соёл? Өмнөх Африкийн их сургуульд арьсны өнгөөр нэгдсэн нь») and Stoczowski, W. 2009. UNESCO's doctrine of human diversity: a secular soteriology? («Хүний олон талыг дэмжих ЮНЕСКО-ийн номлол: Аврал уу?») Anthropology Today, 25 (3) June 2009, pp. 3-11.

- **Бодлого боловсруулахад бүхнийг хамруулах үйл явцыг урамшуулах нь**

Өсөн нэмэгдэж буй соёлын олон төрөл нь бие хүний харьяаллыг тодорхойлоход шууд нөлөөлж байдаг боловсролын бодлогын хувилбаруудыг сонгох асуудал дээр зөвшилцөлд хүрэхэд бэрхшээлтэй болгодог. Тухайлбал, соёлын олон төрөл бүхий нийгэмд сургалт явуулах хэлийг сонгох, түүх, газар зүй, нийгэм судлал, шашин судлал зэрэг иргэний боловсролын хичээлийн агуулгыг тодорхойлох зэрэгт энэ асуудал хамгийн тод илэрдэг. Соёлын олон өнгө төрхтэй манай дэлхий дээр иргэний боловсролын бүтээлч сургалтыг боловсруулахад бодлогын гол асуудлуудаар өргөн хүрээтэй зөвшилцөх үйл ажиллагаа чухал үүрэгтэй.

■ **Дэлхийн түвшин дэх боловсролын засаглал ба үндэсний бодлого боловсруулах**

Дэлхийн түвшний засаглалын шинэ хэлбэрүүд

Боловсрол болон бүх нийтийн баялаг бүтээх хэм хэмжээ, эрх зүйн зохицуулалтын системүүд урд өмнө байсан хэдий ч эдгээр нь улам бүр нарийн төвөгтэй болж байна. Угтаа бол эдгээр системийг засгийн газар, засгийн газар хоорондын байгууллагуудын хариуцдаг байсан бол өнөөдөр төрийн бус бусад байгууллагуудын оролцоо нэмэгдэж байгааг бид харж байна. “Дэлхийн хэмжээнд засгийн газрын, засгийн газрын бус, ашгийн, ашгийн бус гээд тоо томшгүй олон тоглогчид дэлхийн түвшний олон талт, өрсөлдөөн бүхий засаглалын асуудалд оролцож байна”¹¹⁴. Үүний үр дүнд эрх мэдлийн байршлын цэг төр засгаас дэлхийн түвшинд өөрөөр хэлбэл засгийн газар хоорондын байгууллагууд төдийгүй иргэний нийгмийн байгууллагууд, корпорациуд, сангууд, оюуны төвүүдийн идэвхитэй дэмжлэг бүхий дээд түвшинд аажмаар шилжиж байна. Дэлхийн түвшний засаглалын асуудал улам нарийн түвэгтэй болж байгааг “Боловсролын төлөөх түншлэл” зэрэг олон оролцогч бүхий санаачлагууд харуулж байна. Боловсрол болон ур чадварын сургалтад дэлхийн засаглалын үзүүлэх нөлөөний тухай асуудал эрүүл мэнд зэрэг бусад салбарыг бодвол илүү маргаантай байдаг. Учир нь боловсролын төрийн бодлогын улс төрийн шинж, түүнийг бүрдүүлж байгаа ёс зүй, соёл, эдийн засаг, нийгэм, иргэний нийгмийн олон тооны сүлжилдсэн нөхцөл байдалтай уялдаатай юм.

Дэлхийн хэмжээний засаглалын асуудал улам бүр нарийн түвэгтэй болж байна.

Хариуцлага ба түүнтэй холбоотой мэдээллийн хэрэгцээ

Үндэсний болон дэлхийн түвшинд боловсролын төрийн системд оролцож байгаа олон янзын оролцогч талуудын удирдлага, хариуцлагыг тооцоход мэдээ, мэдээлэл амин чухал ач холбогдолтой. Үндэсний хэмжээнд боловсролын салбарын удирдах эрх мэдэлтнүүд улсаас боловсролд зарж буй зардлын хувь хэмжээ (томоохон хувийн хөрөнгө оруулалтыг нэмээд) нь бүх хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн суурь боловсрол эзэмших эрхийг хангах, улмаар үр өгөөжтэй, нийгэмд хэрэгцээтэй сургалт явуулахад ямар хувь нэмэр оруулж байгааг үнэлэх чадвартай байхад ийм

114 NORRAG. 2014. Global governance in education and training and the politics of data scoping workshop report. (Боловсролын засаглал, мэдээллийг шинжлэх бодлого сэдвээр бэлтгэсэн илтгэл) www.norrag.org/en/event/archive/2014/June/16/detail/scoping-meeting-on-theglobal-governance-of-education-16-17-june.html [2015 оны 2-р сард авав.].

115 Дээрх материалд

мэдээ мэдээлэл чухал. Үүний нэг адил, эрх баригчид суурь боловсролын дараах боловсрол, сургалтанд хамрагдах тэгш боломжийг хангаж байгаа эсэхийг тайлбарлах бололцоотой болно. Дэлхийн хэмжээнд, мэдээ мэдээлэл нь олон улсын хэмжээнд харьцуулах боломжтой статистик, шалгуур үзүүлэлтүүд, нийлмэл индексүүд, мониторинг, бенчмарк, чансаа тогтооход хэрэглэх их хэмжээний мэдээний хэлбэрээр илүү нэг загварын, тооны хувьд илэрхийлэх боломжтой болж байна¹¹⁵. Ийм мэдээлэл нь боловсролын бодлого боловсруулах, түүнд хөрөнгө оруулахад мэдээлэл өгч, хууль ёсны үндэслэл болж байна.

Энэ үндэслэлүүдэд тулгуурлан хөгжлийн янз бүрийн зорилгуудтай холбоотойгоор “мэдээллийн хувьсгал” хийх шаардлага гарсан¹¹⁶. Үнэндээ, 2000 оноос хойшхи Мянганы хөгжлийн зорилт болон Бүх нийтийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд дэлхийн хэмжээний зорилт, үзүүлэлтийг тодорхойлсон туршлага нь үндэсний хэмжээнд нэгтгэсэн мэдээлэлд тулгуурласан тайлан бэлтгэж байсан нь улс орны дотоодод байгаа тэгш бус, ялгаатай байдлыг халхавчлах талтайг харуулсан юм. Хэрэв бид үр өгөөжтэй, хэрэгцээтэй зүйлийг сурах боломжийг бүх хүмүүст тэгш олгох *шударга зарчимд* санаа зовж байгаа бол үндэсний хэмжээний зорилт, үзүүлэлтийг тогтоохдоо илүү нарийн анхдагч тоо баримт дээр тулгуурлах боломжийг хангах ёстой. Мэдээлэл цуглуулах, ашиглахдаа хүйсийн байдал, хот, хөдөө орон нутагт амьдардаг зэрэг уламжлалт үзүүлэлтүүдээс гадна гэр бүлийн орлогын тухай мэдээлэл, боломжтой бол цөөнхийн бүлэгт хамаарах эсэхийг оруулах ёстой. Өрхийн амьдралын нөхцөл, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт зэрэг альтернатив мэдээг ашиглах замаар дээрх зорилтыг хангаж болно.

Боловсролын санхүүжилтийн шинэ хандлагууд

Суурь боловсрол ба түүний дараах боловсролын хүртээмж өргөжснөөр албан боловсролын төрийн санхүүжилтэнд учирч байгаа дарамт илүү мэдрэгдэх болсон. Үүнтэй уялдан эдгээр хязгаарлагдмал нөөцийг илүү үр дүнтэй ашиглах арга замыг хайх, боловсролд зориулсан төрийн хөрөнгөнд илүү хариуцлагатай хандах, татварын суурийг өргөтгөх замаар төсвийн боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд албан ёсны тусламжийг нэмэгдүүлэх талаар сурталчилгаа явуулах, төрийн бус байгууллагуудтай түншлэлийн шинэ гэрээ хийх шаардлага гарч ирж байна. Суурь боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд хандивлагчид Засгийн газрын хөрөнгө дээр нэмэр өгч чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Олон талын оролцоотой байгууллагуудын олон нийтэд зориулсан мэдэгдлүүдэд боловсролын талаар хүчтэй амлалт үүргүүд агуулсан байна. Үүнээс гадна, хөгжиж буй орнуудын засгийн газар, иргэний нийгэм, хувийн

116 United Nations. 2013. *A New Global Partnership: Eradicate poverty and transform economies for sustainable development*. («Шинэ түншлэл: ядуурлыг бууруулах ба тогтвортой хөгжлийг хангахын тулд эдийн засгийг өөрчлөх нь».) 2015 оноос хойших хөгжлийн хөтөлбөр боловсруулах асуудлаар нэртэй удирдагчдын бэлтгэсэн илтгэл. New York, United Nations.

117 Pauline, R. and Steer, L. 2013. *Financing for Global Education Opportunities for Multilateral Action: A report prepared for the UN Special Envoy for Global Education for the High-level Roundtable on Learning for All*. («Олон талын арга хэмжээ авах зорилгоор боловсролын боломжийг дэлхийн хэмжээнд санхүүжүүлэх нь: Бүх нийтийн боловсролын асуудлаар болсон дээд хэмжээний дугуй ширээний ярилцлагад Боловсролын асуудал хариуцсан НҮБ-ын тусгай элчийн тавьсан илтгэл ».) Center for Universal Education (CUE) at Brookings Institution and UNESCO EFA GMR. Суурь боловсролын санхүүжүүлэлтийн асуудлыг хөндсөн. (Basic Education at risk). www.brookings.edu/~media/research/files/reports/2013/09/financing%20global%20education/basic%20education%20financing%20final%20%20webv2.pdf {2015 оны 2 сард авав.}.

118 Bokova, I. 2014. Бүх нийтийн боловсролын асуудлаар болсон зөвлөлгөөн, 2014 он. Маскат, Оман. www.unesco.org/new/fileadmin/MULTIMEDIA/HQ/ED/ED_new/pdf/UNESCO-DG.pdf [2015 оны 2-р сард авав.].

секторын дунд хийсэн судалгаагаар боловсролд илүү их дэмжлэг үзүүлэх хэрэгцээ байгааг харуулж байна. Хэдийгээр суурь боловсролд тэргүүлэх ач холбогдол өгч, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон ч бусад сектортай харьцуулбал суурь боловсролд олон талын дэмжлэг суларч байгаа нотолгоо байна¹¹⁷. Зарим улс орнуудад дэмжлэг хамгийн их хэрэгтэй байгаа яг энэ цаг үед энэ бууралт болж байна¹¹⁸. Орлогын түвшин доогуур олон улс орнуудын хувьд боловсролын салбарт оруулж байгаа олон улсын тусламжийн эзлэх хувь өндөр хэвээр байна. Сахарын өмнөд хэсгийн Африкийн есөн орны боловсролын салбарын зардлын дөрөвний нэгээс илүү хувийг олон улсын тусламж эзэлж байна¹¹⁹. Түүнчлэн, улс орны хил хязгаар дамнасан оюуны гадагшлах урсгалыг хүлээн зөвшөөрөх хандлага нь дэлхийн хэмжээнд хамтарсан арга хэмжээ авахыг шаардаж байгаа бөгөөд ялангуяа, дэлхий нийтийн баялаг болох боловсролд төрөөс зарцуулж буй зардлыг нэмэгдүүлэх нэмэлт санхүүгийн механизмыг бий болгоход чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна¹²⁰.

Үндэсний түвшинд бодлого боловсруулах явц дахь хандивлагчдын нөлөө

Хандивлагчид дотоодын нөөцийг нэмэгдүүлэх хөгжлийн тусламж үзүүлэхээс гадна боловсролын бодлогод маш их нөлөө үзүүлдэг. Энэ нь эерэг үр дагавартай ч бас сөрөг үр дагавар бий. Жишээлбэл, “Иргэний нийгмийн боловсролын сан” болон “Боловсролын төлөөх түншлэл” зэрэг санаачлагууд орон нутгийн боловсролын бүлгүүдийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог дэмжсэн байна. Энэ санаачилга нь боловсролын талаарх хөтөлбөрүүдийг боловсруулахад засгийн газар, хандивлагчидтай хамт иргэний нийгмийг оролцуулах, улмаар “Бүх нийтийн боловсрол”-ын зорилгод хүрэх үйл явцыг хянах боломжийг тэдэнд өгсөн¹²¹. Гэхдээ хандивлагчид тусламж өгөхдөө тусгай нөхцөл, тоглоомын дүрэм тулгах нь засгийн газрууд бодлогоо өөрчлөх аргагүй байдалд хүргэж болох юм¹²². Олон тооны хандивлагчид үр дүнгээр нь санхүүжүүлэх хандлага хэрэглэх болсон нь хүссэн зорилгод тэднийг хүргэж болох юм. Гэхдээ энэ арга зам нь зарим улс орны бодлоготой сайн зохицож чадахгүй, үндэсний түвшинд боловсруулж, бүх талын дэмжлэг авсан, орон нутгийн онцлогт тохирсон найдвартай шийдлүүдийг үгүйсгэх байдлаар хэрэгжиж болох юм. Иймээс хандивлагчид үндэсний эрх ашиг, тэргүүлэх чиглэл онцлог нөхцлийг харгалзаж үзсэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд нь засгийн газар, иргэний нийгэм, сонирхогч талуудад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй юм.

119 UNESCO. 2012. *Youth and skills: Putting education to work. EFA Global Monitoring Report 2012*. («Залуучууд ба үр чадвар. Боловсролыг ажилд оруулах нь»). Бүх нийтийн боловсролын хяналт үнэлгээний дэлхийн тайлан 2012 он.) Paris, UNESCO, p. 146.

120 Winthrop, R. and Bulloch, G. 2012.

121 Веб-сайт www.globalpartnership.org/civil-society-education-fund [2015 оны 2-р сард авав.].

122 Moyo, D. 2009. *Dead Aid: Why Aid Is Not Working and How There Is Another Way for Africa*. («Ашиггүй тусламж: Африкийн орнуудад гарах шинэ арга замыг хайх үр дүнгүй тусламжийн шалтгаан») London, Penguin Books.

Олон улсын хамтын ажиллагааны динамик өөрчлөлт

Делорийн илтгэл (1996) нийтлэгдснээс хойш болон Мянганы хөгжлийн зорилт

Делорийн
илтгэл (1996)
нийтлэгдснээс
хойш болон
Мянганы хөгжлийн
зорилт (2000)
батлагдсан үеэс
олон улсын
тусламжийн
динамик ихээр
өөрчлөгдсөн.

(2000) батлагдсан үеэс олон улсын тусламжийн динамик ихээр өөрчлөгдсөн. Олон улсын хөгжилд бөмбөрцгийн хойд хэсгийн орнуудаас өмнөд хэсгийн орнууд руу чиглэсэн тусламжийн урсгал чухал ач холбогдолтой хэвээр байхын зэрэгцээ өмнөдөөс өмнөд рүү, тэр ч байтугай гурван талт хамтын ажиллагаа ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж байна. Дэлхийн санхүүгийн хямрал, шинээр гарч ирж байгаа эдийн засгийн хүчтэй улс орнууд олон улсын тусламжийн шинэ тогтолцоог бий болгож, улмаар улс орнуудын хоорондын харилцааг өөрчлөхөд хувь нэмрээ оруулж байна. Улс орнууд ижил төстэй хүндрэлүүд (ажилгүйдэл, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлт г.м.)-тэй тулгарч байгаа нөхцөлд 2015 оноос хойших ирээдүйн хөгжлийн хөтөлбөрийн чухал онцлог бол түгээмэл бөгөөд нэгдмэл шинж байх ёстойг анхааруулж байна. Түгээмэл байдал нь бүх улс орнууд хөгжлийн замаа

өөрийн өвөрмөц нөхцөл байдлыг харгалзан, өөрийн өвөрмөц хандлагаар эргэж харах шаардлагыг хэлж байна. Үзэл баримтлалын ийм өөрчлөлт нь ирээдүйн төлөөх хамтын хариуцлагын үүднээс хандахыг шаардаж байна.

4. Боловсрол нийтийн баялаг мөн үү?



4. Боловсрол нийтийн баялаг мөн үү?

“Боловсролыг эцсийн зорилго гэж үзвэл бид мэдлэгийг хамгийн цнэ цэнэтэй зүйл гэж хүлээн зөвшөөрнө”

Абул Калам Азад, Энэтхэгийн боловсролын сайд (1947-1958)

Дэлхийн хэмжээнд бий болсон шинэ орчин нөхцөлд боловсролын үзэл баримтлалыг эргэн харахдаа зөвхөн боловсролын зорилгыг биш, сургалтын зохион байгуулалтын аргуудыг дахин авч үзэх хэрэгтэй. Түншлэлийн харилцаа тэлж, улсын болон хувийн хэвшлийн хоорондын зааг аажмаар бүдгэрч байгааг харгалзан боловсролын үйл ажиллагааны удирдлагын үндсэн зарчмуудыг, ялангуяа нийгмийн баялаг гэдэг утгаар боловсролыг үзэх норматив зарчмуудыг эргэж харах хэрэгтэй болж байна. Түүнээс гадна төр, нийгэм, зах зээлийн хэмжээнд гарч буй шинэ нөхцөл байдалд түүнийг хэрхэн ойлгож авахыг эргэн харж үзэх хэрэгтэй болж байна¹²³.

■ Боловсролыг нийгмийн баялаг гэж үзэх зарчим эргэлзээтэй байдалд орж байна

Хүртээмжтэй, ил тод, хариуцлагатай байдлын талаар өсөн нэмэгдэж буй шаардлага

Дэлхийн олон улс орнуудад ардчилал бэхжиж, албан боловсролын системийн хүрээнд төдийгүй тоон технологийн тусламжтай мэдлэгийн хүртээмж нэмэгдэж байгаа нь хувь хүн, нийгмийн бүлгүүдийн эрх, боломжийг өргөжүүлэхэд хүргэж байна. Үүнтэй уялдан олон нийтийн үйл хэрэгт оролцох талаар хүмүүсийн хүсэл эрмэлзэл өсөж байгаа нь орон нутгийн болон дэлхийн түвшний засаглалын хэлбэрүүдэд өөрчлөлт хийх хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлж байна. Нийгмийн ач холбогдол бүхий үйл хэрэгт хариуцлага, ил тод, шударга, эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага өсөж байна. Хэдийгээр нийгмийн амьдралд илүү идэвхтэй оролцох гэсэн хүмүүсийн хүсэл эрмэлзлэл гол төлөв орон нутгийн болон үндэсний хэмжээнд гарч байгаа ч, үндэстэн

123 Morgan, W. J. and White, I. 2014. Education for Global Development: Reconciling society, state, and market. («Дэлхийн хөгжил ба боловсрол: нийгэм, төр, зах зээлийн сонирхлыг зохицуулах нь»). *Weiterbildung*, 1, 2014, pp. 38-41.

дамнасан, дэлхийн хэмжээний асуудалд анхаарлаа хандуулах явдал өсөн нэмэгдэж байна. Олон нийтийн байгууллага, корпорац зэрэг төрийн бус байгууллагуудаас орон нутгийн, үндэсний ба дэлхийн хэмжээнд олон нийтийн үйл хэргийг удирдан зохион байгуулахад илүү идэвхтэй оролцох болсон. Үүнтэй нэг адил мэдлэгт суурилсан, хүртээмжтэй нийгэм байгуулах асуудлыг хамтран шийдэж байгаа төрийн ба хувийн секторууд боловсролын салбарын бодлогод хамт оролцох болжээ. Олон нийтийн дуу хоолой нэмэгдэж байгаа нь хичээлийн хөтөлбөр, сурах бичиг болон практик арга хэмжээ авахтай холбоотой стратеги боловсруулахад нөлөө үзүүлэх болсныг бид харж байна.

Нийгмийн ач холбогдол бүхий үйл хэрэгт хариуцлага, ил тод, шударга, эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага өсөж байна.

Боловсролд хувийн хэвшлийнхний оролцоо нэмэгдэж байгаа нь

Боловсролыг хувьчлах хандлага дэлхий даяар боловсролын бүх үе шатанд нэмэгдэж байна. Өнгөрсөн арван жилд хувийн өмчийн боловсролын байгууллагуудад элсэгчдийн тоо өсөж, ялангуяа бага орлоготой улс орнуудын бага сургуулийн түвшинд, Төв Ази болон эдийн засгийн өндөр хөгжилтэй улс орнуудад дунд сургуулийн дараах түвшинд суралцагчдын тоо өссөн байна¹²⁴. Төрийн болон нийгмийн өмчийн байгууллагуудаас хувь хүн, аж ахуйн нэгжид боловсролтой холбоотой үйл ажиллагаа, хөрөнгө, удирдлага, үүрэг, хариуцлагыг шилжүүлэх үйл явцыг боловсролын хувьчлал гэж ойлгож болно¹²⁵. Хувьчлалын үр дүнд боловсролын үйлчилгээ үзүүлэх олон янзын хэлбэр, тухайлбал, шашны сургууль, хямд төсөр хувийн сургууль, гадаадын тусламжаар санхүүждэг сургууль, олон улсын сургууль, төрийн бус байгууллагуудын удирдан ажиллуулдаг сургууль, дүрэм, гэрээ, эрхийн бичгийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг сургууль, гэрийн сургалт, багшаас хувиараа зөвлөгөө өгөх сургалт, зах зээлийн зарчмаар ажилладаг боловсролын байгууллага, төлбөртэй сургууль зэрэг бий болж болно¹²⁶. Боловсролын үйлчилгээ үзүүлэхэд хувийн хэвшлийн оролцоо шинэ зүйл биш боловч түүний хэмжээ, цар хүрээ, боловсролын үйл ажиллагааны бүх хэсэгт нэвтэрч байгаа нь “шинэ” юм¹²⁷.

Хувьчлал ба боловсрол эзэмших эрх

Боловсролын үйлчилгээг хувьчлах нь нийгмийн зарим бүлэгт суралцах боломжийг нэмэгдүүлэх, эцэг эхчүүдэд өргөн сонголттой олон янзын сургалтын хөтөлбөрийг санал болгох зэрэг эерэг нөлөөг үзүүлж болох юм. Түүний зэрэгцээ төрийн байгууллагуудын

124 ЮНЕСКО-ийн Статистикийн институтын тоо баримт.: 2000-2011 он.

125 Right to Education Project. 2014. *Privatisation of Education: Global Trends of Human Rights Impacts* («Боловсролын хувьчлал: хүний эрхэд үзүүлэх нөлөөтэй холбоотой ерөнхий хандлага») London, Right to Education Project.

126 Patrinos, H.A. et al. 2009. *The Role and Impact of Public-Private Partnership in Education* («Боловсролын салбар дахь хувийн болон төрийн хамтын ажиллагааны нөлөө, үүрэг») Washington, DC, World Bank. Lewis L., and Patrinos H.A. 2012. *Impact Evaluation of Private Sector Participation in Education* («Боловсролын салбарт хувийн секторын оролцооны нөлөөг үнэлэх нь»). London, CfBT Education Trust. Right to Education Project. 2014. *Privatisation of Education: Global Trends of Human Rights Impacts*. London, Right to Education Project.

127 Macpherson, I., Robertson, S. and Walford, G. 2014. *Education, Privatization and Social Justice: case studies from Africa, South Asia and South East Asia* («Боловсрол, хувьчлал, нийгмийн шударга ёс: Африк, Өмнөд, Зүүн-Өмнөд Азид хийсэн сэдэвчилсэн судалгаа»). Oxford, Symposium Books.

зүгээс хяналт зохицуулалт хангалттай түвшинд байхгүй байдгаас сөрөг үр дагавар (лицензгүй сургуулиуд, бэлтгэгдээгүй багш нарыг ажилд авах, чанарын хяналт байхгүй)-тай байж болох талтай учраас нийгмийн нэгдэл нягтрал, хамтын хариуцлагын талаас болзошгүй эрсдэлтэй байдаг. “Нийгмийн эмзэг орхигдсон бүлгүүд хувьчлалын үр дүнд бий болсон боломжийн дийлэнх хэсгийг хүртэж чадахгүйд хүрэхийн зэрэгцээ хувьчлалын сөрөг нөлөөг үүрэх гол объект нь болдог”¹²⁸ явдал сэтгэл зовоож байдаг. Түүнээс гадна боловсролын үйлчилгээ үзүүлдэг хувийн байгууллагуудаас сургалтын төлбөрөө тогтооход хяналт байдаггүйгээс боловсролыг бүх нийтэд хүртээмжтэй болгох зарчмыг үл тооход хүргэж байна. Ерөнхийд нь авч үзвэл боловсролын хувьчлал чанартай боловсрол олж авах эрхийг хэрэгжүүлэх, боловсролын тэгш боломжийг хангах зарчимд сөрөг нөлөө үзүүлж болох юм.

Дэлхий дээр өргөн тархсан боловсролын хувьчлалын нэг илрэл бол хувийн багшийн нэмэлт хичээл буюу “сүүдрийн боловсрол”¹²⁹ юм. Хувийн багшийн хичээл бол гол төлөв сургуулийн сургалтын чанар доогуур байгаагийн илрэл¹³⁰ байдаг боловч хувийн сургалтын бусад хэлбэрийн нэг адил багш суралцагчдад эерэг бас сөрөг үр дагавартай байдаг. Нэг талаас ийм сургалт нь хоцрогдож байгаа сурагчдын онцлог, шаардлагад тохируулсан байх талтайн дээр багш нарт нэмэлт орлогын боломж олгоно. Нөгөө талаас хувийн хичээлийн төлбөр нь өрхийн орлогын, ялангуяа ядуу гэр бүлийн орлогын ихээхэн хувийг эзэлж болох тул сурах боломжийн тухайд тэгш бус байдлыг үүсгэх урдчилсан нөхцөл болдог. Мөн зарим багш нар хувиараа хичээл заахад түлхүү анхаарснаар өөрийн үндсэн үүргээ хайхрахгүйд хүргэж улмаар сургуульд хичээл заах, сургах ажлын чанарт муу нөлөө үзүүлж болно¹³¹. Сүүдрийн боловсролын зах зээлийн өсөлт, үүнтэй холбоотой хувь хүн, гэр бүлийн санхүүгийн зардал, түүнчлэн багш нараас мэргэжлийн үүргээ зохих түвшинд гүйцэтгэхгүй байх болон багш нарын дундах авилгын асуудлууд нь зарим орны боловсролын яамдыг энэ зах зээлийг зохицуулахад чиглэсэн алхам хийхэд хүргэж байна.¹³²

16. Египетэд ядуу гэр бүлийн боловсрол олж авах боломжид хувийн багшийн сургалт сөрөг нөлөө үзүүлж байна¹³³

Египетэд хувийн багшийн үйлчилгээний төлбөр нь өрхийн боловсролын зардлын ихээхэн хэсгийг эзэлдэг бөгөөд дунджаар хөдөө орон нутагт 47%, хотод 40% байна. Хувийн багшийн үйлчилгээний төлбөрт зарцуулсан зардлын хэмжээ 2011 онд 2.4 тэрбум америк доллар буюу төрөөс боловсролд оруулсан зардлын

128 The Right to Education Project («Боловсрол эзэмших эрх» төсөл). 2014.

129 Bray, M. 2009. *Confronting the shadow education system. What government policies for what private tutoring?* («Сүүдрийн боловсролтой тэмцэх нь: хувийн багшийн асуудлаар төрөөс барих бодлого») Paris, UNESCO-IIEP.

130 UNESCO. 2014. *Teaching and Learning: Achieving quality for all. EFA Global Monitoring Report 2013-2014* («Хичээл заах ба сургалт: бүх нийтэд чанартай боловсрол олгох нь. Бүх нийтийн боловсролын хяналт үнэлгээний дэлхийн тайлан 2013-2014 он.»). Paris, UNESCO.

131 Bray, M. and Kuo, O. 2014. *Regulating Private Tutoring for Public Good. Policy options for supplementary education in Asia*. («Нийгмийн сонирхолын үүднээс давталга хичээлийн зах зээлийг зохицуулах. Азид нэмэлт боловсрол зохион байгуулах бодлогын хувилбарууд») CERC Monograph Series in Comparative and International Education and Development. No. 10. Hong Kong, Comparative Education Research Center and UNESCO Bangkok Office.

132 Өмнөхийг үз

133 UNESCO. 2014. *Teaching and Learning: Achieving quality for all. EFA Global Monitoring Report 2013-2014*. («Хичээл заах ба сургалт: бүх нийтэд чанартай боловсрол олгох нь. Бүх нийтийн боловсролын хяналт үнэлгээний дэлхийн тайлан 2013-2014 он.») Paris, UNESCO. [Central Agency for Public Mobilization and Statistics (2013); Elbadawy et al. (2007); Hartmann (2007); UNESCO (2012a) материалуудыг үз.]

27%-тай тэнцэж байна гэсэн мэдээ бий. Ийм хөрөнгө оруулалтыг төлбөрийн чадвартай өрхийн хувьд үр өгөөжтэй гэж үзэж байна. Гэсэн хэдий ч хүн бүр түүнийг төлж дийлэхгүй. Чинээлэг өрхийн хүүхдүүд хувийн багшийн үйлчилгээнд бараг хоёр дахин олон удаа хамрагдаж байна. Харин багш нар нь өөрийн мэдлэг чадвараа ангид хичээл заахад бус хувиараа давтлага өгөхөд зарцуулдагийн улмаас чанар муутай боловсролын үйлчилгээтэй болсон албан боловсролын үр дагаварыг хувийн багшийн хичээлийн төлбөрийг төлж чадахгүй гэр бүлийн хүүхдүүд амсаж байна.

Төрийн боловсролын системд хамрагдах өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах зорилгоор Египетийн засгийн газраас чадвар муу багш нарыг ажилд авсны үр дүнд сүүлийн арваад жилийн дотор багшийн нийгмийн статус буурсан нь хувийн багшийн үйлчилгээ дэлгэрэхэд хүргэсэн гол шалтгаан юм. Сургууль дөнгөж төгсөгчид өөрийн сонирхлоор бус, аргагүйн эрхэнд багшлах ажилд орох болжээ. Египетийн нийгэмд багш нарын нийгмийн статус буурснаар багшийн мэргэжил төрийн албанд хамгийн бага цалинтай ажлуудын нэг болжээ. Нэмэлт цалингийн эх үүсвэр олохын тулд багш нар хувиараа давтлага сургалт хийхэд хүрсэн байна.

Эх сурвалж: UNESCO. 2014. *Teaching and Learning: Achieving quality for all. EFA Global Monitoring Report 2013–2014*. (Хичээл заах ба сургалт: бүх нийтэд чанартай боловсрол олгох нь. Бүх нийтийн боловсролын хяналт үнэлгээний дэлхийн тайлан 2013–2014 он.) Paris, UNESCO

Боловсролын бүх салбарт хувьчлал явуулсны үр дүнд боловсрол олж авах боломжийн тэгш бус байдлыг даамжруулж, тэгш бус байдлыг газар сайгүй бий болгож байгаа нь боловсролыг нийгмийн баялаг гэж үзэх ойлголт болон сурч боловсрох эрхийг хангах төрийн үүргийн талаар чухал асуудлуудыг тавьж байна.

Шинэ нөхцөл дэх боловсрол эзэмших эрх

Хөгжлийн тухай олон улсын хэмжээний яриа хэлэлцүүлэгт боловсролыг хүний эрх, мөн нийгмийн баялаг гэж тодорхойлдог. Хувь хүнд бусад эрхээ хэрэгжүүлэх боломж олгодог үндсэн эрх болох боловсролын зарчим олон улсын хэм хэмжээ тогтоох баримт бичгүүдэд суулгасан байдаг¹³⁴. Энэ зарчмын дагуу боловсрол эзэмших эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх, дагаж мөрдөх нь төрийн үүрэг юм. Боловсролын үйлчилгээ үзүүлэх үүргээс гадна төр нь боловсрол эзэмших эрхийн баталгаа болж байх ёстой.

Боловсролын бүх салбарт хувьчлал явуулсны үр дүнд боловсрол олж авах боломжийн тэгш бус байдлыг даамжруулж, газар сайгүй бий болгож байгаа нь боловсролыг нийгмийн баялаг гэж үзэх ойлголт болон сурч боловсрох эрхийг хангах төрийн үүргийн талаар чухал асуудлуудыг тавьж байна.

17. Боловсрол эзэмших эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх, дагаж мөрдөх нь

46. Боловсрол эзэмших эрх нь хүний бусад бүх эрхийн адил оролцогч улс орнуудад дагаж мөрдөх, хамгаалах, хэрэгжүүлэх гэсэн гурван төрлийн буюу гурван түвшний үүрэг ноогдуулна. Хэрэгжүүлэх үүрэг нь дэм үзүүлэх ба хангах гэсэн хоёр үүргийг хоёуланг хамаарна.

¹³⁴ Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он. (26-р зүйл), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт 1966 онг. (13-р зүйл) Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989 он (28-р зүйл).

47. Дагаж мөрдөх үүрэг нь боловсрол эзэмших эрхээ эдлэхэд саад болох эсвэл бэрхшээл учруулах арга хэмжээ авахаас зайлсхийхийг оролцогч улс орнуудаас шаардана. Хамгаалах үүрэг нь боловсрол эзэмших эрхээ эдлэхэд гуравдагч талууд хөндлөнгөөс оролцохоос урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээ авахыг оролцогч-улсуудаас шаардана. Хэрэгжүүлэх (дэм үзүүлэх) үүрэг нь боловсрол эзэмших эрхээ эдлэхэд хувь хүмүүс, нийгмийн бүлгүүдэд боломж олгож, дэм үзүүлэх зэрэг эерэг арга хэмжээнүүд авахыг оролцогч-улсуудаас шаардана. Эцэст нь, оролцогч-улсууд боловсрол эзэмших эрхийг биелүүлэх (хангах) үүрэгтэй. Дүрэм ёсоор, хувь хүн эсвэл бүлэг хүмүүс өөрсдөөс нь үл хамаарах шалтгаанаар өөрсдийн мэдэлд байгаа хөрөнгө мөнгөндөө тулгуурлан энэ эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байгаа үед оролцогч-улс орнууд Гэрээний тусгай эрхийг биелүүлэх (хангах) үүрэгтэй. Гэхдээ энэ үүргийн цар хүрээ Гэрээний заалтаар тодорхойлогдоно.

Эх сурвалж: UN Committee on Economic, Social, Cultural Rights (CESCR). 1999. General Comment № 13: The Right to Education (Art 13 of the Covenant), 8 December 1999. E/C.12/1999/10 (46/4), available at: www.refworld.org/docid/4538838c22.html [Accessed 6 March 2015]

Сурч боловсрох эрхийн янз бүрийн заалттай холбоотой эрхийн тусгай үүргүүд байдаг боловч саяхан болтол сурч боловсрох эрхийн тухай үндсэн хэлэлцүүлэг нь сургуулийн боловсролын тодруулбал, бага боловсролын асуудлууд дээр анхаарлаа төвлөрүүлж байв. 1990 онд Тайландын Жомтиен хотод болсон Боловсролын бага хурлаас суурь боловсролын тухай ойлголтыг өргөн хүрээнд авч үзсэн. Энэ нь унших, бичих, тоо бодох болон тухайн орчин нөхцлөөс хамаарсан суурь мэдлэг, чадвар, үнэт зүйлс зэргийг агуулсан сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай үндсэн багаж болох чадвараас бүрдэнэ. Албан боловсролын байр сууринаас суурь боловсролыг гол төлөв сургуулийн боловсролтой адилтгаж үздэг. Дэлхийн улс орнуудын дийлэнхийн үндэсний хууль тогтоомжид заавал сурах хугацааг зааж өгсөн байдаг. Энэ өнцгөөс нь харвал суурь боловсрол эзэмших эрхийн зарчим, тухайн зарчмыг хамгаалах, тэгш боломжийг хангахад төрийн үүргийн тухай асуудал эргэлзээгүй болж байна.

Суурь боловсролын хувьд дээрх зарчмууд харьцангуй маргаангүй боловч суурь боловсролын дараах түвшинд тэдгээрийг хэрэглэх талаар нэгдсэн байр суурь байхгүй байна¹³⁵. Суурь боловсролын хүртээмж нэмэгдснээр дунд ба дээд боловсролын эрэлт хэрэгцээ өсөхөд хүргэж, залуучуудын дунд ажилгүйдэл өсөж буй байдал, мэдлэг эзэмших, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны тасралтгүй шинжтэй уялдан мэргэшлийн чадавхиа дээшлүүлэх сонирхол нэмэгдэхэд хүргэжээ. Суурь боловсролын дараах түвшний боловсрол эзэмших, насан турш сурах хэрэгцээ өсөн нэмэгдэж буйг харгалзан сурч боловсрох эрхийн зарчмуудыг хэрхэн ойлгож, хэрэглэх вэ? Эрх хүртэгчийн эдлэх эрх ба эрх агуулагчийн үүргийн үүднээс авч үзвэл энэ эрх нь суурь (албан ёсны заавал эзэмших) боловсрол эзэмших эрхээс юугаараа ялгаатай вэ? Өнөөдөр заавал албан ёсоор эзэмших шаардлагагүй, тухайлбал дунд сургуулийн ахлах шат, дээд боловсрол, техник-мэргэжлийн боловсрол зэрэг боловсролын түвшний сургалтын хувьд төрийн үүрэг хариуцлагын хүрээ ямар байх вэ? Суурь боловсролын дараах боловсрол эзэмших, мэргэжлийн сургалтад хамрагдах хүртээмжийг ялгаварлахгүй, эрх тэгш боломж олгох зарчмыг мөрдөж хэрэгжүүлэхэд хариуцлагын тогтолцооны хуваарилалтыг хэрхэн хангах вэ?

135 Morgan, W. J. and White, I. 2014. The value of higher education: public or private good? («Дээд боловсролын үр өгөөж: Нийгмийн баялаг уу, эсвэл хувийнх уу?») *Weiterbildung*, 6, 2014, pp. 38-41.

136 Singh, K. 2014. *Report of the Special Rapporteur on the right to education*. (Сурч боловсрох эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн тайлан.) United Nations. A/69/402, 24 September 2014. http://ap.ohchr.org/documents/dpage_e.aspx?si=A/69/402 [2015 оны 2 сард авав.]

Төрийн болон хувийн боловсролын зааг хязгаар арилах нь

Боловсролын талаарх олон улсын яриа хэлэлцүүлэгт боловсролыг нийгмийн баялаг гэж тодорхойлох нь олонтаа тохиолддог. Сурч боловсрох эрхийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгч хэлсэн үгэндээ боловсролын салбар дахь нийгмийн сонирхлыг хадгалахын ач холбогдлыг тэмдэглэхийн зэрэгцээ боловсрол бол нийгмийн баялаг болох тухай үзэл баримтлалыг сурталчлахыг онцолсон байна¹³⁶. Үүний хамт иргэдийг төрөөс сурч боловсрох үйлчилгээгээр хангах төрийн үүрэгт эргэлзэх байдал бий болж, боловсролд зарцуулах төрийн зардлыг бууруулах, боловсролын салбарт төрийн бус субъектуудыг идэвхитэй татан оруулах санал дэвшүүлэх болжээ. Иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлийн байгууллагууд, сан зэрэг сонирхогч талуудын хүрээг тэлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг өргөтгөх явдал нь төрийн ба хувийн боловсролын зааг хязгаарыг бүдгэрүүлж байна. Боловсролыг сонирхогч талуудын хүрээ эрс өссөн, олон улс орны хувьд бие даан боловсролын бодлогоо тодорхойлох боломж нь хумигдаж байгаа болон дэлхийн хэмжээний засаглалын шинэ хэлбэрүүд бий болж байгаа зэрэг шинэ орчинд “нийгмийн” гэсэн ойлголтын мөн чанарыг тайлбарлахад түвэгтэй болж байна.

Өнөөгийн даяаршсан шинэ орчинд боловсролыг олон нийтийн баялагт хамруулах гол зарчмыг хэрхэн хамгаалах вэ?

Боловсролын үйлчилгээ үзүүлэхэд хувийн хэвшлийн оролцооны шинж чанар, цар хүрээ нь төрийн ба хувийн боловсролын зааг хязгаарыг бүдгэрүүлж байна. Тухайлбал, төрийн өмчийн дээд боловсролын байгууллагууд хувийн санхүүжилтээс улам ихээр хараат байдалд орж байгаа, ашгийн ба ашгийн бус боловсролын байгууллагуудын тоо өсөж байгаа, дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаанд бизнес эрхлэх загвар хэрэгжүүлж байгаа зэргээс тодорхой ажиглагдаж байна. Хувийн өмчийн боловсролын шинэ хэлбэрүүд (суурь ба түүний дараах түвшний боловсролын байгууллагууд үйл ажиллагаандаа ашиг олох, арилжааны сонирхлыг удирдлага болгож, энэ сонирхлынхоо үндсэн дээр сургалтын хөтөлбөрөө боловсруулж байна) нь боловсролыг нийтийн баялагаас хувийн (хэрэглэгчийн) баялаг гэж үзэхэд хүргэж, боловсролын мөн чанарыг өөрчилж байна¹³⁷. Нийгэм, төр, зах зээлийн хоорондын харилцааны шинж чанар хурдан өөрчлөгдөж байгаа нь өнөөгийн даяаршсан шинэ орчинд боловсролыг олон нийтийн баялагт хамруулах гол зарчмыг хэрхэн хамгаалах вэ гэсэн түвэгтэй асуудлыг бидний өмнө тавих боллоо.

137 Macpherson, Robertson and Walford, өмнө гарсан, хуудас. 9.

138 Menashy, F. 2009. Education as a global public good: the applicability and implications of a framework («Боловсрол бол олон нийтийн баялаг мөн: Ерөнхий зарчмуудыг хэрэглэх боломж, үр дагавар») *Globalisation, Societies and Education*, Vol. 7, No. 3, pp. 307-320.

139 Samuelson, P.A. 1954. The Pure Theory of Public Expenditure («Төрийн зардлын тухай цэвэр онол»), *The Review of Economics and Statistics*, Vol. 36, No. 4, pp. 387-389.

140 Adapted from Zhang, E. 2010. *Community, the Common Good, and Public Healthcare – Confucianism and its relevance to contemporary China*. («Нийгэм, нийтийн баялаг ба эрүүлийг хамгаалах улсын сектор: Орчин үеийн Хятад орон дахь конфуцийн түүний ач холбогдол») Department of Religion and Philosophy, Hong Kong Baptist University.

141 Marella, M.R. 2012. *Oltre il pubblico e il privato: per un diritto dei beni comuni*. Verona, Ombre Corte.

■ Боловсрол ба мэдлэг бол дэлхий нийтийн баялаг мөн

Нийгмийн баялгийн тухай онолын хязгаарлагдмал шинж байдал

Нийгмийн баялгийн тухай онол нь олон жилийн түүхтэй бөгөөд зах зээлийн эдийн засагтай холбоотой үүссэн¹³⁸. 1950-иад онд нийгмийн баялгийг “хүн бүр тэрхүү баялгийг хамтран ашиглаж болох бөгөөд нэг хүн түүнийг ашигласнаар бусад хүмүүсийн ашиглах боломж хумигддаггүй” баялаг гэсэн утгаар тодорхойлсон¹³⁹. Эдийн засгийн

Нийтийн баялгийн тухай ойлголт бол хүний сайн сайхан аж амьдралыг нийгэм-эдийн засгийн индивидуалист онолоор томъёолсон нийгмийн баялагийн тухай үзэл баримтлалын хүрээнээс хальдаг.

мөн чанартай ойлголтыг боловсролын хүрээнд шилжүүлэн хэрэглэх нь тодорхой асуудлыг байнга дагуулдаг. Нийгмийн баялаг бол төрийн бодлоготой шууд хамааралтай гэж үздэг. Нийгмийн гэсэн нэр томъёо нь нийгмийн баялаг бол ард түмний бий болгосон баялаг гэсэн өргөн тархсан буруу ойлголтонд хүргэдэг¹⁴⁰. Нөгөө талаас, нийтийн баялгийг түүний гарал үүсэл нийгмийн ба хувийн байхаас үл хамааран хүний түгээмэл эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай, тодорхой зориулалттай баялаг гэж тодорхойлсон¹⁴¹. Энэ утгаараа “нийтийн баялаг”-ийн тухай ойлголт нь илүү тохиромжтой альтернатив хувилбар байж

болох юм. Нийтийн баялгийг “хүмүүс хамтран хэрэглэдэг, бие биедээ дамжуулж болдог тухайлбал, оюун санааны үнэт зүйлс, иргэний ариун ёс журам, шударга ёсны мэдрэмж зэрэг баялаг” гэж тодорхойлж болох юм¹⁴². Энэ нь “санаа бодол ижил хүмүүсийн холбоо бөгөөд хүн нэг бүрийн баялгийн нийлбэрээс илүү байдаг”. Энэ бол хамт олны гишүүн байхын баялаг, хүмүүсийн хоорондын харилцааны үр дүнд бий болдог, түүгээр дамжуулан хүмүүсийг сайн сайхан амьдралд хүргэдэг баялаг юм¹⁴³. Нийтийн баялаг бол хамтын зорилгоор нэгдсэн нийгмийн гишүүдийн хоорондын харилцааны үр дүнд бий болдог баялаг юм. Ийм баялаг нь түүнийг “бүтээх” болон түүнээс хүртэх талаасаа ч нийтийн байдаг¹⁴⁴. Тэгэхээр энэ төрлийн баялаг уг ёсоороо ‘үйлдвэрлэл’-ийнхээ хувьд ч, үр ашгийнхаа хувьд ч нийтийн байна. Энэ байр сууринаас үзвэл, нийтийн баялгийн тухай ойлголт “нийгмийн баялаг”-ийн тухай ойлголтын хүрээнээс наад зах нь дараах гурван зүйлээр давж гарч байна.

1. Нийтийн баялгийн тухай ойлголт бол хүний сайн сайхан аж амьдралыг нийгэм-эдийн засгийн индивидуалист онолоор томъёолсон нийгмийн баялагийн тухай үзэл баримтлалын хүрээнээс хальдаг. “Нийтийн баялаг”-ийн байр сууринаас авч үзвэл энэ нь зөвхөн хувь хүмүүсийн “сайн сайхан амьдрал” төдийгүй хүн төрөлхтний хамтын амьдралын сайн сайхны тухай асуудал юм¹⁴⁵. Энэ бол хувийн эсвэл явцуу баялаг байж болохгүй¹⁴⁶. Сүүлийн үед олон улсын яриа хэлэлцүүлэгт “боловсрол” гэхээс илүү “сурах” гэдэг ухагдахуун руу анхаарлаа шилжүүлж байгаа

142 Deneulin, S., and Townsend, N. 2007. Public Goods, Global Public Goods and the Common Good («Нийтийн баялаг, дэлхий нийтийн баялаг, нийт олны баялаг») *International Journal of Social Economics*, Vol. 34 (1-2), pp. 19-36.

143 Өмнөхийг үз

144 Дээрхийг үз

145 Deneulin and Townsend-ийн бүтээлийг үз

146 Holster, K. 2003. The Common Good and Public Education. *Educational Theory*, 53(3), 347-361.

147 Zhang, урьд дурдсан бүтээл

148 Deneulin, and Townsend-ийн бүтээлийг үз

явдал бол нийгмийн зорилт болохын хувьд боловсролын зорилго, түүний хамтын хүчин чармайлт болох тал дээр хангалттай анхаарал хандуулаагүйг тэмдэглэж байна. Боловсролоос нийгмийн хүлээж буй мэдрэгдэхүйц бодитой үр дүнгийн үүднээс болон боловсрол олгох боломжийг зохион байгуулах талаасаа ч дээрх байдал үнэний талтай. Боловсрол бол “нийтийн баялаг” гэсэн ойлголт нь түүний хамт олны шинж чанар, нийгмийн хамтарсан хүчин чармайлт (хамтын хариуцлага, харилцан хүлээсэн үүрэгтэй үнэнч байх) гэсэн утгаар батлагдаж байна.

2. Амьдралын сайн сайхны тухай ойлголт, нөхцөл байдлын олон талт байдлыг харгалзаж “нийтийн баялаг” гэсэн ойлголтын мөн чанарыг тодорхойлж болно. Тиймээс нийгмийн янз бүрийн бүлгүүд нийтийн баялагийн тухай орчин нөхцлийн талаар өөр өөр ойлголттой байдаг¹⁴⁷. Нийтийн баялагийн тухай соёлын ялгаатай тайлбаруудыг харгалзан, тэдгээр нь хүмүүсийн сайн сайхан амьдралыг аюулд хүргэхгүй байвал төрийн бодлогод эдгээр өөр өөр агуулга, үзэл бодол, мэдлэгийн системийг хүний түгээмэл эрхийг дээдлэх замаар хүлээн зөвшөөрч суулгаж өгөх хэрэгтэй.¹⁴⁸
3. “Нийтийн баялаг”-ийн тухай үзэл баримтлал өргөн олны оролцоонд тулгуурласан үйл ажиллагаанд онцгой анхаардаг бөгөөд энэ үйл явц нь өөрөө нийтийн баялаг юм. Хамтын үйл ажиллагаа бол нийтийн баялгийн салшгүй хэсэг, чухал шинж чанар бөгөөд түүний үр өгөөж нь хамтын үйл ажиллагаагаар бий болдог¹⁴⁹. Нийтийн баялаг болох утгаараа боловсрол нь төрийн бодлого боловсруулах, түүнийг хариуцлагатайгаар хэрэгжүүлэхэд бүхнийг хамруулахыг шаарддаг. Нийтийн баялгийг төрийн болон хувийн хэвшлийн дихотомоос цааш тавьснаар өргөн оролцоонд суурилсан ардчиллын шинэ хэлбэр, байгууллагуудыг бий болгохын төлөө тэмүүлэх, төлөвлөхийг шаардаж байна. Үүнийг хувьчлалын өнөөгийн бодлогоос гадуур төрийн удирдлагын уламжлалт хэлбэрүүд рүү буцахгүйгээр хийх хэрэгтэй¹⁵⁰.

Боловсрол, мэдлэгийг бүх нийтийн баялаг гэдгээр хүлээн зөвшөөрөх нь

Боловсрол бол мэдлэг эзэмших, тэр мэдлэгээ харгалзах нөхцөл байдалд хэрэглэх чадамжийг хөгжүүлэх үйл явц юм. Мэдлэгээ ашиглах, цаашид гүнзгийрүүлэх нь бидний амьдарч буй нийгмийн зарчимд нийцсэн боловсролын үндсэн зорилго юм. Хэрэв боловсролыг ухамсартай, зохион байгуулалттай сурах үйл ажиллагаа гэж үзвэл түүний тухай аливаа хэлэлцүүлэг зөвхөн мэдлэг эзэмших (баталгаажуулах) үйл ажиллагаанд төвлөрөх ёсгүй. Мэдлэгийг хэрхэн эзэмшиж, баталгаажуулж байгааг төдийгүй, түүний хүртээмж хэдий хирийн хяналтанд байна гэдгийг тооцох хэрэгтэй бөгөөд улмаар ямар арга замаар тэр мэдлэгийг олон нийтэд нээлттэй болгохыг авч үзэх ёстой.

18. Мэдлэгийг бүтээх, хянах, эзэмших, баталгаажуулах, хэрэглэх нь

Өргөн утгаар нь авч үзвэл мэдлэг бол мэдээлэл, ойлголт, ур чадвар, үнэт зүйл, зан үйл зэргийг хамруулна. Тодорхой орчин нөхцөл байдалд тэр мэдлэгийг хэрэглэх чадавхийг чадамж гэнэ. Боловсролын (эсвэл суралцах) тухай хэлэлцүүлгүүд дээр мэдлэг эзэмших, түүнийг хэрэглэх чадавх (чадамж)-ийг хөгжүүлэх

149 Deneulin and Townsend

150 Marella-ийн бүтээлийг үз

151 Kaul, I., le Goulven, K. et al. (eds) 1999. *Global Public Goods. International Cooperation in the 21st Century*, («Дэлхийн хэмжээний нийгмийн баялаг. XXI зуун дахь олон улсын хамтын ажиллагаа») New York, Oxford University Press.

152 Stiglitz, J. 1999. *Knowledge as a global public good*. («Мэдлэг бол дэлхий нийтийн нийгмийн баялаг») In Kaul, I., le Goulven K. et al. (eds), pp. 308-325. мөн UNDP. 1999. *Human Development Report*. (Хүний хөгжлийн илтгэл) New York, Oxford University Press.

тухай гол төлөв ярилцдаг. Боловсрол нь эзэмшсэн мэдлэгийг баталгаажуулах дээр ихээхэн анхаарал хандуулах болж байна.

Боловсрол ба мэдлэг бол бүх нийтийн баялаг байх ёстой. Мэдлэгийг бүтээх, түүнийг хянах, эзэмших, баталгаажуулах, ашиглах нь нийгмийн хамтын хүчин чармайлт гэдэг утгаар бүх хүмүүсийн хувьд нийтлэг байна гэсэн үг.

Гэсэн хэдий ч өнөөдрийн өөрчлөгдөж буй дэлхий дээр боловсрол, суралцах тухай яриа, хэлэлцүүлэг нь мэдлэгийг олж авах, баталгаажуулах, хэрэглэх үйл явцын хүрээгээр хязгаарлагдах ёсгүй. Мэдлэгийг бүтээх, хянах



тухай тулгуур асуудлуудыг энд бас хөндөх ёстой.

Эх сурвалж: Зохиогчид

Мэдлэг бол хүн төрөлхтний нийтлэг өв юм. Тиймээс мэдлэгийг боловсролын нэг адил бүх нийтийн баялаг гэж авч үзэх ёстой. Хэрэв мэдлэгийг зөвхөн нийгмийн баялаг¹⁵¹ гэж авч үзвэл, түүний хүртээмж нь ихэвчлэн хязгаарлагдмал байна¹⁵². Мэдлэгийг үйлдвэрлэх, нөхөн үйлдвэрлэх, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хувьчлах гэсэн өнөөгийн хандлага нь санаа зовниулж байна. Нийтлэг мэдлэгийг хуулиар дамжуулан, тухайлбал, мэдлэгийн үйлдвэрлэлийн салбарт голлох үүрэг гүйцэтгэж байдаг оюуны өмчийн эрхийг хамгаалах дэглэмээр дамжуулан аажмаар хувьчилж байна. Мэдлэгийн үйлдвэрлэл, нөхөн үйлдвэрлэлийг үе шаттай хувьчлах үйл явц их сургууль, судалгааны төв, зөвлөгөө өгөх компани, хэвлэлийн газруудын үйл ажиллагаан дээр илэрч байна. Үүний дүнд бидний ойлголтоор нийгмийн ач холбогдолтой гэж үздэг, нийтэд хүртээмжтэй мэдлэгт харьяалагдах ёстой гэж үздэг мэдлэгийн дийлэнх хэсэг үнэн хэрэгтээ хувийн эрх мэдэлд очсон байна. Ялангуяа экологи, эм эмчилгээний салбар дахь нутгийн уугуул ардын мэдлэгийг олон улсын корпорациуд завшиж өөрийн өмч болгон зарлаж байгаа нь сэтгэл зовохгүй байх аргагүй байдалд оруулж байна. Үүнтэй уялдан энэ хандлагын эсрэг нутгийн уугуул ард түмний дунд эсэргүүцэл гарах болж байна. Цахим орчинд мэдлэгийг чөлөөтэй солилцохын төлөө хөдөлгөөнүүд бий болгоход хүргэж байгаагийн нэг жишээ бол эх бүтээгдэхүүнийг ашиглах, хуулах, тараах, судлах, өөрчлөх, сайжруулах эрх чөлөөг хэрэглэгчиддээ олгодог Linux үйлдлийн систем юм¹⁵³.

Харилцан хамааралтай болж байгаа өнөөгийн дэлхий ертөнц дээр тогтвортой хөгжлийг хангах гол асуудлын талаас авч үзвэл боловсрол ба мэдлэг нь бүх нийтийн баялаг байх ёстой. Мэдлэгийг бүтээх, түүнийг хянах, эзэмших, баталгаажуулах, ашиглах нь нийгмийн хамтын хүчин чармайлт гэдэг утгаар бүх хүмүүсийн хувьд нийтлэг байна гэсэн үг. Боловсролын засаглал нь мэдлэгийн засаглалаас тусдаа ангид байж болохгүй болж байна.

153 www.linuxfoundation.org

154 «Сургалтын дүн нь хувь хүний эзэмшсэн мэдлэгийн түвшин, ур чадварь үнэт зүйлсийг хэлнэ. Энэ нь сурах үйл ажиллагаа явагдсныг баталгаа үзүүлэх шаардана.». Бүх нийтийн боловсролын асуудлаар болсон дэлхийн бага хурал, 1990 он. *Meeting Basic Learning Needs: A vision for the 1990s*. («Сурах үндсэн хэрэгцээг хангах нь: Ерээд оны үзэл баримтлал.»), лавлах материал, Нью-Йорк,

Тулгуур зарчмыг хамгаалах нь

Боловсролын талаарх өнөөгийн олон улсын яриа хэлэлцүүлэг нь боловсролын талаарх олон улсын ба үндэсний бодлого, практик удирдамж болсон тулгуур зарчмуудыг сулруулж болзошгүй аюултайг онцлох нь чухал юм. Үнэн хэрэгтээ, өнөөдөр боловсролын асуудлаар явагдаж байгаа хэлэлцүүлэг дээр сурах үйл ажиллагааны тухай ярихдаа боловсролын үйл ажиллагааны үр дүнд гол анхаарлаа хандуулж, сурах үйл явцыг орхигдуулах тал байна. Үр дүнд анхаарах гэдэг нь үндсэндээ *сургалтын дүн, амжилт*⁵⁴-ыг хэлж байгаа бөгөөд өөрөөр хэлбэл, хамгийн амархан хэмжиж болох мэдлэг, чадварыг хэлж байна. Үүний эцэст хувь хүн болон нийгэмд чухал ач холбогдолтой сурах үйл ажиллагааны өргөн хүрээтэй үр дүн болох мэдлэг чадвар, үнэт зүйл, зан үйлийг хэмжиж чадахгүй гэсэн ганц үндэслэлээр орхигдуулах хандлага байна. Түүнчлэн, сурах үйл ажиллагааг хувь хүний мэдлэг чадвар эзэмших үйл ажиллагаа гэж үзэж, боловсролын зорилго, *нийгмийн хамтын хүчин чармайлт* болох сурах боломжийг зохион байгуулахтай холбоотой асуудлуудад хангалттай анхаарал хандуулахгүй байна. Иймд дээр дурдсан яриа хэлэлцүүлгүүд нийтийн баялаг болох боловсролын тулгуур зарчмыг үл тоох аюулыг бий болгож байна.

Нийтийн баялгийг зохицуулах үүрэг, хариуцлага

Бидний нийтлэг хүмүүнлэг чанарыг илэрхийлэх нийгмийн шударга ёс, эв санааны нэгдлийн үнэт зүйлсэд тулгуурласан бүх нийтийн баялаг болох сурч боловсрох эрхийн үндсэн зарчмууд нь хүн, нийгмийн тогтвортой, хүртээмжтэй хөгжлийг хангах хамтын эрмэлзлэлийг хэрэгжүүлэхэд сонирхогч янз бүрийн талуудын үүрэг хариуцлагад тодорхой үр дагавар үзүүлнэ.

• Иргэний нийгэм ба бусад түншүүдийн үүргийг нэмэгдүүлэх нь

Өнөөгийн нөхцөл байдалд боловсролд иргэний нийгмийн үүргийг илүү бодитой болгох, дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь чухал ач холбогдолтой. Төрийн өмчийн боловсролыг арилжааны хэлбэрт оруулж байгаа хандлагын эсрэг олон нийтийн холбоод, ашгийн бус байгууллагуудтай хүчтэй түншлэлийн харилцаа тогтоож эсэргүүцэх хэрэгтэй. Үнэн хэрэгтээ боловсрол, түүний олон талт үйл ажиллагаа бол зөвхөн засгийн газрын үүрэг төдийгүй бүхэл бүтэн нийгмийн хариуцах ёстой зүйл юм. Боловсролын салбар дахь сайн засаглал бол засгийн газар-иргэний нийгэм гэсэн олон талт хамтын ажиллагааг шаарддаг бөгөөд үндэсний түвшин дэх боловсролын бодлого нь өргөн хүрээтэй нийгмийн зөвлөлдөөн, үндэсний зөвшилцлийн үр дүн байх ёстой.

Сүүлийн жилүүдэд аж ахуйн нэгж, сангуудын оролцоотой хөгжлийн асуудлыг санхүүжүүлэх шинэлэг арга замуудыг боловсролын салбарт туршиж байна. Энэ туршилт нь гадаад түншүүдийн туршлага, чадавх, нөөцийг ашиглах зорилгоор улс орнууд, хувийн сектор, иргэний нийгэм, шинжлэх ухааны байгууллага, иргэд зэрэг хөгжлийн салбарын бүх түншүүдийн дунд үр дүнтэй, шинэлэг түншлэлийн харилцаа өргөжихөд хувь нэмэр оруулсан юм. Нийгмийн баялаг гэж ойлгодог боловсролын салбарт ч өндөр үр дүнд хүргэсэн амжилттай түншлэлийн жишээ олон байдаг.

Хувийн бизнесүүд нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа хэрэгжүүлэх үүднээс өөрт шаардлагатай боловсон хүчний хэрэгцээнээс гадна боловсролд хөрөнгө оруулах замаар гол үүрэг гүйцэтгэж болно. Тухайлбал, Энэтхэг улсад хувийн компаниудыг жилийн эргэлтийнхээ 2%-тай тэнцэх хөрөнгө оруулалт боловсролд хийхийг төрөөс дэмждэг байна. Компаний нийгмийн хариуцлагын хөрөнгийг нийгмийн ядуу бүлгийнхний

нийгмийн болон боловсролын хэрэгцээнд ашиглаж болох юм. Ийм нэмэлт эх үүсвэрийг татахын тулд харгалзах компаниудад татварын урамшуулал олгодог хууль гаргах шаардлагатай байж болно.

- **Нийтийн баялгийн хүртээмжийн зохицуулалтын асуудалд төрийн үүргийг бэхжүүлэх нь**

Боловсрол бол тэнцүү боломж олгох гинжин холбоосны эхний гогцоо учраас боловсролын үйлчилгээг бүхэлд нь зах зээлийн харилцаанд шилжүүлэх ёсгүй.

Эдийн засгийн даяаршил, зах зээлийн либералчлалын өнөөгийн нөхцөлд нийтийн баялаг, ялангуяа боловсролын хүртээмжийг хангах, түүнийг зохицуулалтыг хариуцсан үүргээ хадгалж байх ёстой. Боловсрол бол тэнцүү боломж олгох гинжин холбоосны эхний гогцоо учраас боловсролын үйлчилгээг бүхэлд нь зах зээлийн харилцаанд

шилжүүлэх ёсгүй. Энэ байр сууринаас үзвэл, төр дараах хоёр үүрэгтэй:

1. Нийгмийн өмнө илүү хариуцлагатай болгох тодорхой журмыг ашиглаж боловсролын салбарын авилгатай тэмцэх, төрийн өмчийн боловсролын системийг мэргэжлийн хувьд бэхжүүлж, өөрчлөлт хийх.
2. Боловсролын салбарт хувийн хэвшлийг татан оролцуулах ажлыг хянах зохицуулах. Ийм хяналт бол захиргааны ба хүнд суртлын саад байж болохгүйн дээр цагдаагийн үүргийг биелүүлж бүр ч болохгүй. Төрийн зүгээс тавих хяналт нь төрийн болон хувийн өмчийн боловсролын байгууллагуудад ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн боловсруулж баталсан стандартын хэрэгжилт, түүнчлэн олон улсын норматив баримт бичгүүдийн заалтуудыг биелүүлэх явцыг хангахад оршино.

- **Бүх нийтийн баялагийн хүртээмжийн зохицуулалтад засгийн газар хоорондын байгууллагуудын үүргийг бэхжүүлэх нь**

Бүх нийтийн баялагийн засаглалын асуудал дээр олон улсын хамтын нийгэмлэг үүрэг хариуцлага хүлээдэг. Бүх нийтийн баялгийн засаглалын асуудал нь энэ чиглэлээр бодлого боловсруулах, практик асуудлуудыг шийдвэрлэх талаар хамтын ажиллагааг өргөжүүлэх үүрэгтэй НҮБ-ын систем ба бусад олон улсын байгууллагын үндсэн асуудал байдаг. НҮБ-ын бүрэлдэхүүн ба төрөлжсөн байгууллагууд нь техникийн шинжтэй үүрэгтэйгээс гадна мэдлэг, боловсрол, биет ба биет бус соёлын өв зэрэг бүх нийтийн баялгийн засаглалтай холбоотой харилцааг зохицуулах олон улсын хэм хэмжээг тогтоох үүрэг хүлээдэг. Үүнтэй уялдан ЮНЕСКО-оос гол зохицуулагч, оюун санааны тэтгэгчийн үүрэг гүйцэтгэж байгаа “Бүх нийтийн боловсрол” хөдөлгөөн, боловсролын салбарт норматив хэм хэмжээ тогтоох гэсэн хоёр том ажлыг тэмдэглэх хэрэгтэй¹⁵⁵.

■ Цаашдын алхмын талаарх эргэцүүлэл

Хүн, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах тэргүүн зэргийн зорилтын дор бэлтгэгдсэн энэхүү хэлэлцүүлэгт өнөөдөр дэлхийн хэмжээнд гарч буй нийгмийн өөрчлөлтийн чиг хандлага, төвөгтэй байдал ба зөрчил, түүнчлэн бидний өмнө нээгдэж буй шинэ

155 Bray, M. and Kwo, O. 2014. Regulating Private Tutoring for Public Good Policy Options for Supplementary Education in Asia. *CERC Monograph Series in Comparative and International Education and Development*, (Азид даван сургалтын талаар бодлогын арга хэмжээ боловсруулах зорилгоор хувиараа багшлах салбарын зохицуулалт хийж байгаа нь) No. 10. Comparative Education Research Center, University of Hong Kong.

мэдлэгийн цар хүрээг тоймлон харуулсан. Хүний сайн сайхан аж амьдралыг хангах асуудалд хандах альтернатив арга замуудыг судлах ач холбогдол, ертөнцийг үзэх үзэл ба мэдлэгийн системийн олон төрлийг судлах, хамгаалах шаардлагыг онцлон тэмдэглэсэн. Ёс зүйн болон ёс суртахууны шинэ зарчмыг үндэслэж боловсруулсан өвч нэгдмэл хандлагыг хэрэглэхийг чухалчилж байгаа боловсролын хүмүүнлэг хандлагыг энэ баримт бичигт дахин сануулж бататгасан. Тэгш бус байдлыг шинээр гаргахгүй байх, жинхэнэ хүртээмжтэй сурах үйл ажиллагаа, шударга, хариуцлагатай байдлыг хангасан үйл ажиллагаанд хүрэх замаар өөдлөн дэвших шаардлагыг тэмдэглэсэн. Энд өөрийн бодолгүй шууд хүлээн зөвшөөрөхийн оронд шүүмжлэлт сэтгэхүй, бие даан тунгаан бодох чадварыг хөхүүлэн дэмжихэд багш, сурган хүмүүжүүлэгчдийн үүрэг ач холбогдол чухал хэвээр байгааг онцлон тэмдэглэсэн.

Орчин үеийн нарийн түвэгтэй ертөнцөд боловсролын салбарын бодлогыг боловсруулахтай холбоотой асуудлыг энд авч үзсэн. Нэгдүгээрт, албан боловсрол ба хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээний хооронд оршиж байгаа зөрүүтэй байдлыг бид хүлээн зөвшөөрч, хариу арга хэмжээ авах шаардлагатай. Хоёрдугаарт, дэлхий дээр ажиглагдаж байгаа хил хязгаар, ажил мэргэжил, сурах орон зайн хувьд өсөн нэмэгдэж буй шилжилт хөдөлгөөн бүхий өнөөгийн нөхцөлд мэдлэгийн түвшинг хүлээн зөвшөөрч, баталгаажуулах асуудлыг шийдэх явдал чухал болж байна. Гуравдугаарт, олон ургальч байдлыг хүндэтгэхийн хамт нийтлэг үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрөх, хүн төрөлхтний нийтлэг ирээдүйн тухай санаа тавих зэргийг агуулсан иргэний үзэл санаагаар хүмүүжүүлэх үзэл баримтлалыг эргэж шинээр харах шаардлагатай. Эцэст нь, боловсролын салбарын үндэсний бодлого боловсруулах, боловсролын дэлхийн хэмжээний засаглалын ирээдүйтэй хэлбэрүүдтэй уялдаатай асуудлуудыг авч үзэх шаардлагын тухай өгүүлсэн. Энэ номонд авч үзсэн олон асуудлууд одоо хүртэл тодорхой хариултгүй байна.

Боловсролын удирдлагын суурь зарчмууд, тухайлбал, сурч боловсрох эрх, боловсролыг нийгмийн баялаг гэж үзэх зарчмыг дахин авч үзэж боловсруулах шаардлага байна.

Номонд дурдсан хэлэлцүүлэгт боловсролын удирдлагын суурь зарчмууд, тухайлбал, сурч боловсрох эрх, боловсролыг нийгмийн баялаг гэж үзэх зарчмыг дахин авч үзэж боловсруулах шаардлагын тухай тодорхой судалсан. Мөн боловсролын бодлого боловсруулахдаа мэдлэг, түүнийг бүтээх, олж авах, батлах, хэрэглэх арга замуудын талаар нухацтай авч үзэж, анхаарахыг тэмдэглэсэн байна. Түүнээс гадна, боловсрол, мэдлэгийг бүх нийтийн баялаг гэдэг талаас нь авч үзэх нь боловсролын зорилго, сурах үйл ажиллагааг өөрчлөгдөж байгаа өнөөгийн нөхцөлд нийгмийн хамтын үйл ажиллагаа гэдэг үүднээс нь зохион байгуулах асуудлыг зөвшилцөхөд тустай байж болох талаар дурдсан байна.

Цаашдын алхмыг тодорхойлох зорилгоор яриа хэлэлцүүлгийн урилга болгон дараах хэд хэдэн асуудлыг хойшдын хэлэлцүүлэгт зориулан санал болгож байна. Үүнд:

Мэдэхийн тулд суралцах, хийж чадахын тулд суралцах, хүн болохын тулд суралцах, хамт амьдрахад суралцах гэсэн суралцах үйл ажиллагааны дөрвөн

156 Elfert, M. 2015. UNESCO, the Faure Report, the Delors Report, and the Political Utopia of Lifelong Learning. («ЮНЕСКО, Форийн илтгэл, Делорын илтгэл ба насан туршийн боловсролын улс төрийн хоосон санаа») European Journal of Education. 50.1, pp.88-100

тулгуур зарчим өнөөдөр ч гэсэн ач холбогдолтой байгаа хэдий ч даяаршил болон үндэс угсааны асуудлаас үүдэлтэй улс төрийн үйл ажиллагаа сэргэснээр тэдгээрийг амьдрал дээр хэрэгжүүлэх асуудал эргэлзээнд орж байна. Эдгээр зарчмуудыг хэрхэн бэхжүүлж, хэрэгжүүлж болох вэ?

Эдийн засаг, нийгэм, экологийн тогтвортой байдлыг хангахад боловсрол хэрхэн үр дүнтэй нөлөөлж чадах вэ? Боловсролын салбарт бодлого хэрэгжүүлж, практик арга хэмжээ авах замаар хүмүүнлэг хандлагыг амьдралд хэрхэн нэвтрүүлэх вэ?

Боловсролд хүмүүнлэгийн үүднээс хандах замаар ертөнцийг үзэх олон ургальч үзлийг хэрхэн эвсэлдүүлэн зохицуулах вэ? Боловсролын үндэсний бодлого ба шийдвэр гаргалтанд даяаршил ямар аюул учруулж, ямар боломжууд олгож байна вэ?

Боловсролыг хэрхэн санхүүжүүлэх вэ? Багш бэлтгэх, давтан бэлтгэх, хөгжүүлэх, дэмжихэд энэ нь ямар үр нөлөөтэй вэ? Хувийн баялаг, нийгмийн баялаг, нийтийн баялгийн тухай үзэл баримтлалуудын хоорондын ялгаа боловсролд яаж тусах вэ?

**Бодлогын
удирдамжийн
хэм хэмжээ,
зарчмуудыг
тодорхойлохын
тулд олон талын
байр суурьтай олон
янзын оролцогч
талуудын хүч
чармайлтыг нэгтгэх
хэрэгтэй.**

Боловсролын асуудал хариуцсан НҮБ-ын төрөлжсөн байгууллага болох ЮНЕСКО нь шинжлэх ухаан, соёл, мэдээлэл холбооны холбогдох хүрээний асуудлуудын хамт дэлхийн хөгжлийн чиг хандлага, түүний суралцах үйл ажиллагаанд үзүүлэх үр дагаврыг хянан шинжилж, “шинэ санааны цөм- лаборатори” байх үүргээ бэхжүүлэх хэрэгтэй. Энэ нь ЮНЕСКО-гийн боловсролын талаар хүлээсэн үүрэг, бүрэн эрх, түүний оюуны агентлаг, шинжээчдийн төв байх үүрэгтэй нягт уялдаж байна¹⁵⁶. Өнөөдөр бусдаас тусдаа салангид байж үр дүнтэй бодлого боловсруулах тухай ярих боломжгүй бөгөөд судалгааны үр дүн харилцан солилцох, бодлогын удирдамжийн хэм хэмжээ, зарчмуудыг тодорхойлохын тулд олон талын байр суурьтай олон янзын оролцогч талуудын хүч чармайлтыг нэгтгэх хэрэгтэй.

Түүнчлэн ЮНЕСКО бол үндэсний комисс, ЮНЕСКО-ийн тэнхим, мэргэжлийн хүрээлэн зэрэг дэлхий нийтийн сүлжээтэй НҮБ-ын систем дэх цорын ганц байгууллага гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Эдгээр сүлжээг өөрчлөгдөж буй нөхцөл байдал, хэрэгцээг харгалзан боловсролын зорилгыг дахин эргэж харах, тэдгээрийн хэрэгжилтэд тогтмол үнэлгээ хийх хэрэгсэл болгон илүү эрчимтэй ашиглаж болох юм. Энэ асуудлыг хөгжлийн чиг хандлага, түүний боловсролд үзүүлэх үр нөлөөний талаар мэдээлэл, шинжилгээ дүгнэлт хийдэг байнгын ажиглалтын механизмыг бий болгох замаар шийдэх ёстой.

Хүн төрөлхтөн шинжлэх ухаан, технологийн илүү хурдац бүхий хөгжлийн шинэ үе шатандаа ороод байна. Энэ хөгжил нь урд өмнө байгаагүй цоо шинэ боломж, түүний зэрэгцээ утопи шинжтэй байх боломжтой. Хүн төрөлхтний тогтвортой хөгжил, шударга ёсыг бэхжүүлэхийн тулд энэ боломж, эрсдлүүдийг ойлгож, түүнийг удирдаж чадах хэрэгтэй юм. Үүнийг амьдралд хэрэгжүүлэх явдал бол хорин нэгдүгээр зууны боловсрол, сургалтын үндсэн зорилго байх ёстой. Хүний сайн сайхан байдлыг дэмжих зорилгоор ийм боломжуудыг таньж мэдэх явдал бол “шинэ санааны цөм-лаборатори” болох ЮНЕСКО-ийн үндсэн зорилго байх ёстой. Энэхүү ном нь эдгээр асуудлуудыг цаашид өргөн хүрээнд хэлэлцүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой юм.

Бид нарийн төвөгтэй, зөрчил тэмцэлтэй, байнга өөрчлөгдөж байгаа ертөнцөд амьдарч байна. Материаллаг баялгийн үйлдвэрлэл, эдийн засгийн өсөлтийн дүнд дэлхий дээр ядуурлын цар хүрээг бууруулж чадсан хэдий ч эрх тэгш биш байдал, хүчирхийлэл, тусгаарлал, эмзэг байдал дэлхий дахинаа өсөж байна. Үйлдвэрлэл, хэрэглээний эдийн засгийн тогтвортой бус загварыг хэрэглэснээр дэлхийн дулааралд хүргэж, хүрээлэн буй орчны байдлыг доройтолд хүргэж, байгалийн гамшиг ихээхэн нэмэгдэхэд хүргэж байна. Сүүлийн арваад жилд хүний эрхийн чиглэлээр олон улсын эрх зүйн үндсийг бэхжүүлсэн хэдий ч баталж хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх асуудал шийдэгдээгүй байна. Технологийн дэвшил хоорондын хамаарлыг нэмэгдүүлж, хамтран ажиллах, харилцан солилцох, эв нэгдлээ илэрхийлэх өргөн боломжийг нээж өгч байна. Түүний зэрэгцээ соёл, шашны үзлээр гадуурхах, үндэс угсаанаас улбаатай улс төрийн хөдөлгөөн газар авч, мөргөлдөөн нэмэгдэх зэргийг бид харж байна. Эдгээр өөрчлөлтүүд нь суралцахуйн чиглэлээр боловсролд гүнзгий нөлөө үзүүлэх цоо шинэ нөхцөл бий болсныг илэрхийлж байна. Боловсролын зорилго, сургалтын зохион байгуулалтыг эргэж тунгаан бодох асуудал урд өмнө ийм хурцаар тавигдаж байгаагүй юм. Энэ ном бол харилцан ярианд дуудсан уриа юм. Боловсролыг хүмүүнлэгийн үүднээс үзэх, хүний нэр төр, амь нас, тэгш эрх, нийгмийн шударга ёс, соёлын олон талт байдал, олон улсын эв санааны нэгдэл, ирээдүйн тогтвортой хөгжлийн төлөө хүлээх хамтын хариуцлага зэргийг дээдлэн хүндэтгэх үндсэн дээр хөгжих үзэл санааны үндсэн дээр энэ ном бэлтгэгдсэн юм. Өнөөгийн ээдрээтэй дэлхий дээр нийгмийн хамтын хүч чармайлтын үндсэн дээр боловсролын системийн зорилго, зохион байгуулалтын бүтцийг зөвшилцөх зорилгоор боловсрол мэдлэгийг бүх нийтийн баялаг гэж үзэхийг санал болгож байна.



ШУТИС ХЭВЛЭЛИЙН ГАЗАР

